



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, МЯГМАР ГАРАГ**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1-2
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3-25
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	26-127
<b>1. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	32-45
<b>2. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	45-59
<b>3. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>	59-76
<b>4. Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	76-78
<b>5. Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	78-79
<b>6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	79-81
<b>7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	81-86
<b>8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</b>	86-88
<b>9. “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</b>	88-91

<b>10. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	<b>91-95</b>
<b>11. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	<b>95-98</b>
<b>12. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	<b>98-101</b>
<b>13. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	<b>101-102</b>
<b>14. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэх судлах сонсголын тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>	<b>102-127</b>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 16 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

*Томилолттой: П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Д.Ганбат, Г.Ганболд, Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Ц.Идэрбат, Б.Саранчимэг, Ц.Туваан;*

*Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Оюун-Эрдэнэ,*

*Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд;*

*Хоцорсон: Ш.Адъяаа-02 минут, С.Амарсайхан-23 минут, Ж.Батсуурь-01 минут, Б.Баярсайхан-09 минут, Т.Доржханд-18 минут, Б.Дэлгэрсайхан-15 минут, Л.Мөнхбаатар-16 минут, Д.Өнөрболор-36 минут, Ж.Сүхбаатар-20 минут, Б.Энх-Амгалан-36 минут, Б.Энхбаяр-12 минут.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж, Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж, Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

***Нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлагч Ч.Ариунхур нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Баярсайхан, Б.Баттөмөр, Н.Наранбаатар, Т.Доржханд нарын тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 01 минутаас 15 цаг 06 минутад хуралдааныг даргалав.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 23  
Бүгд: 51  
54.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын газрын дарга О.Номинчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын тасгийн дарга Л.Эрдэнэбадрах, Нийслэлийн Орон сууцны корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ш.Адьяа, Б.Баттөмөр, Ч.Хүрэлбаатар, Т.Доржханд нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын газрын дарга О.Номинчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар, Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38  
Татгалзсан: 12  
Бүгд: 50  
76.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын референт Д.Нямдэлгэр, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрэлээ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Х.Мөнхжаргал, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн хорооны Хуулийн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Төгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Одонтуяа, Г.Дамдинням, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл, Ч.Ундрам, Т.Энхтүвшин, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 16 цаг 40 минутаас хуралдааныг даргалав.*

*““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав*

**Л.Мөнхбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, М.Оюунчимэг, Ч.Ундрам, Т.Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын нийт иргэдэд адил тэнцүү хэмжээгээр эзэмшүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 15

Бүгд: 43

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 1072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 11

Бүгд: 45

75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр олгосон “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг тус компанийн энгийн хувьцаанд бүртгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14

Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/”Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, “Эрдэнэс Монгол” нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр, авлагад суутган тооцох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 13

Бүгд: 44

70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 17 цаг 23 минутаас хуралдааныг даргалав.*

**Г.Занданшатар:** 5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 13  
Бүгд: 44  
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Итгэлт, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 22  
Бүгд: 44



50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хулын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 22

Бүгд: 46

52.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 21

Бүгд: 46

54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 19  
Бүгд: 46  
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, мөн шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1. Байнгын хорооны саналаар, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн Тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11, 12 дахь хэсэг болгох:

“11. Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 18  
Бүгд: 46  
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар, Төслийн 2 дугаар зүйлийн “6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “19.14/Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/,” гэсний дараа “19.18/Ард нийтийн санал асуулга хууль бусаар явуулах/,” гэж, 20.2/Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/,” гэсний дараа “20.19 /Улсын онц чухал объект, онц чухал мэдээллийн дэд бүтцийн байгууллага, байгууламжийн үйл ажиллагаанд саад учруулах/, гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 17  
Бүгд: 46  
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 17  
Бүгд: 46  
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах, Н.Баасанжав, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга Ч.Оюунцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч М.Оюунчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 17 цаг 51 минутаас хуралдааныг даргалав.*

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

### **Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

**“1 дүгээр зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар<sup>1</sup> бүлэг нэмсүгэй:

### **“ДОЛДУГААР<sup>1</sup> БҮЛЭГ Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа**

#### **75<sup>1</sup> дүгээр зүйл.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг**

75<sup>1</sup>.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75<sup>1</sup>.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75<sup>1</sup>.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75<sup>1</sup>.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75<sup>1</sup>.2.Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75<sup>1</sup>.2.2.энэ хуулийн 75<sup>1</sup>.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75<sup>1</sup>.2.3.ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75<sup>1</sup>.3.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75<sup>1</sup>.4.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75<sup>1</sup>.5.Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

### **75<sup>2</sup> дугаар зүйл.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа**

75<sup>2</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.2.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75<sup>2</sup>.3.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.4.Энэ хуулийн 75<sup>2</sup>.3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

### **75<sup>3</sup> дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах**

75<sup>3</sup>.1.Шүүгч энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75<sup>3</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup> дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75<sup>4</sup>.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75<sup>3</sup>.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

### **75<sup>4</sup> дүгээр зүйл.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх**

75<sup>4</sup>.1.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн

этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75<sup>4</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup>.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75<sup>4</sup>.3.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75<sup>4</sup>.4.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2, 75<sup>4</sup>.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

#### **75<sup>5</sup> дугаар зүйл.Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох**

75<sup>5</sup>.1.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75<sup>5</sup>.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75<sup>5</sup>.3.Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75<sup>5</sup>.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75<sup>5</sup>.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75<sup>5</sup>.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

#### **75<sup>6</sup> дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг**

75<sup>6</sup>.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.2. Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.3. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75<sup>6</sup>.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

### **75<sup>7</sup> дугаар зүйл. Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх**

75<sup>7</sup>.1. Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75<sup>7</sup>.1.1. нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75<sup>7</sup>.1.2. тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75<sup>7</sup>.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75<sup>7</sup>.3. Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75<sup>7</sup>.4. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

### **75<sup>8</sup> дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх**

75<sup>8</sup>.1. Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

### **75<sup>9</sup> дүгээр зүйл. Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр**

75<sup>9</sup>.1. Энэ хуулийн 75<sup>7</sup>.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75<sup>1</sup>.1, 75<sup>1</sup>.2-т заасан хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75<sup>9</sup>.2. Энэ хуулийн 75<sup>9</sup>.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75<sup>9</sup>.3. Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 119 дүгээр зүйлд заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75<sup>9</sup>.4. Энэ хуулийн 75<sup>9</sup>.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

### **75<sup>10</sup> дугаар зүйл. Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох,**

### хуваарь гарган хэсэгчлэн төлөх

75<sup>10</sup>.1.Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлшгүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

### 75<sup>11</sup> дүгээр зүйл.Давж заалдах гомдол гаргах

75<sup>11</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75<sup>9</sup>.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75<sup>11</sup>.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, мөн шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг нар оролцов.



Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	19
Бүгд:	42

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

**Ес. “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, мөн шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

**Арав.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав, баглаа боодлын асуудал хариуцсан хэлтсийн ахлах шинжээч Д.Тунгалаг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн профессор Н.Отгонсайхан, Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр хариулж, тайлбар хийв.

**1.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн талаар:**

**Л.Мөнхбаатар:** 1.Байнгын хорооны саналаар Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн органик бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн санд илгээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 16  
Бүгд: 42  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашигласан тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 16  
Бүгд: 42  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5.10<sup>1</sup>.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 4.1.2-т заасан органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний 5 жилд 100 хувиар, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 17  
Бүгд: 42  
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.*

**Арван нэг. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын референт О.Дөлгөөнтуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

*“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Мөнхбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “арга хэмжээ авах” гэснийг “талаарх бодлогыг боловсруулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 19  
Бүгд: 40  
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “шаардлагатай бол” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 20  
Бүгд: 40  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 19  
Бүгд: 40  
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 20  
Бүгд: 40  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг 18 цаг 54 минутаас 19 цаг 22 минутад хаалттай горимоор хэлэлцэв.*

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 19 цаг 22 минутаас хуралдааныг даргалав.*

**Арван хоёр.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлагч Ч.Ариунхур нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

*Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.5.21 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.5.21.нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн” гэсний дараа “8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хуульд заасан тусгай хувцас” гэсний дараа “болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас” гэж” нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 13  
Бүгд: 40  
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг

алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 19 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван гурав.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын газрын дарга О.Номинчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын тасгийн дарга Л.Эрдэнэбадрах, Нийслэлийн Орон сууцны корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

### **Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**1.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1</sup> дэх хэсгийн “дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно.” гэсний дараа “Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно.” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 14  
Бүгд: 40  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

## **2.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “арга хэмжээг” гэснийг “арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1</sup>, 28<sup>1.3</sup>-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг” гэж өөрчлөх гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ тогтоолыг Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 11  
Бүгд: 39  
71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 19 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

*Арван дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэх судлах сонсголын тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл*



Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Х.Мөнхжаргал, Хянан шалгагч Ч.Анхбаяр, Ж.Батцэнгэл, И.Уянга, Ч.Ням-Оюун, Б.Хишигтогтох, Шинжээч О.Лхагвадорж, О.Мөнхбат, Г.Жавхлан, Э.Болормаа, С.Энхзориг, Б.Ариун, Ч.Баярмаа, Б.Сугармаа, Б.Сүнжидмөнх, Ш.Ариунболд, Б.Батдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэх судлах сонсголын тайланг Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Өнөрболор, М.Оюунчимэг, С.Одонтуяа, Б.Баттөмөр, Ш.Адьшаа, Н.Учрал, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.8-д заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог татан буугдсанд тооцов.

**Г.Занданшатар:** “Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 21 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн нээлттэй хуралдаанаар 14 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт,

мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 6 цаг 29 минут үргэлжилж, 73 гишүүнээс 56 гишүүн хүрэлцэн ирж, 76.7 хувийн ирцтэйгээр 21 цаг 17 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 16 минут

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Өглөөний амгаланг айлтгая. Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

2.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

3-д, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл

4-д, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

5-д, Иргэний нисэхийн тухай хууль

6-д, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулна

7-д, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

8-д, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

9-д, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг

10-д, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг

11.“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг

12.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг

13.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг

14.“Зэвсэгт хүчний зэвсэг техникийг шинэчлэх сэргээн сайжруулах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг

15.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит

чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий хяналт шалгалтын түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэхээр саналаа ирүүлсэн Ширнэнбандийн Адьшаа, Бөхчулууны Пүрэвдорж, Жадамбын Бат-Эрдэнэ, Одонгийн Цогтгэрэл нараас албан бичгүүд ирүүлсэн байна.

Ингээд Ширнэнбандийн Адьшаа гишүүн Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 16-ны чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэгдэх асуудалтай холбогдуулан үг хэлэх саналаа үгээр хүргүүлж байна гэсэн байна.

Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар “Эрдэнэс Тавантолгой”-н 1072 хувьцааны талаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлээд, одоо хэлэлцэх гэж байна. Миний бие Монгол Улсын Их Хурлын гишүүнийхээ хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд иргэдээс худалдаж авсан 1072 хувьцааг буцаан олгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн бариад жил гаруй болж байгаа. Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцээд ингээд 54 дэх хоног дээрээ явж байна л даа. Энэ яагаад энэ Улсын Их Хурлаар үүнийг орж хэлэлцүүлж болохгүй байгаа юм бол? Засгийн газар сүүлд хэдхэн хоногийн өмнө л өргөн барьсан юм ингээд л цахилгаан шатаар явдаг, цөөнхийн бүлгийн яг үүнтэй адилхан үзэл баримтлалтай ийм хууль, тогтоолын төсөл өргөхөөр энэ Улсын Их Хурал дээр гацаад байна. Та бүгдээс би хүсэж байна. Тэр иргэдээс авсан сая гаруй иргэнийхээ 1072 хувьцааг буцаан олуулах тухай асуудлыг хэлэлцэж өгмөөр

байна. Юу нь болохгүй байгаа юм? Сөрөг хүчний гишүүн өргөн барихаар хэлэлцдэггүй, эрх баригчдын Засгийн газар өргөн барихаар нэн даруй хэлэлцдэг ийм юм байж болохгүй шүү дээ. Парламентын засаглал чинь хамтын шийдвэр гаргадаг, олонх цөөнхийнхөө гаргасан саналыг хэлэлцэж олонхоороо шийддэг ийм парламентын засаглалын хэлбэрээр бид 30 гаруй жил явсан. Юунаас айгаад байна та нар. Ард түмнийхээ мэдээлэлгүй, хөрөнгө мөнгөний дутагдалтай байдлыг далимдуулж, 12, 16 оны сонгуулийн өмнө тухайн үед эрх барьж байсан улс төрийн хүчин иргэдийнхээ хувьцааг сонгууль өгөх зорилгоор хулгайлж авсан. Үүнийгээ засъя л даа. Үүнийг үнэгүй авах гээгүй шүү дээ. Ноогдол ашгаас суутгаад, бүх иргэнээ өмч хөрөнгөтэй л болгоё гэсэн. Өнөөдөр ноогдол ашиг Эрдэнэс Тавантолгойн мэдээллээр 1 хувьцаанд 500 гаруй мянган төгрөг байгаа тухай мэдээлэл энд хэвлэл мэдээлэл гарч байна.

Гэтэл энэ сая гаруй иргэнийхээ хувьцааг нь ноогдол ашгаас нь суутгах зарчмаар өгчихье л дөө. Яагаад болохгүй байгаа юм. Юунаас айгаад байна та нар. Сөрөг хүчний гишүүн өргөн барихаар болохгүй байгаа юм уу. Нэг бол ард түмнээ өмч хөрөнгөтэй байхын эсрэг ийм бодолтой хүн байхгүй байх гэж бодож байна. Байхгүй байх гэж бодож байна. Үүнийг оруулаад нэг санал хураалт явуулж өгөхийг би Улсын Их Хурлын даргаас дахин хүсэж байна. Энэ Улсын Их Хурлын даргын зөвлөлийн гишүүдээс хүсэж байна. Монгол ардын намын бүлгийн дарга Тогтохсүрэнгээс хүсэж байна. Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэлээс хүсэж байна. Би энэ сая гаруй иргэнийхээ авсан хувьцааг нь ноогдол ашгаас нь буцааж өгөх зар зарчмаар ингээд өгөх энэ асуудлыг хэлэлцээд, санал хураалтаараа шийдээд өгмөөр байна Тогтохсүрэн даргаа. Тийм, тэгээд өгөхгүй нь сонин биш байна. Энэ хууль санаачлах, энэ хууль дээдлэх зарчим, энэ хуулийн асуудлаа л энэ шийдээд өгчихмөөр байна. Би заавал та

бүгдийг дэмж гээгүй шүү дээ. Ард түмнээ өмч хөрөнгөтэй байлгахын эсрэг хэн санал өгөхийг л харах гэж байгаа юм. Энэ буруу юм ерөөсөө байхгүй. Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдээгүй асуудал үнэн. Тэгэхдээ энэ чуулганаар үүнийг хэлэлцэж өгөхийг би дахин хүсэж байна. Өнөө Эрдэнэс Тавантолгойн 1072 хувьцааны асуудлыг энэ Засгийн газар чинь түрүүчийн 7 хоногт өргөн барьсан юм шүү дээ. Одоо шууд гэрлийн хурдаар явж байна шүү дээ. Сөрөг хүчнийхээ нэг муу гишүүнийхээ өргөн барьсан юмыг хэлэлцэхээр яагаад болохгүй байгаа юм.

Хоёрдугаарт нь тэр сая гаруй иргэнийхээ өмч хөрөнгөтэй байхын эсрэг тийм бодолтой хүн байна уу, байхгүй байна уу гэж би харах гэсэн юм. Та нар шийдэхгүй байх л даа. Тэгэхдээ өнөөдөр ийм зарчим Монголын төр өнөөдөр сонгууль өгөхийн өмнө төрийн өмч хөрөнгөө санал өгөх зорилгоор ийм үйл ажиллагаа явуулдаг явдлыг бид дүгнэлт хийж энэдээ засах ёстой л гэж бодож байгаа. Энэ асуудлыг хэлэлцүүлж өгөхийг би Улсын Их Хурлын гишүүний хувьд дахин хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа Их Хурлын даргаа.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Нийгмийн даатгалын багц хуультай хамтатгаад 3 жилийн турш тэмцэж батлуулсан 7 жилийг 5 жил болгох тухай Нөхөн бодох тухай хуулийн төслийг баталсан. 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлж байгаа. Гэвч харамсалтай нь хэрэгжилт дээр Засгийн газар 63 дугаар тогтоолоор энэ 263 дугаар тогтоолоор энэ хуулийг гууль болгосон ийм шийдвэрийг гаргасан байна.

Өөрөөр хэлбэл 7 сарын 1-нд тэтгэвэр нэмэхдээ тэтгэврийг итгэлцүүрийн хүрээнд тэтгэврийг нэмсэн. Яг үүн дээр ямарваа нэгэн асуудалгүй бүх ахмадууд тодорхой хувиар тэтгэвэр нь нэмэгдээд энэ дээр

ямарваа нэгэн гомдол гараагүй. Гэтэл энэ 7 жилийг 5 жил болгуулах энэ хууль дээр урьд өмнө олон жилийн янз янзын будилаантай асуудлыг яг миний энэ хууль дээр оруулж шийдвэрлэх маягаар асуудалд хандсан нь зарим хүмүүсийн тэтгэврийг нэмэгдүүлэх боломжгүй, 1000 төгрөгөөр, 5000 төгрөгөөр зарим хүмүүсийнх нь буурчихсан байгаа шүү дээ. Яахлаараа буурдаг юм би ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Таны тэтгэвэр буурч байна гэж байгаа юм. Жишээ нь 2019 онд тэтгэвэрт гарсан хүн 2019 оны цалин 2012 оны цалин хамаагүй зөрүүтэй байгаа шүү дээ.

Гэтэл үүнийг ингээд ийм хэрэгжилт дээр нь будилуулсан ийм нөхцөл байдал маш их харагдаж байна. Дээрээс нь Булгантуяа сайдыг Их Хурлын дарга тодорхой мэдээлэл хий гэсэн. Тэгээд яг тэр өнгөрсөн нэг дэх өдөр мэдээлэл хийсэн. Харамсалтай нь ямар ч тийм энэ асуудлыг огт буруугаар нь тайлбарласан ийм мэдэгдлийг хийсэн. Тэгээд энэ дээр бол янз янзын асуудлууд байна. Жишээ нь 2019 онд тэтгэвэрт гарсан хүн 2020 оны 10 хувийн нэмэгдэл, 2022 оны 15 хувийн нэмэгдэл, энэ бүх нэмэгдлүүд, тэтгэврийн нэмэгдлүүд огт нэмэгдээгүй. Зөвхөн 2023 оны 7 сарын 1-ний нэмэгдэл нэмэгдсэн байх жишээтэй. Үүнээс болоод ард иргэдийн ахмадуудын тэтгэвэр нэмэгдээгүй ийм нөхцөл байдал гараад байна.

Ер нь 2024 оны улсын төсвийг хэлэлцэж байх үед Сангийн сайд надад хэлж байсан. Пүрэвдорж оо чиний хуулийн хүрээнд 140 тэрбум төгрөг энэ 2024 оны төсөв дээр тусгагдах нь гэж ярьж байсан. Гэвч харамсалтай нь 2024 оны төсөв дээр яг 20.6 тэрбум төгрөг болоод ороод ирсэн байж байгаа. Тэгэхээр энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл тэр Засгийн газар хэрэгжилтээрээ тэр Засгийн газрын тогтоол дээрээ энэ Пүрэвдоржийн хуулиар иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэхгүй байх тэр гол зүйлүүдийг бүгдийг нь хийсэн байна л гэж би хараад хараад байгаа. Тийм

учраас энд энэ тал дээр би бас дахиад тодорхой хэмжээний арга хэмжээ авах талаар ялангуяа тэр Засгийн газрын тогтоолыг зөв болгох. Яг тэр энэ чинь ганцхан л асуудал байгаа шүү дээ. Нөхөн бодох тухай хууль дээр чинь энэ бүх 2020 он, 22 оны тэтгэврийн нэмэгдлүүдийг нэмнэ, 23 оны тэтгэврийн нэмэгдлийг нэмнэ, дээрээс нь 7 жилээр бодуулж байсан бол 5 жил болгоод л 45 хувиар бодох ер нь голцуу 45-аар бодож байгаа. 45 хувиар бодох тэр асуудлыг л шийдэх юм шүү дээ.

Гэтэл энэ хэрэгжилт дээрээ ингээж будилуулж нэг программ зохиосон. Тэр программаар бүх хүний асуудлыг шийдэх боломж байхгүй шүү дээ. Хүмүүс харилцан адилгүй цалин авч байгаа, харилцан адилгүй тэтгэврээ тогтоолгож байгаа тэр бүх хүмүүсийн тэтгэврийг нэгхэн программаар бодож ингээж хүмүүсийг хохирооно гэдэг бол үнэхээр хариуцлагагүй зүйл.

Ерөөсөө нэг зүйлийг л ерөөсөө ойлгохгүй байгаа. Тэтгэвэр, таны тэтгэвэр энэ программын дагуу буурч байна гэдэг чинь ямар учиртай ийм хариулт вэ гэдэг дээр ерөөсөө гайхаад байгаа юм. Тэгэхээр энэ программ дээр асуудал байна. Тийм учраас манай ахмадууд ер нь бол энэ асуудал дээр нэлээн тайван байж бай. Ялангуяа Монгол Улсын өнцөг булан бүрд сууж байгаа, тэр ажиллаж байгаа нийгмийн даатгалын байцаагч нар бол нэг л программын дагуу та нарын дээрээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу, Засгийн газрын тогтоолын дагуу яамнаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу л асуудалд хандаж байгаа. Тийм учраас тэр программыг зөв болгох тал дээр ойрын үед бас дахиж ярилцаж, яг энэ асуудал дээр тодорхой зөв шийдлүүдийг гаргахын төлөө ажиллах болно гэдгийг хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Жадамбын Бат-Эрдэн гишүүн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жил гарны өмнө 2022 оны 12 сард Уул уурхайн биржийн тухай хууль батлагдсан. Миний бие ажлын хэсгийг ахалж, энэ Тэмүүлэн, Баттөмөр гишүүдийг ингээд оролцоод энэ хуулийг баталсан. Энэ зүгээр ч нэг хууль баталчхаагүй. Монгол Улсын төсөвт сүүлийн үед 1.8, 2 их наяд орчим төгрөгийн орлого оруулсан ийм хууль байгаа. Тэгээд энэ хуулийг дагаад бид нар Улсын Их Хурлын тогтоол баталсан. Энэ тогтоол дээр юу заасан бэ гэхээр нэгдүгээрт “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн иргэдэд ноогдох 1072 хувьцааг эргэлтэд оруул гэж байгаа юм 1 дүгээр заалт.

2 дугаар заалт гэхээр 12 оноос хойш төрсөн хүүхдүүдэд энэ хувьцааг нэмж олгоё гэсэн ийм заалт.

3 дугаар заалт хувьцаанд оногдох ноогдол ашигийг олго. Энэ талаар Засгийн газар тодорхой бодлого гаргаж ирж Улсын Их Хуралд танилцуул гэсэн ийм тогтоолын төсөл батлагдсан юм. Энэ бол 2022 оны 12 сард батлагдсан тогтоол. Үүнээс хойш жил гаран болчихлоо. Үүний дараа цагаан сар болсон. Цагаан сараар ард иргэд энэ гарсан тогтоолыг чинь хэрэгжилтийн дагуу ноогдол ашиг олгогдох нь гэсэн асуудал нэлээн яригдаад горьдлого үүсгэсэн. Дахиад жил болоод дахиад удахгүй цагаан сар болох гэж байна.

Тэгэхээр өчигдөр энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаатай холбоотой асуудал орж ирлээ. Энэ дээр тэр 1072-ыг хувьцааг эргэлтэд оруулах асуудал нь яригдсан байна. Нөгөө ноогдол ашиг олгох асуудал маань хаягдсан байна. Би өчигдөр Байнгын хороон дээр хэлсэн. Бид нар тодорхой арга хэмжээ аваад энэ өнөөдөр жишээ нь 2 хоногийн ар дээр Их Хурал завсарлах гээд байна шүү дээ.

Тэгээд ард иргэдийн хувьд бас ноогдол ашигтай холбоотой, хувьцаатай холбоотой, ноогдол ашгаа

хуваарилахтай холбоотой асуудал нэлээн горьдлого үүсээд ингээд явж байгаа. Сая сонсгол Нүүрсний сонсгол болсон. Шат шатдаа энэ хулгай дээрэм янз янзын асуудлууд нь бол шат шатдаа үүрэлчихсэн. Өөрсдөө идэж уусан ийм асуудлууд байгаа шүү дээ. Ард иргэд тодорхой бүүр мэдээлэл авчихсан байгаа. Тийм болохоор зайлиггүй энэ Их Хурлаас тодорхой шийдвэр гаргаад энэ тогтоолын хэрэгжилт өөрөөр хэлбэл Засгийн газраас ноогдол ашиг олох асуудал дээр бол Улсын Их Хурал тодорхой шийдвэр гаргаад завсарласан нь дээр байх гэсэн ийм зүйлийг Улсын Их Хурлын даргад бас уламжилж байгаа юм.

Хоёрдугаар асуудал. Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудал байна. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай холбоотой. Энэ сая өнгөрсөн амралтын өдрүүдээр орон нутгаар очиж ажиллалаа. Ард иргэдийн хувьд тэр газартай холбоотой асуудал дээр маш эмзэг байна. Тэр тусмаа газар тариалангийн нутаг болсон Булган аймгийн хувьд жишээ нь тариаланчдын хувьд маш эмзэг хандаж байгаа. Бид өөрсдөө тариаланчдаа яаж байна гэхээр ерөөсөө 15, 15-н жилээр л бид нар сунгаж байгаа шүү дээ. 15 жилээр.

Тэгчхээд гадаадынханд болохоор 60 жил, 40 жил гэсэн айхтар том хугацаа өгчхөөд байгаа. Өнгөрсөн хавар хүртэл энэ асуудалтай холбоотойгоор буруу ойлголт аваад, би Газрын тухай хууль өргөн барьсан биш энэ Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай хольж, хутгаж над руу бас нэлээн дайралтууд орж ирж байсан. Би тухайн үед хэлж байсан. Адилхан болгох ёстой. Бид өөрсдийнхөө аж ахуйн нэгжүүдэд болохоор 15, 15-н жилээр сунгаад явдаг.

Гэтэл Аж ахуйн нэгжүүд маань жишээ нь газар тариалан дээр бол асар өндөр том хөрөнгө оруулалт оруулж байгаа шүү дээ. Гадаадад ажиллаж байгаа том том техникүүд, тоног

төхөөрөмжүүд тэр олон өндөр хөгжилтэй улсад ажилладаг эд нар газар тариалангийн тоног төхөөрөмжүүд бүгдээрээ Монгол Улсад ажиллаж байгаа шүү дээ. Ороод ирчихсэн байгаа шүү дээ. Энэ чинь бол дотооддоо асар том хөрөнгө оруулалт оруулсан асуудал байхгүй юу.

Тийм болохоор ерөөсөө энэ Газрын тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай холбоотой асуудал дээр Улсын Их Хурал гишүүд нэлээн анхаарал хандуулаад энэ газрын 60 жилээр газрыг олгох, 40 жилээр сунгах гэдэг асуудал дээр бүүр нэлээн том арга хэмжээ авах. Өөрөөр хэлбэл үүнийг ер нь бас багасгах. Ер нь яах вэ 30 жилээр олгох, 10 жилээр сунгаад явдаг ч юм уу нэг иймэрхүү зүйл рүү оруулах тал дээр Улсын Их Хурал анхаарал хандуулахгүй бол болохгүй байна.

Яг үнэндээ бас энэ чинь цаад утгаараа гаднынхныг түлхүү оруулж ирэх, өөрсдөө хэрэглэж чадахгүй байгаа энэ газраа өөрсдөө чадан ядан ашиглаж байгаа энэ газраа гаднынханд олгох гэсэн ийм зүйл үнэхээр бас ард иргэдийн бухимдаад байгааг бас ойлгох хэрэгтэй байхгүй юу даа. Ойлгох хэрэгтэй. Улсын Их Хурал энэ дээр нэлээн том арга хэмжээ аваад, ер нь Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг дэмжиж байгаа. Дэмжих ёстой хууль. Дэлхий нийтээрээ Монгол Улс ч биш ер нь дэлхий нийтээрээ бие биедээ хөрөнгө оруулалт оруулж байгаад л энэ чинь хөгжиж л байгаа шүү дээ. Тийм болохоор хөрөнгө оруулалт гэдэг чинь өөрөө хөрөнгө оруулалт гэдэг нэр чинь аливаа зүйлийг бүтээн байгуулах, аливаа зүйлийг хөгжүүлэх, аливаа зүйлийг өргөжүүлэх ийм л санхүү, мөнгөний хөрөнгө оруулалт гэдэг хаана ч байсан аливаа зүйл дээр нэмэх оноо авчрах ийм л хууль шүү дээ. Тийм ч утгаараа Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиа дэмжиж байгаа.

Гагцхүү энэ газар дээр нь тодорхой арга хэмжээг авах тал тал

дээр Улсын Их Хурал анхаарах та хэрэгтэй юм байна гэдгийг бас Улсын Их Хурлын даргад, гишүүддээ уламжилж байна.

**Г.Занданшатар:** Ойлголоо. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 7 хоногт Ардчилсан намын бүлгээс Гадаад хөрөнгө оруулалтын тухай хууль дээр 3 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа өнөөдөр дуусаж байгаа Ардчилсан намын бүлгийн хувьд бас хэлэлцээд байр сууриа нэгтгэсэн. Ер нь Монгол Улс хөгжье, дэвшигье гэвэл хөрөнгө оруулалт гадаад, дотоодгүй хөрөнгө оруулалтын асуудал асар чухал. Дэлхий нийтийн хөгжил, дэвшлийн түүх ч өөрөө бас ийм байдаг. Тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулалт өөрөө өрийг нэмэгдүүлэхгүйгээр Монгол Улсад хөрөнгө оруулалт орж ирэх. Тэр тусмаа валют орж ирэх, тэр тусмаа эргээд өр нэмэгдэхгүйгээр экспортын бүтээгдэхүүн гарах олон олон ийм мэдээж ийм давуу талуудтай маш чухал хууль. Цаг хугацааны хувьд өнөөдөр биш энэ 1 жилийн өмнө, 4 жилийн өмнө, 8 жилийн өмнө бид нар энэ хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах олон зүйлүүдийг харин энэ асар их тийм цаг хугацаа хоцорч орж ирж байгаа хууль. Энэ бол 1 өдрийн өмнө ч гэсэн үүнийг хэлэлцэх ёстой байсан ийм хууль.

Гэтэл нөхцөл байдал дээр одоо яг юу болж байна вэ гэвэл энэ хууль нь өөрөө хуудуутай олон зүйлүүдийг бас дагалдаж орж иржээ. Хариуцлагагүй олон зүйл, заалтууд орж иржээ. Тэр хөрөнгө оруулалтын 100 мянган долларын босгын асуудал, дахиад дээрээс нь тэр гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгж Монгол Улсад хөрөнгө оруулахад тэр босгын асуудал. Бид нар Монголын төрийг Монголын эдийн засагт оролцоог бага байх ёстой л гэж боддог.

Гэтэл гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн оролцооны асуудал дээр бид нар ингэж хэмжээ, хязгааргүй болж байгаа нь бас энэ бас ингэж эргэж харах, ёстой, ярилцах ёстой асуудал гэж боддог. Тэгээд явсаар байгаад хөрөнгө оруулалтын энэ асар чухал асуудал явсаар байгаад 2 хүний хоорондын хэрүүлийн асуудал болж хувирч байгаа нь асар их харамсалтай. 2 хүний хоорондын хэрүүлийн асуудал болоод, ийм их чухал асуудал, ийм их чухал цаг үеэс улам хоцрогдож байгаа, цаг үеэсээ бид нар цагаа алдаж байгаа. Маш хурдан үр дүн гаргах ёстой үүн дээр.

Ийм учраас Улсын Их Хурал тэр хувь хүмүүсийн хоорондын хэрүүлийн асуудал биш. Улсын Их Хурал Улсын Их Хурлын танхимд энэ асуудал зөвшилцөл, ярилцлагын журмаар асуудал хэлэлцэж ярилцах шаардлагатай байна. Ийм учраас хууль санаачлагч Засгийн газар, Засгийн газар энэ хуулиа яаралтай горимоор эргүүлэн татаж аваад тэр ард иргэдийн дургүйцэж байгаа, бас тэр бодлогын олон асуудал байгаа энэ олон зүйлүүдийг засаж, залруулаад яаралтайгаар бас дахин өргөн барьж энэ хуулийг хэлэлцэн батлах шаардлагатай гэж боддог.

Тийм учраас Засгийн газраас энэ хуулийг Ардчилсан намын бүлгийн зүгээс буцаан татаж авах шаардлагатай. Энэ хуулиа буцаан татаж авч, дахин боловсруулж өргөн барь. Үүнийгээ улс төрийн зөвшилцлийнхөө арга замаар бас асуудалдаа ханд гэдэг ийм шаардлагыг тавихаар Ардчилсан намын бүлгийн зүгээс бас байр сууриа нэгтгэснийг бас илэрхийлье.

**Г.Занданшатар:** Гишүүд хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлж дууслаа.

Пүрэвдорж гишүүн бол Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилттэй өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдсонгүй юм ярилаа. Өнөөдөр Бат-



Эрдэнэ гишүүний ярьсантай холбоотойгоор Эрдэнэс Тавантолгойн 1072 хувьцааны асуудлаар Улсын Их Хурлын тогтоол хэлэлцэнэ. Түүн дээр Бат-Эрдэнэ гишүүний ярьж байгаа санал байгаа.

Хөрөнгө оруулалтын хуулийн асуудлаар ер нь аль ч тал нь тэр энэ Цогтгэрэл гишүүний хэлж байгаа бас зөв. Энэ 2 хүний хэрүүл болж таарахгүй. Женко гэдэг Баттулга ч, Хүрэлбаатар сайд ч нийгмийг талцуулахаа больсон нь дээр. Энэ хэдэн троллоороо гишүүдийг шантаажилж байгаад хууль батлуулна, эсвэл зогсооно гэж байхгүй. Нэг талаас болохоор Цэцэд өгөөд хэлэлцүүлээ гээд байдаг, нөгөө талаас нь болохоор 6 сар барилаа гээд байдаг. Бид нар энэ эрүүл саруулаар хандаж улс орны эрх ашгийг, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж ингэж л асуудалд хандана гэдгийг хатуу анхааруулъя.

Ер нь энэ цэц-д өгөөд байгаа нөхдүүд 2013 онд энэ 100 жилээр эзэмшүүлнэ, ашиглуулна гээд хуулийг чинь та нар баталчихсан юм байна лээ шүү дээ. Тэгээд ямар юмаараа хууль зөрчсөн гэж ингэж цэц гэж гүйгээд байгаа юм? Энэ ард түмнийг талцуулдаг, төөрөгдүүлдэг, шоуддагаа боливол таарна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

**Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна.

**С.Амарсайхан:** Улсын Их Хурлын эрхэм дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төр,

түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хянан зохицуулах, гүйцэтгэлийг хангах чиглэлээр хуульчилсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатын төсвийн захирагчид төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд ханган ажиллаж, хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэмнэгдэж байгаа зардал болон өдөр тутмын үйл ажиллагаанаас хэмнэх боломжтой зардлуудыг тодорхой бууруулж хэмнэлт гаргасан байна. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайланд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 83.2 тэрбум төгрөг хэмнэгдсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсвийн арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэнээр төсвийн алдагдал буурах, төрийн өмчит байгууллагуудын ашигт ажиллагаа нэмэгдэх, үр дүн гарах боломжийг бий болгосон байна гэж дүгнэсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хэмнэлтийн горим баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулахгүй байхаар, төрийн үйл ажиллагаа үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар тус тус заасан хэдий ч орон нутаг дахь төсвийн байгууллагууд, газар нутгийн хэмжээ, алслагдсан байдал, хүн амын тархмал суурьшил зэргээс шалтгаалан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд харилцан адилгүй хүндрэл үүсэж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх боломж хязгаарлагдаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж буурах, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг

алдагдуулах нөхцөл үүсээд байгаа талаар төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас удаа дараа санал, хүсэлтийг ирүүлсэн билээ.

Иймд орон нутаг дахь төсвийн байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа.

Нэгдүгээрт, Төрийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон төрийн аудитын байгууллага, хяналт шалгалт хийх чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд эдгээр байгууллага автомашин ашиглах зохицуулалтыг тусгалаа.

Хоёрдугаарт, Албан ажлын онцлогийг харгалзан шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн албан хаагчийн албаны гар утасны зардлыг санхүүжүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Гуравдугаарт сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг үр ашгийг нэмэгдүүлэх оновчтой болгох зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-д сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолтын зардлыг хориглосон зохицуулалтуудыг хуулиар хасахаар, төсөлд тусгахаас гадна урсгал зардал жишээ нь шинжилгээ, оношилгооны урвалж бодис болон бусад төрийн ажлыг тасралтгүй явуулах, хүн амын эрүүл мэнд аюулгүй байдалтай холбоотой асуудлын үйл ажиллагааны урсгал зардлыг шийдвэрлэхээр тусгасан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горим баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг харгалзан орон нутгийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх зарчмыг хангах хүрээнд хэмнэлтийн зарим хязгаарлалтыг уян хатан болгох нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нийслэлээс алслагдсан гэдэгт бүх аймгууд болон нийслэлтэй ойр аймгууд хамрагдах эсэх, мөн ижил чиг үүрэг хэрэгжүүлдэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд алслагдсан, алслагаагүй байдлаар

ялгавартай хандах нь оновчтой эсэх, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээвэр, эрчим хүчний салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцсыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамруулж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн үр ашгийг тооцсон эсэх, Багануур, Багахангай, Налайх зэрэг алслагдсан дүүргүүд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд хамрагдаагүй үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд орон нутгийн хөгжлийн сангаас өвөлжилтийн хүндрэлтэй байдлыг харгалзан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр тухайн аймаг, сумдад эрх олгох зохицуулалтыг тусгах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданиатар:** Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Тогмидын Доржханд гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Барсүрэнгийн

Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Чойжилсүрэнгийн Ариунхур Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлагч.

Одоо асуулт асууя. Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууна.

**Ш.Адьшаа:** Энэ төрийн хэмнэлтийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал дээр оруулж ирлээ. Энэ төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсан. Олон шалтгааны улмаас л үүнийг хийсэн байх. Тэгэхдээ энэ хууль зарим талаар цаг үеэ олоогүй бас хуулийг бид нар баталсан байгаа юм. Ялангуяа орон нутагт, орон нутгийн төр захиргааны байгууллага, орон нутгийн Засаг даргын Тамгын газруудын үйл ажиллагаанд маш их хүндрэл учирсан. Төрийн үйл ажиллагаа явагдах ийм нөхцөл боломж хумигдсан ийм асуудал дээр бас энэ Засгийн газар дүгнэлт хийж, үүндээ оруулж ирж байгаа нь сайн хэрэг. Тэр унаа машины асуудлуудыг ойлгомжтой хэрэг байгаа. Түүнчлэн өнөөдөр тэр урсгал зардал, тэр бичиг хэргийн зардал гээд өнөөдөр орон нутагт маш олон асуудал дагуулсан төрийн үйл ажиллагаа явуулахад бэрхшээл учирсан ийм асуудлууд дээр ямар хөрөнгө, санхүүгийн нээлттэй боломж олгож байгаа вэ?

Дээр нь би буруу сонсоогүй бол зарим түрүүн албан хаагчдын утасны зардлыг төлнө гэсэн ийм юм оруулж ирэх гэж сонсогдлоо. Яахаараа өнөөдөр төрийн албан хаагчдын энэ утасны зардал төрөөс төлдөг юм бэ? Машин

унааны зардлыг төлж болно. Тэр мэдээж төрийн үйл ажиллагааг явуулахад алслагдсан нутагт, хөдөө орон нутагт унаа машины зардал, бензин шатахууны зардал, бичиг хэргийн зардал, бусад урсгал зардлыг төлж болно.

Төрийн албан хаагчдын утасны зардлыг төлөх нь бол эргээд л нөгөө асуудал руугаа халтираад орчихлоо шүү дээ. Утасныхаа зардлыг өөрсдөө энэ төрийн албан хаагчид төлцгөө. Тэрүүгээр өөр асуудал тэр утасны зардлын мөнгийг нь өөр асуудалд өөр, тэр бичиг хэргийн зардал, тэр шатахууны зардал, бусад шатны шатны төрийн албан хаагчдын бусад үйл ажиллагаанд үүнийг нь зарцуул аа. Утасны зардлаа төлөх төрөөр төлүүлнэ гэдэг чинь бас энэ хэмнэлтийн хуулиа эргээд зөрчиж байгаа ийм асуудал. Энэ утасны зардал, тэр бусад асуудлын талаар энэ хууль санаачлагчаас хариулт авъя.

**Г.Занданшатар:** Барсүрэнгийн Баасандорж, 82. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга.

**Б.Баасандорж:** Адьшаа гишүүний асуултад хариулъя Баасандорж. Төрийн хэмнэлтийн тухай хууль маань 2022 оны 4 сарын 29-ний өдөр батлагдсан. Батлагдсанаасаа хойш ер нь энэ хуулийн зорилго үзэл баримтлалдаа хүрсэн үү гэвэл хүрсэн. Үндэсний аудитын газраас Төрийн хэмнэлтийн тухай хуульд дүгнэлт, зөвлөмж ирүүлсэн байдаг. Мөн мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр ялангуяа мөнгөн бус хэлбэрээр энэ төрийн албан хаагчдад, тэр дундаа төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч нарт энэ төсвийн сахилга бат, ер нь төсөвтөө ариг гамтай, үр ашигтай зарцуулах хандлага, ёс зүй гэх мэт өөрчлөлтүүд сайн эерэг талууд бол гарсан байгаа. Сая Адьшаа гишүүн 2 үндсэн асуудлыг хөндөж байна.

Нэгд нь энэ утастай холбоотой асуудлыг хөндөж байна. Энэ асуудал

бусад хангамж буюу энэ хуулийн 12 дугаар зүйлээр зохицуулсан байгаа. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа хуулийн төслөөр Адьшаа гишүүнээ нийт төрийн албан хаагчдыг хавтгайд нь утас хэрэглэхийг нь нээж өгөөгүй ээ. Тодорхой албан тушаалтнуудыг л утас хэрэглэх, албаны гар утас хэрэглэхийг нь нээж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны утасны зардлыг нь төрөөс хариуцдаг байхаар. Өөрөөр хэлбэл Онцгой байдлын ерөнхий газар, эрүүл мэндийн байгууллага, цагдаа гэх мэт ийм тодорхой тооны төрийн тусгай албан хаагчдынхаа энэ албаны гар утасны хэрэглээг нь нэмэгдүүлж өгье гэдэг асуудлыг нэмж өгсөн байгаа.

Хоёр дахь асуудал нь тантай яг санал нэг байна. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг өөрчлөлт оруулахад бол нэлээдгүй тандалт судалгаа хийсэн. Мөн Үндэсний Аудитын газраас, орон нутгийн Засаг дарга нараас, мөн хууль тогтоогчдоос буюу Улсын Их Хурлын гишүүдээс санал ирсэн байгаа. Тэр дотор энэ ер нь орон нутагт унаа тэрэг хэрэглэхтэй холбоотой.

Ялангуяа Засаг даргын дэргэдэх агентлагууд маань алслагдсан сумдууд руугаа төрийн үйлчилгээг явуулахад хүндрэлтэй байна гэдэг үүднээс энэ хуулийн маань төсөл дээр 6.5.21 дээр нийслэлээс алслагдсан аймгийн Засаг даргын дэргэдэх эрхлэх асуудлын хүрээнд хамаарах агентлагуудын унаа хэрэглэх асуудлыг нь энэ хуулиар нээж өгч байгаа юм. Хүртээмжтэй болгож өгч байгаа. Энэ нь өөрөө гол зорилго нь бол Төрийн үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн, хүний аюулгүй байдлыг хангах руу чиглэсэн өөрчлөлт байгаа юм. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөл.

**Г.Занданшатар:** Ширнэнбандийн Адьшаа гишүүн тодруулж асууя 1 минут.

**Ш.Адьяа:** Тэр цэрэг, цагдаа, хүчний байгууллага гэдэг нэрийн доор энэ утасны зардал ингээж хавтгайрах тийм бодит байдал үүснэ Баасандоржоо. Яг энэ утасны зардалд хэдэн сая төгрөг, хэчнээн хөрөнгө мөнгө төвлөрсөн тухайд яг мэдээллийг надад өгмөөр байна. Өнөөдөр бүх муу юм болохоор л, аливаа юмыг хаацайлдаг болохоор л энэ цагдаа, онцгой байдал гэдэг нэрийн доор ийм халхавч хийхээ боль Баасандорж. Энэ мэдээж сайд дарга нар төсвийн ерөнхийлөгчийн захирагч нарт л энэ утсаар ярих энэ зардлыг нэмж өгч байгаа нь тодорхой байгаа шүү дээ. Ингээд л энд нэг ийм асуудлаа хаацайлахын тулд өнөөдөр ингээд л цагдаа, онцгой байдал, эрүүл мэнд, түргэний машин гэдэг ийм юмнаасаа татгалзах ёстой шүү. Энэ дээр ийм дүгнэлт хийх ёстой шүү.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

**Б.Баярсайхан:** Энэ маш чухал хуулийн төсөлд шинэчлэгдэж орж ирж байгаад баяртай байна. Удаа дараа энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг эргээж харах, ялангуяа алслагдсан хөдөө орон нутагт төрийн албан хаагчдыг ажиллах боломж, нөхцөлийг нь хангах, орон нутагт засаг захиргаа нь өөрийнхөө ажлын хэрэгцээнд унаа тэргээ авах тэр боломжийг нь олгох энэ асуудлыг бол Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороон дээр бол хэд хэдэн удаа хөндөж ярьж байсан.

Улсын Их Хурлын чуулганы 12 дугаар сарын 1-ний өдрөөр Улсын Их Хурлын дарга Занданшатар дарга энэ асуудлыг онцгой анхаарч Шадар сайдад чиглэл өгч, Засгийн газар энэ хуулийн төслийг шинэчлэн найруулж орж ирэх ийм үүрэг, чиглэл өгсөн. Үүнээс хойш Монгол Улсын Шадар сайд бас алслагдсан аймгуудад, газар дээр нь ялангуяа энэ өвөлжилтийн нөхцөл хүндэрсэн аймгуудад, сумуудад унаа, мал,

тэрэггүй ямар хүнд, хэцүү байгааг өөрийн нүдээр харж бас ажилласан. Тэгэхлээр энэ хуулийн төсөл өнөөдөр ингээж орж ирж байгаад гишүүний хувьд ч тэр, Монгол Улсын 21 аймаг 330 сумын төрийн албан хаагчид бол их баяртай дэмжиж байгаа гэдгийг бас хэлье. Тэгээд баярлалаа.

Тэгээд надад нэг л асуулт байна. Энэ төслийн 8.1 дээр цэргийн албан хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагчид төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно гэдэг нь одоо ямар төрийн байгууллагууд хасагдаж байгаа юм бэ? Урьд нь авч байсан газрууд хасагдаад байгаа юм уу, эсвэл ер нь үүнийг хориглож байгаа юм уу гэдэг дээр тодруулж өгөөч. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Барсүрэнгийн Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга.

**Б.Баасандорж:** Баасандорж, Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Сая гишүүний асуусан хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 бол хууль санаачлагч буюу манай Засгийн газраас бол хөндөөгүй заалт. Гэхдээ 8.1 дээр заасан цэргийн албан хаагч, прокурор, гадаадын иргэнийг хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас авч болохгүй. Энийг нь бусад нь бол хориглож байгаа. Өөрөөр хэлбэл гааль, би жишээ нь татвар дээр жишээ авъя. Татварын байцаагч дүрэмт хувцас хуулиараа зөвшөөрдөг.

Гэхдээ татварын байцаагч шинээр ажилд томилогдох юм байгууллагын мөнгөөр буюу төсвийн мөнгөөр дүрэмт хувцас авч болохгүй. Өөрсдөө өөрийнхөө мөнгөөр тэр албан тушаалд томилогдож байгаа хүн маань өөрийнхөө мөнгөөр дүрэмт хувцас авна

гэсэн үг. Судалгааг хийхэд бол сүүлийн Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойш нэг 10-15 хувь нь шинээр томилогдсон хүмүүс байдаг юм байна лээ. Энэ татварын байцаагч нар маань яг өөрсдийн мөнгөөрөө цалингаасаа дүрэмт хувцсаа авч байгаа. Гагцхүү 8.1-д заасан энэ субъектүүдийн хувьд бол зөвхөн төсвөөс дүрэмт хувцсыг нь авч өгч байгаа. Ийм хориглосон зохицуулалт байгаа. Бусад албан тушаалтнуудад.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Энэ Хэмнэлтийн тухай хууль үр дүнгээ өгсөн байна. Бас тодорхой хэмжээний мөнгөн дүнгүүд гарч ирж байна. Энэ хуулийг анх хэлэлцэж байхад би бас энэ нэг хөдөө орон нутаг алслагдсан сумуудын, дүүргүүдийн энэ машин унаа ийм юмаар битгий оролдооч ээ. Энэ чинь жижигхэн юм гэж ярьсан юм. Тэгээд их ажил болохгүй байсаар байгаад л батлагдаад явчихсан л даа. Одоо ингээд дахиад ороод ирж байна л даа. Үүнийг больё, үүнийг нь буцааж өгье гээд зүйтэй үүнийг нь өгөхөөс өөр арга байхгүй. Тэр сумд байж байгаа төрийн албан хаагч утсаар л аймагтайгаа, хоттой ажил хийнэ шүү дээ энэ чинь. Ажлаа ярина шүү дээ. Түүнээс биш яаж өөр ажил хийх юм. Машин унаа гээд тэгтэл унаатай байж байж тэр нааш цаашаагаа малчидтайгаа багуудаараа явна, аймаг руугаа явна. Улаанбаатарт бол автобусанд суугаад явчихна. Тэгээд ийм юм хийгээд л хойноос нь буцаж юмаа эргээж буцаад ингээд яваад байгаа нь буруу байна. Энэ орж ирж байгааг бол дэмжиж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ 15.3.2-ыг бол энэ цахим сургалтыг хийе гэдгийг болиулж л байгаа юм байна л даа. Монгол Улс чинь энэ цахим хөгжлөөрөө бол ер нь бас нэлээн их сайн болчихсон гэсэн дүн байдаг шүү дээ. Энэ 23 онд энэ энэ Төрийн ордны том заал тэр чигээрээ л

хурал цуглаан байлаа шүү дээ. Долоо хоногт 2, 3 зөвлөгөөн, том том хурал цуглаан. Бараг долоо хоногт 4 удаа. Тэгээд л том том юм нэр барьчихсан баахан улсууд хөдөө сумуудаас ирээд байдаг. Би заримд нь орж үзсэн тэгээд ороод суухаар зэрэг тэнд тийм их шинэлэг мундаг юм алга. Цахимаар хийчихмээр л юм байгаа байх.

Тийм учраас энэ цахим гэдэг юмаа ингэж устгах нь зөв юм уу? Ер нь цаашидын чиг хандлага чинь ер нь цахимаар явна шүү дээ. Том ч бай, жижиг ч бай сургалтууд, энэ мэдээллүүдийг Монголын 360 сумууд цахимаар яахад ерөөсөө хэдэн секунд л дамжиж хүрнэ шүү дээ. Тэгээд үүнийг устгахаар чинь тэр Улаанбаатар руу явдаг тэр аймаг руугаа явдаг барьдаг юм чинь бүгд л үргэлжлээд л явна шүү дээ. Тэгээд энэ заалт чинь зөв юм уу гэж нэгдүгээр асуулт байна.

Хоёр дахь асуулт энэ 12.1.2 гэж байгаа юм. Энэ цэвэр хувь хүний өөрийн холбоотой юм байж байна шүү дээ. Амралт, сувилал тэгээд нааш цааш нь явахад л өөрөө зарлаад гаргаад явж болдоггүй юм уу? Үүнийг яагаад ингэж хүчингүй болгож байгаа юм? Энэ бид энэ төрийн өмчтэй компаниудыг нь та нар мэдэж байгаа шүү дээ төрийн өмчтэй том том компани тэр Тавантолгойн цахилгаан станц гэсэн мөртөө байхгүй цахилгаан станцаар баахан тууз гээд сар болгон 10-аад хүн цалинждаг ийм ийм юмаа хас л даа. Энэ түүнээс биш хөдөө орон нутгийн энэ хүмүүсийн юмыг ингэж хасаад хэрэггүй шүү дээ. Ингээд залруулж байгаа нь зөв байна. Тэр 2 асуултад энэ 15.2.3, 12.1.2-ыг ямар үндэслэлээр ингэж хүчингүй болгож байгаа юм бэ? Үүнийг хүчингүй болгож байгаа юм бэ? Энэ 2 асуултад хариулт авъя.

**Г.Занданшатар:** 82,  
Барсүрэнгийн Баасандорж дарга.

**Б.Баасандорж:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя Баасандорж. 2 үндсэн асуулт асуулаа.

Нэг дэх нь 15.2.3-ыг хасах болсон үндэслэл нь Баттөмөр гишүүн ээ энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаад 2 жил орчим хугацаа өнгөрлөө. Үүнээс хойш бол энэ төрийн албан хаагчдад ялангуяа төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнууд маань энэ үйл ажиллагаагаа цахимаар хийдэг нь нэгэнт хэвшсэн. Хэвшсэн зүйл болсон.

Жишээлбэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас орон нутгийнхантайгаа хурал хийхдээ дандаа цахимаар хийж байгаа. Ер нь зууны дийлэнх олонх нь цахимаар хийж байгаа. Миний хувьд, жишээ нь би өөр дээрээ жишээ аваад ярихад би Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр ажилладаг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын гишүүнээр ажилладаг манай хурлууд бол дандаа цахимаар болдог. Тэгэхээр миний хэлэх гээд байгаа энэ үндэслэл нь энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсанаар нийт төрийн албан хаагчдын хандлагад маш том өөрчлөлт орсон. Аль болох төсвөө хэмнэх, үр ашигтай хэмнэх, бичиг цаасан дээр, албан хэрэг хөтлөлт дээр, мөн энэ хурлууд дээр үр ашиггүй зардал гаргаж байснаас цахимаар хийснээрээ цаг хугацаа, зардал мөнгийг хэмнэх тийшээгээ нэгэнт шилжсэн.

Тийм учраас энэ бол нэгэнт хэвшсэн ойлголт учраас энэ цахим хурал хийхтэй холбоотой, албан хэрэг хөтлөлттэй холбоотой 15.2 маань өөрөө үйл ажиллагааг аль болох хэмнэлт гарга гэсэн зохицуулалт байгаа. Энэ үүднээс энэ 15.2-ыг хасаж өгч байгаа юм.

15.1.2-ыг хасах болсон үндэслэл маань энэ 12.1.2 бол ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр нөхрийн төрсөн нутагт амрах

тохиолдолд түүний очих ирэх замын зардал гэж байгаа. Энэ зохицуулалт маань өөрөө Төрийн албаны хууль дээр зохицуулсан байгаа маш тодорхой. Тэгэхээр энэ Төрийн албаны тухай хуулиар нэгэнт зохицуулсан асуудлыг төрийн хэмнэлтийн хуулиар давхардуулан зохицуулах нь өөрөө зохимжгүй байна гэдэг үүднээсээ хасаж байгаа. Энэ хасагдсанаараа Төрийн албаны хуулиараа энэ зохицуулалт явчих юм. Яг энэ үндсэн 2 шалтгаанаар энэ 2 заалтыг хасаж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр тодруулж асууя.

**Б.Баттөмөр:** Энэ хамрах хүрээгээ та нар олон судалгаа, шинжилгээ хийж сайн хамруулж байгаа юм байгаа биз дээ. Энэ алслагдсан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, аудитын төв болон орон нутгийн байгууллага гэж. Ингээд над дээр ямар өргөдөл ирчихсэн байна гэхээр шинжлэх ухааны байгууллагууд, тухайлбал археологийн хүрээлэн бид хөдөө явмаар байна унаа байдаггүй. Засгийн баазаас юм уу энд тэндээс машин авах гэхлээр зардал байхгүй. Явгарчихсан байна гэж. Энэ хамрах хүрээгээ яг ийм цөөхөн хүрээнд яах юм уу? Бас энэ ажлын зайлшгүй шаардлагаар орон нутаг, энэ тэр хөдөө орон нутаг явдаг улсуудын энэ машин унааны юмыг хэр зэрэг судалгаан дээр хийж оруулж ирсэн юм бэ? Ялангуяа тэр шинжлэх ухааны байгууллагуудад боломж байгаа юу, ажлын хэсэгтэй ярих боломж байгаа юу?

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Баасандорж дарга хариулъя.

**Б.Баасандорж:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Шинжлэх ухааны байгууллагатай холбоотой асууж

байна. Автомашин хэрэглэхтэй холбоотой. Засгийн газраас бол өргөн мэдүүлсэн төсөлд саяын шинжлэх ухааны байгууллага хамаарахгүй. Засаг даргын дэргэдэх эрхлэх асуудлын хүрээнд хамаарах агентлагууд буюу нийтдээ 26 хуулийн этгээдүүд хамаарч байгаа. Энэ дотор бол шинжлэх ухааны агентлаг байхгүй байгаа. Гэхдээ Шинжлэх ухааны академи маань өөрөө Төрийн хэмнэлтийн тухай хуульд зааснаар авто баазаас, эс үгүй бол түрээсээр орон нутагт ажиллахдаа машин хэрэглэх асуудал нь зохицуулагдаж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариултаа авсан байна. Одоо Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

**Н.Наранбаатар:** Хэмнэлтийн хуулийн зарим зүйл, заалт өөрчлөх энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Эдийн засгийн хүндрэлтэй үед ялангуяа КОВИД-ын дараах эдийн засгийн хүндрэлтэй үед зардлыг тодорхой хэмжээгээр хэмнэхэд энэ хууль бас үр дүнгээ өгсөн. Одоо нэгэнт эдийн засаг сэргэж байна. Цар тахлын бас бид дараах хүндрэлээс тодорхой хэмжээгээр гарч байгаа учраас ер нь орон нутагтай холбоотой, орон нутгийн, энэ аймгийн, сумын Засаг даргын Тамгын газартай холбоотой, зарим агентлагуудтай холбоотой энэ хязгаарласан заалтуудыг ер нь бүгдийг нь аваад хаячихвал яасан юм? Тэгээд энэ Хэмнэлтийн хуульдаа тэр том төрийн болон орон нутгийн өмчит том данхайсан аж ахуйн нэгжүүдээ үлдээгээд энэ төрийн байгууллагын төрийн үйлчилгээг хэвийн явуулахад чиглэгдсэн энэ зүйлүүдийг нь боомилсон заалтуудыг нь ер нь авч хаявал яадаг юм. Тухайлах юм энэ орон нутагт чинь энэ ялангуяа хүйтний өвлийн үеэр шугам дулааны, гэнэтийн гэмтэл янз бүрийн юм гарахад тендер зарлалгүйгээр яаралтай засварлах шийдвэрлэх ийм асуудлууд гардаг.

Тэгтэл энэ хуулиар бас хориод хаячихсан төсөв хөрөнгө зарцуулахыг нь.

Мөн энэ цахим дэлгүүрт байршуулсан л бараанаас авна гээд байна. Цахим дэлгүүрт байршуулсан бараа нь жишээ нь ухаалаг самбар гэхэд 13 саяын үнэтэй, гадуур 8 саяын үнэтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр гадуур хямдханыг нь авах тийм бас боломж байхгүй болгоод хаячихсан. Мөн цахим дэлгүүрээс орон нутгийн төрийн байгууллагууд бичиг хэрэг болон ойр зуурын юм авах гэхлээр тэр нь цахим дэлгүүрт байршаагүй, заавал Улаанбаатар явж зардал чирэгдэл олж авдаг. Энэ чинь өөрөө хэмнэх биш бүүр их үр ашиггүй байдал руу оруулж байх жишээтэй.

Мөн тэр сургалт семинар байна. Бүх зүйлийг цахимаар гэдэг бол боломж байхгүй шүү дээ. Зайлшгүй биеэрээ хүрч ирж үзүүлэх, таниулах ийм сургалтууд зайлшгүй шаардлагатай байгаа учраас энэ цахим заавал цахимаар хийе гэдгийг бас болиулах ёстой.

Тэгээд сая гишүүд ярьж байна. Унаа тэрэг худалдаж авах, барих гээд энэ өвөлжилтийн хүнд үед сумдын Засаг дарга нар явган явж байгаа агентлагийн дарга, сумын дарга нар бол зөндөө байгаа шүү дээ. Энийг нь бол нээгээд өгчих ёстой.

Мөн энэ бүсчилсэн хөгжлийг үзэл баримтлалыг дэмжинэ, хэрэгжүүлнэ гээд байдаг тэгээд орон нутгаа аль болохоор хөгжүүлэх талаас нь биш орон нутгийнхаа хөгжлийг боомилсон ийм зүйл заалтууд бол маш их байгаад байгаа юм. Тухайлбал Улаанбаатарт шилжиж очсон хүмүүсийг дэмжинэ барина л гээд байдаг. Тэгэхээр энэ хуулиар чинь янз бүрийн дэмжлэг, урамшуулал ийм зүйлүүдийг нь хасаад хаячихсан байх жишээтэй.

Тэгэхээр бид нэг бодлого гаргаад нөгөө бодлогоо хууль гаргаад нөгөө бодлогоо хязгаарладаг ийм асуудлууд бас байгаад байгаа юм. Тэгээд энэ тэр дээр ямар зүйлүүдийг нээж өгсөн юм? Зөвхөн энэ гар утсыг нь нээж өгөөд машин



худалдаж авах хоёрыг нь нээгээд өгчихсөн юм уу? Мөн энэ хөдөө орон нутаг чинь бас энэ тухайлах юм байгаль хамгаалагч нар чинь энэ нормын хувцас дулаан хувцас байх шаардлагатай байна шүү дээ. Тэгээд үүнийг нь хүртэл хаагаад хаячихсан ийм зүйлүүдийг нь нээж өгч байгаа юм уу, үгүй юм уу? Саяын миний хэлсэн асуудлууд дээр тус бүрд нь хариу өгөөч.

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн. Барсүрэнгийн Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга асуултад хариулъя. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга.

**Б.Баасандорж:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Баасандорж.

Нэгд нь цахим дэлгүүртэй холбоотой асууж байна. Яах вэ энэ Төрийн хэмнэлтийн тухай хуульд яг хэрэгжилтэд нь хяналт тавьдаг 3 субъект байгаа. Үндэсний аудитын газар, Сангийн яам, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар. Яг энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Засгийн газраас боловсруулахад яг энэ гурван субъект бол ялангуяа аудиторүүдтайгаа хэлэлцүүлэг хийсэн. Энэ дээр яг саяын Наранбаатар гишүүний хэлсэн асуудал бас хөндөгдсөн цахим дэлгүүртэй холбоотой, мөн орон нутгуудаас нэлээн саналууд ирсэн. Энэ цахим дэлгүүртэй холбоотой асуудалд сайн тал ч байгаа, цааш нь мөн хөгжүүлэх асуудлууд ч байгаа.

Түүн дээрээ яг саяын саяын хэлдгээр барааны сонголттой холбоотой асуудлууд. Зарим бараа хомс байдаг, зарим барааны үнийг нь харьцуулах юм бол харьцангуй зарим нь үнэтэй байдаг. Энэ асуудал дээр яг Үндэсний аудитын газар, Сангийн яам, манай 3 ярилцаад ер нь энэ худалдан авах ажиллагааны газартайгаа хамтраад энэ цахим дэлгүүр дээрээ үнэлгээ, мониторинг хийгээд

хэрхэн яаж сайжруулах вэ гэдэг дээр Засгийн газраас бодлогын түвшинд ажиллаж байгаа Наранбаатар гишүүнээ. Таны саяын хэлсэн асуудлууд дээр бол нэлээн сайн судалсан байгаа. Яг ийм асуудлууд байгаа юу гэвэл байгаа. Бас цаг хугацаа хэмнэх, түргэн шуурхай худалдаж авах, төрийн үйл ажиллагааг хэвийн болгоход хурдан шуурхай байх талаасаа сайн талууд бас байгаад байгаа. Засах юмнууд бас байгаа. Таны саяын ялангуяа орон нутагт алслагдсан бүсүүдэд ажиллах шинэ залуу, боловсон хүчнүүдтэй холбоотой урамшууллын асуудал бол байгаа.

Гэхдээ Төрийн хэмнэлтийн хуулийг хүмүүс ингээд дандаа хориглосон хууль гэж хараад байдаг. Энэ хууль яг хуульд заасан үндэслэлээр тэр шагнал байна уу, урамшуулал байна уу, нэмэгдэл өгөх асуудал нь бол нээлттэй. Харин хуульд байхгүй зүйлийг Засаг дарга юм уу тухайн төсвийн шууд захирагч дур мэдэж ямар нэгэн байдлаар урамшуулал, төсвийг үр ашиггүй зарцуулах асуудлыг л хориглож байгаа юм. Тэрнээс биш бүсийн алслагдсан бүсийн нэмэгдэл, төрийн үр дүнгийн урамшуулал ч гэдэг юм уу энэ бүх нэмэгдэлтэй асуудлууд нь бол нээлттэй байгаа. Хуульд заасан үндэслэлээр хуулиар хийсэн асуудалд.

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна. Дараа нь санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглая.

**Т.Доржханд:** Баярлалаа. Би нэг тодорхой бас асуулт асуумаар байна. Энэ нөгөө Төрийн хэмнэлтийн хууль маань гараад 2 жил болчихлоо. Тэгээд үр дүн маань юу байгаа билээ. Бид нар анх батлахдаа бол энэ төрийн албан хаагчид төрд ажиллаж байгаа мөн төрийн энэ үр ашиггүй зардлуудыг хэмнэх нь зүйтэй юм байна, дэлхий нийтээрээ хүндрэлд орчихлоо гээд ингээд энэ агуулгаар хийж байсан. Их зөв зүйтэй ийм заалтууд бол нэлээн орсон гэж бодож байгаа. Төсөв дээр ч гэсэн бас ийм соёлын их

өөрчлөлтийг бас оруулж чадсан байх гэж бас найдаж байгаа. Асуулт нь юу байна гээд. Тэгэхлээр яг энэ 2 жилийн хугацаанд яг ямар үр дүнгүүд гарсан юм бэ гэдэг талаар мэдээлэл авчихмаар байна. Төсөв дээр ямар хэмжээний хэмнэлт гарчхав хуулийн хүрээнд? Цаашаагаар урт хугацаандаа яг ийм байдлаар зохицуулаад явах шаардлагатай зүйлүүд нь ийм байна. Өнөөдөр бол зайлиггүй шаардлагатай ийм зохицуулалт хийхгүй бол болохгүй байна гэдэг талаар мэдээлэл өгөөч гээд.

Хоёрт нь болохлоор энэ тодорхой хэдхэн асуудлуудыг өөрчилж гэж орж ирж байгаа юм. Энэ 15.2.3 дээр би бас тодорхой тайлбар авмаар байх юм. Энэ дээр болохлоороо уг нь агуулга нэг зөв л заалт байна шүү дээ. Төсвийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана гээд 15.2 дээр. Тэгээд 15.2.3-д нь бол сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэнэ гээд. Бид нар чинь нэг цахим Монгол үндэстэн байна гээд. Монгол чинь бол газар нутаг томтой, төрийн үйлчилгээг цахимаар хүргэх юм бол энэ маань өөрөө үр ашигтай яг л манайд тохирсон систем байна л гэсэн энэ агуулгаар л Засгийн газар ажиллаад байгаа гэж ойлгоод байгаа. Парламент ч гэсэн үүнийг дэмжсэн гэж бодоод байгаа гээд. Гэтэл энэ заалтыг авах яг үндсэн үндэслэл нь юу юм? Ерөөсөө харагдахгүй байна даа. Одоо энэ заалт нь ингээд хэвээрээ явж байхад, хэрэгжүүлээд явахад зөв зүйтэй бөгөөд боломжтой ийм л заалт байна. Энэ дээр нэг бас тодорхой хариулт авмаар байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, 85.

**М.Санжаадорж:** Санжаадорж Сангийн яам Доржханд гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр Төрийн хэмнэлтийн хууль өөрөө бол цаг үе нь 2020 онд бол эдийн засгийн өсөлт 4.6, 21 онд бол 1.6 дөнгөж эдийн засаг буцаад сэргэж ирж байсан КОВИД болон КОВИД-ын нөхцөл байдлыг бол бид бүгд дөнгөж давж байсан үе байсан. Тэгээд давхар таарсан зүйл нь юу вэ гэхлээр геополитикийн хүндрэлтэй бид нарт таарсан. Үүнтэй холбоотойгоор инфляцын асар өндөр дарамт бид нарт ирж байсан энэ цаг үе байсан. Улс орон даяараа түүнээс тэр дундаа Засгийн газар түрүүлж бүсээ чангалах ийм бодлогын хүрээнд орж ирж батлагдсан ийм хууль байгаа. Үр дүнгийн талаар аудитын газраас энэ дээр бол үр дүн дээр бол тооцоо хийсэн байна лээ.

Тэгэхлээр энэ дээр бол 2.7 их наяд төгрөгийн хэмнэлт бий болсон байна гэдэг дүгнэлт хийсэн. Тодорхойлон хэлэх юм бол 2023 онд батлагдсан 2022 оныхоо төсвийн жилдээ энэ батлагдсан төсөв дотроо бол хэмнэлтүүд хийгдсэн. Тодорхой хэлэх юм бол 270 орчим тэрбум төгрөг. Үүн дээрээ нэмээд бол 23 онд Хэмнэлтийн хууль гараагүй байсан батлагдах тусгах шаардлагатай байсан 1 их наяд орчим төгрөгийн хэмнэлтүүд тэн дээр бол гарсан байгаа. Мөн үүн дээр нэмээд ТӨК-удын болон бусад төсвөөс гадуурх зарцуулалтууд дээр нэлээд том тоо ингээж гарч ирж байгаа.

Соёлын яамны хувьд энэ өөрөө төсөв зарцуулалтын хувьд төсвийн шууд захирагч нар болон төсвийн бүх шатын захирагч нарын хувьд соёлын том дэвшилтэт арга хэмжээг гаргаж ирсэн ийм хууль болсон гэж үзэж байгаа. Тэгээд үнэлэлт, дүгнэлтийн хувьд Улсын Их Хурал болон Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу бол ажлын хэсэг гарч ажилласан зүйл, заалт бүрээр. Мөн төрийн үйлчилгээг хүргэхэд ямар хүндрэл гарч байгаа талаар бол төрийн байгууллагуудтай бичгээр болон уулзалтын байдлаар бид нар бол санал,

дүгнэлтүүдийг нь гаргаж авч, үүн дээрээ бол анализ хийсний үр үр дүн дээр бол энэ хуулийн төслийг бол энэ байдалтайгаар бол оруулж ирсэн ийм байж байгаа.

Цахимаар хурал, зөвлөгөөн явуулах зүйл дээр байгууллагуудаас саналууд бол нэлээд гарч ирсэн. Мэдээж хэрэг цахимаар явуулах дээр бол ингээд Улаанбаатар хотод төвлөрч байгаа ийм байгууллагуудын хувьд бол цахимаар бол хийгээд даачихсан, сурчихсан, болчихсон. Үүнийх нь дагуу бол бид нар цахим хурлыг маш ингээд хангалттай хэмжээнд бол хийж болж байна гэж үзэж байгаа юм.

Гэхдээ бодит байдал дээр бас нийцэхгүй зарим зүйлүүд гарч ирж байгаа. Жишээ нь сумын хувьд сум дээр байгаа жишээ нь сургууль, цэцэрлэг, эмнэлэг ч байдаг юм уу сумынхаа хэмжээндээ ингээд хурал зохион байгуулъя гэхлээр цахимаар хийе гээд бид нар шахаад суух бас бодит байдалд нь бол нийцэхээргүй болж ирж байгаа. Тэр чинь сумдаа байгаа учраас бүгдээрээ сууж байгаад л Засаг даргынхаа өрөөндөө ч юм уу ийм байдлаар хурал, цуглаан хийх ийм боломжийг нь бол бид нээх шаардлагатай гэж үзсэн учраас хуулийн төслийг ингэж өргөн барьсан байгаа.

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууна.

**Т.Доржханд:** Зөв. Тэгэхлээр 2.7 их наяд төгрөгийн ерөнхий хэмнэлт гарсан байна гээд. зөвхөн нэг онд гэхэд улсын төсөв дээр 1 их наяд төгрөгийн хэмнэлт гарсан байна гээд. Энэ тоонуудаа та бүгд аягүй сайн мэдээлэл өгөх хэрэгтэй шүү. Өөрөөр хэлэх юм бол ингээд үр дүн гарч байгаа нь ч. Гэхдээ нөгөө талд нь ингээд зөв соёл ингээд тогтчихлоо гээд. Тэгээд зөв соёл дотор чинь энэ цахим орно шүү дээ. Тэгээд энэ чинь бол зөвхөн ингээд сумын төвийн нэг хэсэг хүмүүст зориулагдсан заалт биш шүү дээ. Энэ чинь бол ингээд нийт улс орон даяар хэрэгжүүлэх заалт байдаг. Гэтэл та

бүгд маань ингээд тайлбар дээрээ сумын төвийн нэг хэдэн хүмүүс тасалгаандаа суугаад ярих боломжтой ийм зохицуулалтыг бид нар аваад явах нь зүйтэй гээд. Тэгвэл нөгөө том зохицуулалт маань яах билээ? Энэ чинь бүх улс орон даяар энэ цахим шилжилтээ хийнэ гээд, цахимаар төрийн үйлчилгээг үзүүлэх, цахимаар хуралдах гэдэг чинь өөрөө зүйтэй зохицуул.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Баасансүрэнгийн Баасандорж, 82. Засгийн газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга.

**Б.Баасандорж:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Энэ 15.2-ыг хасаж байгаатай холбоотой асууж байна. 15.2 маань өөрөө төсвийн байгууллага төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хэмнэлтийн дараах арга хэмжээ авч ажиллана шүү гэсэн заалт байгаа. Яг энэ дээр ганцхан нөгөө сургалт семинараас гадна нөгөө тээвэр шатахуунтай холбоотой, бичиг хэрэгтэй холбоотой төрийн үйл ажиллагаа хэвийн тасралтгүй, алдагдалгүй явахтай холбоотой ийм зүйлүүдтэй холбогдож байгаа.

Гэхдээ Доржханд гишүүн тантай санал нэг байгаа. Энэ хуулийн зарчим буюу 4 дүгээр зүйл дээр 4-ийн бүүр тодруулж хэлбэл 4.2.8 дээр цахимжуулалт болон инновацыг дэмжих замаар үрэлгэн байдлын эсрэг саад тотгорыг арилгана гэдэг энэ заалт бол энэ зарчим хэвээрээ байгаа. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагууд маань нийт төрийн байгууллагууд маань энэ 4.2.8-д заасны дагуу энэ зарчмын дагуу ажиллана. Цахимжуулалт огт алга болохгүй энэ заалт 15.2.3-ыг хассанаараа. Энэ цахимжуулах болон инновацтай холбоотой холбоотой төрийн энэ үйл ажиллагааг Төрийн хэмнэлтийн дагуу зарим зардлуудыг хэмнэхтэй холбоотой энэ зарчмынхаа дагуу хэмнэлт явагдах юм. Цахимжуулалтын цахим хурлууд маань

байх юм. Энэ асуудал маань энэ 4.2-ынхоо зарчмын хүрээнд бол байх юм.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Уучлаарай Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Энэ Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн тухай яригдаж байна л даа. Хэрэгжилт болоод өөрчлөлтийн талаар. Яг үүн дээр би ажлын хэсгээс нэг асуулт аваадахъя. Ер нь бид нар төрийг хэмнэнэ, ер нь төрийн өмчийг жижгэрүүлнэ, төрийн оролцоог бууруулна гэдгийг бид нар өнгөрсөн хугацаанд маш их тийм механикаар ярьдаг. Шууд л төсвийг нь тэдээр танаад ингээд. Тэгэхээр энэ хуулийн үзэл санаа болоод энэ хуулийн хэрэгжилтийн явцад дахиад энэ хуулийн өөрчлөлт дээрээс би нэг зүйл асуух гээд байгаа нь ер нь ийм механик зүйлээсээ илүүтэйгээр яг шэйр гэдэг нэг юмыг хуваалцдаг, нөөцийг дундаа ашигладаг төрийн байгууллагууд, зөвхөн төр гэлтгүй төр, хувийн хэвшил, олон зүйлүүд Монгол Улсад байгаа нөөцийг яаж үр дүнтэй ашиглах юм.

Жишээ нь төрийн байгууллагууд бүгдээрээ өөр өөрийн өмч хөрөнгө, данхар олон олон зүйлүүд бараг л спорт заал, авто баазаас эхлээд л баахан олон зүйлүүд байдаг. Тэр хуваалцдаг харилцаа, техник технологийн дэвшил, дахиад дээрээс нь тэр төрийн бус байгууллагуудад гэрээтээр олон ажил яаж шилжих энэ бүгдийн цаана чинь л төрийн өмчийн болоод энэ Монгол Улсын өмчийг нь тэр ашигт үйлийн коэффициент олон зүйл энд яригдах ёстой байх.

Тэгэхээр бид нар ерөөсөө л нэг ийм Төрийн хууль, Төсвийн хууль, Хэмнэлтийн хууль эндээсээ ингэж хасаж тайрна. Тэр нь механик, магадгүй хэрэгтэй зүйл ч үүний цаана тайрагдчихсан байгаа учраас одоо энэ ярьж байгаа энэ унаа машинаас эхлээд энэ олон зүйлүүдийг яриад байна л даа. Тэр техник, технологи

менежментийн дэвшил, хуваалцдаг, шэйрлэдэг тэр олон зүйлүүдийг энэ хэ хуулийн хэрэгжилтэд та бүгд ямар дүгнэлттэй байна вэ? Хэрхэн, яаж цаашидаа төрийн үүний цаана чинь төр болоод олон нийтэд төрийн үйлчилгээ олон зүйл, эрүүл мэнд, боловсролоос эхлээд төрийн үйлчилгээг бүгдэд иргэдэд хүргэх асуудал үүний цаана тавигдаж байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ зүйл дээр яг ямар дүгнэлт та бүхэнд энэ хуулийн төслийн ажлын хэсгийнхэнд та бүхэнд байна вэ? Бид нар хэрхэн яаж зөв зүйтэй үр дүнтэйгээр хэмнэх юм? Үүн дээр ямар бодлого чиглэл байгаа вэ? Үүнийгээ хуваалцаач?

**Г.Занданшатар:** Барсүрэнгийн Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, 82.

**Б.Баасандорж:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Яг Төрийн хэмнэлтийн тухай хуульд бол яг саяын энэ Цогтгэрэл гишүүний хэлсэн зохицуулалт бол нарийвчилсан зохицуулалт бол байхгүй. Гэхдээ та бол их чухал асуудал хөндөж байна. Жишээ нь Засгийн газрын зүгээс бол энэ асуудлаар нэлээдгүй олон ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа. Жишээ нь Засгийн газраас 2023 оны 340 дүгээр тогтоол батлагдсан. Энэ тогтоолын хүрээнд бид нар төрийн зарим чиг үүргийг ер нь хувийн хэвшилтэйгээ хэрхэн яаж хамтарч ажиллах юм энэ талаар нэлээдгүй ажлуудыг хийж байгаа.

Мөн өнгөрсөн 2023 онд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр процессын дахин инженерчлэлийг энэ салбарт хийсэн. Яг анх удаа. Яг үүн дээр юу харагдсан гэхээр яг энэ нийгмийн хамгааллын салбар дээрэнэ харьяа агентлагууд нь яг тийм дундын оффис буюу яг таны хэлж байгаагаар тийм шэйр оффис маягаар яг энэ үйлчилгээнүүдээ иргэндээ хүргэдэг болдог юм. Жишээ нь Сонгинохайрхан дүүрэг

дээр. Сонгинохайрхан дүүрэг дээр яагаад салбар салбарын өөр өөр агентлагууд дээр өөр өөр үйлчилгээ хийгээд байгаа юм бэ? Яагаад иргэд өөр өөр агентлагууд дээр, халамж дээр очоод, нийгмийн даатгал дээр очоод, хүүхэд хамгаалал дээр очоод. Үүний оронд яг иргэн нэг төв дээр буюу нэг оффис дээр ирээд нэг оффис дээр ирээд ирээд яг энэ нийгмийн хамгааллын салбарын салбарын энэ үйлчилгээнүүдээ авчихдаг. Ийм байдлаар бид нар процессын дахин инженерчлэл хийгээд, Засгийн газарт танилцуулаад холбогдох шийдвэрүүд нь гарсан байгаа.

Мөн энэ 24 онд Засгийн газраас Эрүүл мэндийн яам, Байгаль орчны яаман дээр ахиад процессын дахин инженерчлэлийг хийж байгаа. Яг энэ процессын дахин инженерчлэлийн хүрээнд хийхэд яг энэ дүгнэлт дээр яг таны хөндөж байгаа энэ шэйр оффис буюу энэ дундын оффисын энэ асуудлууд бол ингээд шийдэгдэж байгаа. Яваандаа Засгийн газар бол хаана хүн амын нягтаршил их байна, хаана хүн амын нягтшил нягтаршил дунд нийгмийн ямар үйлчилгээний хэрэгцээ шаардлага байна гэдэг дээр тэр процессын дахин инженерчлэлийнхээ хүрээнд онож тогтоогоод үүнийхээ дагуу Засгийн газраас үе шаттай арга хэмжээ авах ажлууд хийгдэж байгаа Цогтгэрэл гишүүнээ Засгийн газар дээр. Яг энэ Төрийн хэмнэлтийн хуулиас гадуур. Энэ нь өөрөө яг нөгөө хэрхэн, яаж, үр ашигтай байх юм, иргэдэд түргэн шуурхай төрийн үйлчилгээг хэрхэн яаж үзүүлэх юм гэдэг рүү зорьж байгаа.

**Г.Занданиатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Төслийг дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно.

Байнгын хорооны саналаар Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь

зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

54.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул үзэл баримтлалын хүрээнд төслийг хэлэлцэхэд дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэе.

Энэ хууль шуурхай хэлэлцэж баталмаар байна. Өнөөдөр 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ. Төсвийн байнгын хороо өнөөдөр 17 цагаас хуралдана. Ер нь энэ хөдөө орон нутагт цас, зудын байдалтай танилцаж бид Төв аймаг, Багануур дүүргийн малчдаар Сандаг-Очир гишүүн манай Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан бид нар ажилласан. Тэгээд тэр ер нь явж байгаа бүх газрууд дээр энэ хөдөө орон нутагт энэ цас, зуданд төрийн үйлчилгээг хүргэдэг автомашины хомсдол нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиас болоод хаагдчихсан, бензин шатахууныг нь хаачихсан. Энэ хуулиас болж бас төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд их чирэгдэл учирч байна.

Ийм учраас энийг онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. Манай Жигжидийн Батжаргал гишүүн Төв аймагт бид ингээд хамт ажилласан. Тэгээд энэ дээр нэг асуудал яригдсан нь Засгийн газраас Барсүрэнгийн Баасандорж дарга нэн ялангуяа тэр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг яаралтай өргөн баримаар байна. Одоо энэ хот, хөдөөгийн сэргэлтийг хэрэгжүүлэхэд, хотын төвлөрлийг саад сааруулахад, Багануур, Налайхыг хот болох асуудлыг Багануурын иргэд ихээр тавьж байгаа. Манай Сандаг-Очир гишүүн, Амарсайхан гишүүд нар бас санаачлаад ярьж байгаа.

Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 2019 онд аймгийн төвүүдийг хот болгохоор Үндсэн хуульчилсан. Улсын чанартай хот, орон нутгийн шинж чанартай хотуудыг тодорхойлж, Хот, тосгоны эрх зүйн байдлыг тодорхой болгох шаардлагатай байна. Ийм учраас энэ дээр Баасандорж дарга. Бэлэн хуулийн төслийг Тогтохсүрэн дарга нарын ажлын хэсэг боловсруулаад өгчихсөн. Одоо хүлээгдээд байгаа юм байна лээ. Гишүүдийн дотор хэлэлцүүлэг яваад нэгдсэн ойлголтод хүрчихсэн. Тогтоол нь аймгийн төвүүдийг хот болгох тогтоолыг Засгийн газар л санаачлах ёстой учраас Засгийн газарт өгчихсөн. Одоо хүртэл байдаггүй. Ингээд намрын чуулган завсарлалаа. Үүнийг яаравчлахыг чиглэл болгож байна. Дараагийн асуудалд орё.

15.23 цаг.

**Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Дэлгэрсайхан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хот 2022 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ий 64 хувийг дангаараа үйлдвэрлэж байгаа бөгөөд хотын төсвийн 90.1 хувийг татварын орлогоор, 9.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.

Төсөв дагасан уг санхүүгийн схемийг шинэчлэн олон улсын жишиг хотуудын эдийн засгийн хөгжилтэй ижил түвшинд хүрэх чухал нэг алхам бол хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох

томоохон төслүүдийг санхүүжилтийг шийдвэрлэх механизм юм. Монгол Улсын хөрөнгийн зах зээл орон нутгийн болон ногоон бонд зэрэг нийгмийн байгаль орчинд эерэг нөлөөг үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулагчдад хангалтгүй байгаа бөгөөд нийслэлийг үнэт цаасны хувьд гол сонирхож буй субъект нь арилжааны банкнууд болж байна. Арилжааны банкнуудын хувьд аль болох өгөөж өндөртэй өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой байна.

Иймд нийслэлийн хэмжээний томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг хямд эх үүсвэрээр нөхөн зөвхөн дотоодын зах зээлээс босгох зах зээл хязгаарлагдмал байна.

Нөгөө талаар олон улсын зах зээл дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлын багасгах чиглэлээр дэлхийн улс орнууд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүний нэг нь ногоон санхүүжилтийг хөгжүүлэх явдал бөгөөд хөгжингүй улс орнууд ихээхэн хэмжээний хөрөнгийг энэ чиглэлийн хөрөнгө оруулалтад зориулах чиг хандлага дэлхий даяар эрчимжиж байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлын бууруулахад чиглэсэн ногоон зах зээл болон бондын хүү бага байгаа бөгөөд 2023 оны 4 сард Олон Улсын Валютын Сангийн судалгаанаас үзэхэд хөгжиж буй орнуудын хувьд ногоон болон энгийн бондын хүүгийн түвшний зөрүү 2 хувь орчим байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нийслэл олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсрууллаа.

Нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах эрх зүйн орчныг бий болгосноор урт хугацаатай, зардал

багатай өрийн хэрэгслийг зах зээлд гаргах, үүний үр дүнд төсөвт ирэх ачааллыг бууруулж, нийслэлд хөгжлийн болон томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх, цаашилаад Монгол Улсын валютын нөөцийг бүрдүүлэлт, төгрөгийн ханины чангаралт, гадаад хөрөнгө оруулалтад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Чуулганы нэгдсэн хурал хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Өнөрболор:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах, эрх зүйн орчныг бий болгох, Засгийн газраас зөвшөөрсөн тодорхой төсөл, арга хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор гадаадын зах зээлд үнэт цаас гаргах хөгжлийн болон томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хууль болон холбогдох хуулийн төслийг боловсруулсан байна.

Мөн нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ” дэд төв түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цаас зориулан 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах нь зүйтэй гэж үзэж “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нийслэл хотын түгжрэл, агаар, орчны бохирдлыг бууруулах, авто замын нэвтрэх чадварыг дээшлүүлэх чиглэлээр инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн төсөл, ТЭЗҮ байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Өрийн удирдлагын тухай хуулийн өөрчлөлтийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл, санхүүжилтийн арга замын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл нь Төсвийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлагуудыг хангаж байгаа эсэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргахад шаардагдах хуулийн тусгай шаардлагын нэг болох төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ТЭЗҮ хийгдсэн эсэх, Төсвийн хуульд заасан Засгийн газрын баталгааны дээд хязгаарт багтаж байгаа эсэх, төсөл арга хэмжээний төсвийн нарийвчилсан зардлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Доржханд гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүд Нийслэл Улаанбаатар хотын Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хишгээгийн Нямбаатар, Монгол Улсын сайд Нийслэл Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Борхүүгийн Дэлгэрсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын газрын дарга Одсүрэнгийн Номинчимэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга,

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Дугаржавын Амгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Санхүү, төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын тасгийн дарга Лхагвадоржийн Эрдэнэбадрах, Нийслэлийн Орон сууцны корпорац хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Маньбазарын Говьсайхан.

Одоо Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

**С.Одонтуяа:** Тэгэхээр нийслэл бас эрх зүйн байдлын тухай хуулиа батлуулаад энэ олон улсад бонд гаргах ийм юу орж ирж байна. Тэгэхээр нэгэнтээ л Засгийн газрын баталгаа гаргаж байгаа учраас энэ бол Засгийн газрын л өр нэмэгдэнэ гэсэн үг. Тэгээд нийт 1.6 их наядын хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ гэж байна. Тэгэхээр зүгээр зарчмын хувьд бол үүнийг дэмжиж байгаа юм. Дэмжихээс өөр бид нарт бол арга бол байхгүй болсон. Энэ хот чинь ингээд энэ утаатайгаа байгаад байх юм уу, энэ хот чинь ингээд түгжрэлтэйгээ байгаад байх юм уу? Тэгэхээр үүнийг дэмжихээс өөр арга байхгүй.

Гэхдээ одоо энэ орж ирж байгаа энэ Улсын Их Хурлаар орж ирж байгаа хуулиуд бол дандаа гоё эхэлдэг байхгүй юу олон улсын сайн жишигийн дагуу тэр улсын тийм тийм гээд л ингээд эхэлдэг. Одоо энэ Их Хурал бол ерөөсөө баталсан хуулиар бол дэлхийн хамаг сайн сайхан юмыг бүгдийг нь л баталлаа шүү дээ. Тэгээд хэрэгжилт дандаа нойл. Дүүжин тээвэр гээд л хэчнээн сайхан юм ярьсан байхгүй. Одоо иргэдийн бас шүүмжлээд байгаа тэр фантам бараг л Лас Вегасын фантам шиг л юм болно гэсэн чинь байхгүй. “Би Ар Ти” гээд л олон жил яриад л хамгийн чухал гээд л ярьсан байхгүй. Тэгэхээр ийм зорилго агуулга нь болохоор гоё юм яриад байдаг. Яг гүйцэтгэл дээр бол дандаа алдаж байна. Сая ногоон автобусны асуудал бол хамгийн том сүүлийн жишээ. Тэгэхээр энэ бид нар бол энэ мөнгө байхгүйдээ гол



асуудал байна уу, эсвэл энэ арга менежменттэй гол арга байна уу гэдэг дээр л маш сайн ажиллах ёстой. Хөгжлийн банк гээд л мэдээж сайхан төсөл.

Гэтэл яг санхүүжилт нь юу болж хувирлаа. Нүүрс Монгол Улс хэчнээн их нүүрс гаргалаа гэнэ. Ихэнх нь л сая хулгайн гараар ингээд явлаа. Тэгэхээр бид нар ийм нөгөө ард түмэн чинь ингээд нэг төрд итгэх итгэл байхгүй болчихлоо. Төрийн байгууллагад итгэх итгэл байхгүй болчихоод байна л даа. Тэгэхээр энэ дээр яамаар юм Нямбаатар сайд бол бас туршилагатай хүн учраас бас жоохон найдаж л байна. Бас нэг гайгүй юм хийчих болов уу гэж найдаж байна. Тэгээд өчигдөр гэхэд л Эрдэнэс Тавантолгой бараг 8 тэрбум долларын орлого олсон гэсэн чинь л одоо бол 4.6 их наядын өртэй байна гээд л бас л ингээд л ихэнх нь өр болчихоод л сууж байна. Тэгэхээр энэ бонд бол өөрөө бас шууд орлого биш шүү дээ. Энэ чинь өөрөө бас өр, зээл. Маш том менежмент хийх хэрэгтэй. Энэ бондын мөнгөнд хариуцлагагүй хандах юм бол эргээд л маш том өрөнд унана.

Тийм учраас энэ асуудал дээр яг энэ бонд дээрээ яг яаж ажиллах юм бэ, ямар мэргэжлийн баг ажиллах юм уу, энэ бондоо эргэн төлөлтийг нь юунаас харж байгаа юм гээд энэ нэг санхүүгийн тооцоо судалгааг нь нэг сайн тайлбарлаад өгөхгүй юү. Одоо бүүр үнэхээр бүүр юманд итгэх итгэлгүй л болчихоод байна л даа. Тэрнээс биш агуулгыг нь бол дэмжиж байна. Мэдээж Улаанбаатар хот сайхан байхыг хүсэж байна. Энэ их хүнд нөхцөлөөсөө гарахыг бол хүсэж байна. Гэхдээ эргээд гүйцэтгэл дээрээ дахиад алдаа гаргах вий, энэ их мөнгө баахан хийсэн юмгүй өр болоод үлдэх вий гэдэг дээр л яг санаа зовж байна. Энэ дээр нэг сайхан хариулт өгөөч.

**Г.Занданшатар:** Хишгээгийн Нямбаатар нийслэл Улаанбаатар хотын

Засаг дарга Улаанбаатар хотын Захирагч, 81.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Бид 11, 12 сард бас энэ орон нутгийн бонд гаргах чиглэлээр олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай нэлээд олон уулзалтууд хийсэн. Тухайлах юм бол Ай Эф Си-тэй хийлээ, Би Ар Ди-тай уулзалтууд хийлээ, Ай Ди Би-тэй уулзалтууд хийлээ. Тэгээд нөхдүүд бид нарын энэ хэрэгжүүлэх гэж байгаа төслийг Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлэмжийн хийг бууруулах агуулгатай төсөл учраас ногоон ийм зээлийн санхүүжилт хийх боломжтой гэдгээ дээрх байгууллагууд ярьсан байгаа. Би Монгол Улсын бондын арилжаанд өмнөх бүх бондын арилжаанд оролцож байсан санхүүгийн зөвлөхүүдтэй ч гэсэн хэд хэдэн удаагийн уулзалтууд хийгдсэн.

Тэгээд гол асуудал юун дээр оршоод байгаа вэ гэхээр манай энэ Өрийн удирдлагын тухай хууль дээр орон нутгийн бонд зөвхөн төгрөгөөр байна гэдэг ийм зохицуулалт нь цаашаа олон улсын хөрөнгийн зах зээл дээр бид нар орон нутгийн бондоо гаргах энэ боломжийг хязгаарлаж байна гэдгийг санхүүгийн болон энэ хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд бидэнд зөвлөөд байгаа юм. Танай тухайн өдрийн Монголбанкны ханшаар бид нар үнэ нэрлэж, бонд худалдаж авсан тохиолдолд ханишийн эрсдэлийг хэн үүрэх вэ гэдэг ийм хүртэл асуудлууд яригдаж байгаа. Тэгээд үүнээс гарах гарцыг бид нар энэ Өрийн удирдлагын тухай хуульд төгрөгөөр гэдгийн ард таслал тавиад валютаар гэдэг ийм л өөрчлөлтийг оруулж ирж байгаа.

Хоёрдугаарт, бид нарын энэ төсөл бол цэв бүүр “Сэлбэ” дэд төв дээр хэрэгжих ийм төсөл байгаа. “Сэлбэ” дэд төв дээр 2003 айлын нэгж талбарыг чөлөөлөх хууль, эрх зүйн орчин нээгдсэн. 2003 нэгж талбар дээр бид нар 12 мянган айлын орон сууцыг барьж

байгуулснаар Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Хайлааст, Таван буудал, Зургаан буудал орчмын айлуудыг 12 мянган айлуудыг нүүлгэн шилжүүлж оруулах ийм агуулгатай. Өөрөөр хэлбэл орон сууцыг газраар своп хийх ийм агуулга төсөл байгаа. Ингээд бид нар энэ төслийг амжилттай хэрэгжүүлж чадвал бид нарт 701 га газар үндсэндээ чөлөөлөгдөнө. 701 га газраа бид нар бонд босгосон. Энэ мөнгөө эргэн төлөх барилгын компаниудад 50, 100 га-аар нь хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан борлуулах ийм агуулгатай төсөл байгаа. Ногоон байвал бид нарын зах зээл дээрээс босох хүү одоогийн Засгийн газрын үнэт цаасны хүүгээс 2 хувь доогуур буур байх ийм боломжууд бас байгаа гэдгийг ярья, хэлье.

Тэгээд хэд хэдэн ийм бас санхүүгийн байгууллагуудтай бид нар бол уулзалтууд хийчхээд байгаа. Эдгээр байгууллагуудын бидэнд өгч байгаа зөвлөгөө бол болж өгвөл ногоон өнгөтэй ийм бонд гаргавал илүү зах зээл дээр 500 орчим 1 тэрбум ам.доллар-ын ийм эргэлтүүд байгаа эндээс танай орон нутгийн бондыг сонирхох санхүүжилт бол байна гэдэг ийм зүйлийг ярьсан. Бид нар чуулган завсарласан хугацаанд бас Засгийн газрын зөвшөөрлийн хүрээнд бондоо гаргах ийм төл.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Ширнэнбандийн Адьяаа гишүүн.

**Ш.Адьяаа:** Өнөөдөр энэ Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэж байна. Нийслэл Улаанбаатар хотын энэ түгжрэл, агаарын бохирдол, бусад тулгамдсан асуудлуудыг шийдүүлэхийн тулд энэ хууль, эрх зүйн хүрээнд энэ төслийг дэмжих, энэ шийдлийг дэмжих асуудал өнөөдөр хамгийн чухал байна. Нийслэл хотын асуудал өнөөдөр ер нь гамшигийн хэмжээнд хүрсэн, үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрсэн. Энэ асуудлыг

энэ ногоон хөгжил, олон улсын зах зээл дээр бонд бусад эх үүсвэр гаргаж шийдэх асуудлууд өнөөдөр энэ нийслэлийн асуудал биш энэ Монгол Улсын үндэсний эрх ашиг. Үүнийг шийдэх ёстой. Энэ зарчмын асуудлаа тодорхой тулгуурлаад энэ нийслэл хот бусад энэ Засгийн газрын холбогдох албаны хүмүүс үүнийг яаралтай орж ирж шийдүүлэх асуудлыг цаг алдалгүй хийх ёстой л гэж бодож байгаа юм.

Яагаад гэвэл энийг шийдэх ёстой ийм олон улсын туршилага байдаг юм байна. Бид аливаа асуудлыг шүүмжлээд, эсэргүүцээд, олон талаас нь ингээд яриад байвал яриад л байна. Тэгэхдээ бид өнөөдөр шийдлийг гаргах ёстой шүү дээ. Нэгэнт эрх мэдлийг нь ард түмэн үүнийг шийд гэдэг ийм асуудлыг яриад тэр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлага, түүний нэгжийн тухай хуулиар нийслэлд эрх хэмжээг нь өгсөн байхад энэ хэмжээнд энэ шийдлээ гаргаад явах цаг алдалгүй явах ёстой л гэж бодож байгаа юм.

Дээр нь энэ бид Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг бас 22 онд бид баталсан. Энэ хуулиар чинь ч гэсэн энэ Өрийн удирдлагын тухай хуулиас гадна Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар бол нийслэлд тодорхой хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг шийдэх ийм хууль, эрх зүйн боломжийг нээж өгсөн байгаа. Энэ Өрийн удирдлагын хуулиас гадна тэр хуулийнхаа хэмжээнд ч гэсэн бонд, бусад санхүүгийн эх үүсвэрээ шийдээд явах нь энд эрх зүйн хувьд, хуулийн хүрээнд бол нээлттэй байгаа. Ийм учраас бол энэ Өрийн удирдлагын тухай хуулийн хүрээнд шийдэгдэх ёстой энэ эко ногоон хөтөлбөрүүдийн асуудлыг шийдэхийг бол бас Их Хурлын гишүүний хувьд дэмжиж байгаа юм.

Энд шүүмжлэлүүд зөндөө асуудал байгаа. Тэгэхдээ бол тэр урьд хийгдсэн, хийж байсан алдаа дутагдалтай дүгнэлт хийх ёстой. Бид нар маш их

шүүмжилж байсан шүү дээ. Ногоон автобус гээд л, сүүлд нь энэ саарал автобус гээд л, сүйрүүлээ гээд л байсан. Энд нийслэл хотын талбай дээр Нямбаатар сайдын ахалсан, Дэлгэрсайханы ахалсан тэр автобус оруулж ирж сайн жишиг тогтоох иргэдийн бас хүсэн хүлээсэн шийдэж болдгийг л бас харуулж л байгаа шүү дээ. Тэгэхлээр бол энэ асуудлыг цаашидаа цаг алдалгүй шийдэх асуудал бол энэ Их Хурлын ч асуудал биш нийслэлийн эрх ашиг, Монгол Улсын хүн амын бараг тэн хагас нь Улаанбаатар хотод оршин сууж байгаа энэ нийслэлийн түгжрэл, энэ агаарын бохирдол, энэ бусад бэрхшээлтэй асуудал шийдэх энэ хуулийн төслийг дэмжих ёстой гэж бодож би үг хэлж байгаа юм. Дэмжиж үг хэлж байгаа юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

**Б.Баттөмөр:** Нийслэл бонд гадаад зах зээлд бонд гаргах гэж байгаа юм байна. Тэгэхээр нийслэл гэдэг бол их том айл. Монгол Улсын хүн амын 60-аад хувь нь нийслэлд байж байгаа. Монгол Улсын ДНБ-ий жаран тав, зургаан хувийг үйлдвэрлэдэг ийм том айл л даа. Тэгээд энэ хэмжээгээрээ нийслэлд маш их асуудал хуримтлагдсан байгаа. Энэ хуримтлагдсан асуудлуудыг мөнгөөр л хийнэ. Аливаа хөгжил, дэвшлийг бол мөнгөөр хийнэ шүү дээ. Тэр байтугай төгс ардчиллын ч мөнгөөр удирдана гэж нэг хүний хэлсэн үг байгаа шүү дээ.

Тэгэхээр Нямбаатар дарга бас ажил аваад нэлээн удчихлаа. Хэдэн хэдэн сар болчих гэж байгаа билээ? 3 сар болж байгаа юм байна. Яах вэ ажилтайгаа танилцаад боломжуудыг ч шинэ нүдээр харж байгаа байх. Ер нь бол нийслэл бол татвар хураагаад энэ их олон асуудлуудыг шийдэж чадахгүй. Тэгэхээр орлого нэмэгдүүлэх ямар боломж харагдаж байна гэж өөр чинь нэгдүгээр асуулт энэ байгаа.

Дараа нь юу гэхлээр энийг яагаад ингэж байна гэхээр бүх асуудлыг зээл авч гаднаас, дотноос зээл авч хийхгүй шүү дээ. Тийм учраас дотооддоо нэгэнт ДНБ-ий 60, 70-аад хувийг үйлдвэрлэж байгаа юм чинь тэр хэмжээний далд эдийн засаг Монголд байгаа шүү дээ. Үүнийг илрүүлэх чиглэлд, илүү орлого олох чиглэлд тэр уурхай гээд яриад байсан юмнууд ч бид нар дэмжээд байгаа шүү дээ. Энэ эд нар чинь юу болж байгаа бэ гэсэн нэг дэх асуудал байгаа юм.

Дараагийн асуудал яах вэ гэхээр энэ Ганбат дарга хариулах юм болов уу? Энэ улсын өр гээд яваад байгаа. Сүүлийн үед чинь төрийн өр гэдэг болж байгаа шүү дээ тийм ээ. Төрийн өрийг нэмэхээр ДНБ-ий хэдэн хувь болж байгаа вэ гэсэн хоёр дахь асуулт. Энэ бонд ер нь ямар хэмжээний хэчнээн төгрөгийн, хэчнээн долларын бонд гаргах гэж байна? Энэ тоо хэмжээ байна уу гэсэн гурав дахь асуулт байгаа юм.

Дөрөв дэх асуулт юу гэхээр энэ авсан зээлийн ашиглалт, Чингис бондыг чинь гаднынхан тэгсэн шүү дээ их хааныхаа нэрийг барьж байгаад монголчууд 1.5 тэрбум долларын зээлийг авчихлаа. Хийх ажил нь тун тодорхой бус гэж гаднынхан нь хэлсэн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тэр Сэлбэ дэд бүтцийн чинь ажил хэр зэрэг байгаа вэ? Энэ иргэд чинь газраа чөлөөлж өгөх үү, үгүй юү? Бэлтгэл нь хэр зэрэг байгаа вэ гэсэн ийм дөрөв дэх асуулт байна.

Дараагийн асуудал яг өнөөдөр гаднын юмнаас бонд, зээл авахад бол тийм их таатай бус байгаа юм. Хамгийн сүүлд авсан зээл, бонд бол 7.3 хувь байгаа байх тээ? Тийм, найм аравны хэдээр ч авсан шүү дээ. Тэгэхээр энэ хүүгийн тооцооллыг та нар тооцож байна уу? Хаана бонд гарга гэж бодож байгаа вэ? Энэ үр ашиг гэдэг юмыг та нар юу гэж бодож байгаа вэ? Яаж тооцооллуудын юмнууд байна вэ? Ийм асуултуудад хариулт авъя.

**Г.Занданшатар:** Хишгээгийн Нямбаатар 81, Нийслэл Улаанбаатар хотын Засаг дарга.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Баттөмөр гишүүний 4 асуултад хариулъя.

Нэгдүгээрт, орлого нэмэгдүүлэх чиглэлээр Нийслэл дараах ажлуудыг хийж байна. Энэ үл хөдлөх эд хөрөнгийн тооллогыг шинэчилж явуулах ажил Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдаад гарч байна. Бид нар сая 12 сард батлагдсан хуулийг дагуулж Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулсан. Ихэнх үл хөдлөхөөр хуучин 2000-аад оны үеийн өмч хувьчлалын тэр өртгөөрөө үнэ бичигдсэн. Түүнээсээ үл хөдлөх эд хөрөнгийн татвар төлөгддөг ийм байдалтай байгаа.

Хоёрдугаарт, бид нар энэ үл хөдлөх эд хөрөнгийн бүсчлэл дээр бас нэг эргээж харъя гэдэг зүйл ярьж байгаа.

Гуравдугаарт, энэ Зайсан Богд уулын ам болгонд бараг хаусын хорооллууд боссон. Тэгээд газрынх нь зориулалт нь болохоор аялал жуулчлалын отог нэртэй. Гэсэн хэр нь яг газар дээрээ бол үнэтэй тансаг хаусны хорооллууд байгаа. Эдгээрийг бүгдийг нь үл хөдлөх эд хөрөнгийн тооллого бүртгэлд хамруулж, тэдгээрээс үл хөдлөх эд хөрөнгийн татвар авахаар төлөвлөж байгаа.

Ер нь барууны улс орнуудыг судалж үзэхэд үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг нотариатын тэр хийсэн тухайн жилийн хэлцлүүдийн дунджаар район болгоноор нь үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээнүүдийг гаргадаг ийм эрх зүйн орчин тогтчихсон юм байна лээ. Манайд бол энэ бас ийм жишиг тогтоогүй ийм байгаа. Тийм учраас таны хэлж байгааг жил болгон мянга орчим үл хөдлөх эд хөрөнгүүд улсын комисс ашиглалтад орж байгаа. Ингээд үзэхээр бид нар бол таны хэлж байгаагаар ДНБ-

ий бараг 65 орчим хувийг үйлдвэрлэж байгаа Улаанбаатар хот цаашид татварын бааз сууриудаа үл хөдлөх эд хөрөнгийн татваруудаа бүрэн хураавал бид нарт татварын бас боломжууд харагдаж байгаа. Бид нар ойрын 4 жилээр нь бас татварын тийм тооцооллуудыг бас хийж үзэж байгаа.

Яагаад гэхээр бид нар нөгөө метроны том төсөл хэрэгжүүлэхээр олон улсын нээлттэй тендер зарлаж байгаа учраас үүн дээр бид нар бас Дэлхийн банк зэрэг байгууллагуудын өгч байгаа санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах тэр зөвлөмжүүдийг бас Засаг даргын зөвлөлийн хурал дээр шинэчилж ярихаар бас төлөвлөж байгаа. Энэ зөвлөмжүүдийн дагуу санхүүгийнхээ төлөвлөлтүүдийг цаашид бас хийж явъя. Тэгээд бааз сууриудаа яаж нэмэгдүүлэх вэ гэдэг чиглэлээр ажиллаж байгаа.

Нөгөө талаасаа бид нар зүгээр л татвар хураагаад авах гэхээсээ илүүтэй бас татварын бааз суурийг бий болгоход хувийн сектортой яаж хамтарч ажиллах вэ гээд өнөөдөр өглөө Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байгаа рестораны зочид буудлын төлөөллүүдтэй уулзлаа. Бид нар аялал жуулчлалыг хүлээж авах, нэмэгдүүлэхэд яаж хамтарч ажиллах вэ гэдэг чиглэлүүдээ гаргаж байна.

Өрийн тухайд Ганбат дарга ярина биз. Ер нь сая улсын төсөв батлагдахдаа 2024 оны улсын төсвөөр энэ жилийн тавьж болох өрийн дээд хязгаарыг 3.5 их наяд гэдэг ийм хэмжээгээр баталсан байгаа. Бид засаг дээрээ нөгөө хэрэгжүүлэх төслүүдийнхээ эрэмбийг эрэмбэлж байгаад Засгийн газар

**Г.Занданшатар:** Гүйцээгээд хариулчихъя. Нямбаатар сайд, 81.

**Х.Нямбаатар:** Нэмээд хэлэхэд бид нар сая би танд товчхон л хэлсэн “Сэлбэ” дэд төв дээр 160 га газар

инженерийн шугам сүлжээ, дулаан, цэвэр бохирын асуудал нь шийдэгдчихээд байгаа юм. Бүүр холбоо дохиолол нь ч шийдэгдчихээд байгаа юм. Зам дундах, хорооллын дундах замын зам нь ч баригдчихаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ айлуудтай нөгөө шинэ батлагдсан хуулийн дагуу хэлэлцээрүүд хийх ажил хийж байгаа. Говьсайхан дарга ахалж байгаа. Тэндээ бид нар төвөө байгуулж байгаа хэлэлцээр хийх. Энэ цагаан сарын дараачаас эхлээд аль нэг бүртэй хэлэлцээрүүд хийгээд энэ 3 сар гэхэд дуусна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Энэ дээр баригдах орон сууцны хорооллын төлөвлөлтийн ажлын зургийн тендер зарлагдсан шорт лист үүсчихсэн явж байгаа. Эндээс ингээд сонгон шалгаруулалт хийгдэнэ. Үүнтэй паралельны бид нар гадна зах зээл дээр энэ ногоон бондоо гаргахаар төлөвлөж байгаа. Товчхондоо бол одоогийн бид нарын бас ярьж байгаа гаднын болон дотоодын зөвлөхүүдийн зөвлөж байгаагаар бол энэ “Сенчерийн III”-ын араас явбал зүгээр юм биш үү. Түүн дээр бас локал бондыг сонирхох, тэр дундаа ногоон өнгөтэй бондыг сонирхох эрэлтүүд их байгаа гэж байгаа. Энэ хуультай дагуулж бид нар олон улсын санхүүгийнхээ зөвлөхийг авах бас эрхээ нээлгэж байгаа.

Тэгээд зөвлөхөө албан ёсоор авсны дараа бид нар бондоо аль маркет дээр гаргах вэ гэдгээ ярина. Зүгээр бид нарын одоогийн тооцож байгаагаар нэг энэ жилдээ бид нарт 700 орчим тэрбум эрэлт үүсэх байх. Барилгын сезонд ашиглагдах. Үүний дараа жил бол нөгөө тэр дайны эрэлтүүд үүсэх байх. Бид нар 12 мянга л барьчихаж чадах юм бол дахиад 701 га газрыг л бүхэлдээ чөлөөлнө. 701 га гэдэг бол манай бараг их тойруугийн дайтай хэмжээний ийм газрыг чөлөөлнө. Үүнийг зах зээлийнх нь жамаар бид нар газрын дуудлага худалдаагаар эргүүлж борлуулж, барилгын компаниудад компаниудад борлуулаад бондынхоо эргэн төлөлтийг хийнэ гэдэг ийм тооцоололтой ажиллаж

байгаа. Эхний бид нарын хийх барилгажилт бол 160 га дээр хийгдэнэ. 160 га дээр одоо 2 мянган айл байгаа. Нам орон сууцны хорооллын төлөвлөлтүүд хийгдэж байгаа. Энэ дээр бид нар 12 мянган айлын орон сууцны хороолол барина.

Түүнээс гадна энэ Бага тойруу дотор байгаа их, дээд сургуулиуд, соёл урлагийн байгууллагуудыг бид нар бас давхар энэ төв рүүгээ дагуулж гарах, улмаар энэ Их, Бага тойруу доторх төвлөрлөө задлах зорилготой байгаа. Ингээд 12 мянган айлаа барьж чадах юм бол бид нар дахиад 50 мянган айлын орон сууцны хороолол барих ийм иж бүрэн хороолол барих 700 га газрыг чөлөөлөх ийм л төлөвлөлттэй явж байгаа. Хоёр дахь нь бол зах зээлийнхээ жам руугаа шилжиж барилгын компаниудад өгөхөөр байгаа. Одоо ингэж төлөвлөлт хийхгүй болохоор барилгын компаниудад гэр хорооллыг орон сууцжуул гэж өгөхөөр 2-3 айлын газар чөлөөлөөд дээр нь 2 есөн давхар ямар нэгэн нийгмийн дэд бүтэцгүй ийм л төлөвлөлт болчихоод байгаа юм. Тэгэхээр бид нар бол одоогийн ажлын даалгавар дээр юу гэж байгаа вэ гэвэл тухайн хороололд амьдарч байгаа хүн 15 минутад эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг, ажлын байр гэдэг бүх хэрэгцээгээ хангах л ийм төлөвлөлтийг “Сэлбэ” дэд төв дээр жишиглэж хийе л гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Таны ярьж байгаагаар нэмээд хэлэхэд бол хотод тулгамдсан маш их асуудал байна. Одоо газар доорх шугам сүлжээ 40 жил солигдоогүй маш олон тэрбумын эрэлт байна. Одоо дулааны 10 орчим ийм жижиг станцуудыг барих шаардлагууд байна. Энэ Хүннү хороолол энэ Ривер гардены зүүн талд ийм оргил ачааллын үед дулааныг дэмжиж өгөх газын станцуудыг хэд хэдийг байгуулах шаардлагууд байна. Яармаг, Зайсанд дулааны станцууд байгуулах шаардлагууд байна. Дэнжийн мянга, Дамбадаржаа гээд ингээд дулааны

станцууд барих олон л ийм эрэлт шаардлагууд байна. Зүгээр бид нар эхний ээлжид энэ төлөвлөлтийн дагуу энэ бонны мөнгөөрөө зөвхөн “Сэлбэ” дэд төв гэдэг 12 мянган айлын орон сууцын хороолол барьж ийм энэ хавь руугаа фокусалж байгаа гэдгийг бас танд хэлье.

**Г.Занданшатар:** Жигжидийн Ганбат 83, Мижиддоржийн Санжаадорж. Санжаадорж биш шүү. 85.

**С.Тулга:** Сангийн яамны хэлтсийн дарга Тулга. Гишүүний асуултад хариулъя. Улсын секторын өрийн хувьд Баттөмөр гишүүний Монгол Улс 34.6 их наяд төгрөгийн өртэй байгаа. Энэ ДНБ-д эзлэх хувиар өнөөгийн үнэ цэнээр тооцох юм бол 55.5 хувьтай байгаа. Үүн дотроо Засгийн газрын өр нь номинал үлдэгдлээр 27 их наяд төгрөг байгаа. Энэ өнөөгийн үнэ цэнээр тооцох юм бол 43.3 хувьтай тэнцүү ийм байдалтай байгаа.

Зээлийн хүүгийн хувьд ерөнхийдөө нийслэлийн үнэт цаасан дээр Засгийн газрын баталгаа гаргаж байгаа нэг том шалтгааны нэг нь бол сүүлийн 3 жилийн хугацаанд Засгийн газар өрийн дахин санхүүжилтийг харьцангуй маш амжилттай олон улсын зах зээл дээр хийсэн. Сүүлд гаргасан “Сенчери III” төслийн хүрээнд бол бид нар 7.87 хувийн хүүтэй гарсан. Энэ нь АНУ-ын бодлогын хууль ерөнхийдөө 5.5 хувьтай.

Тэгэхлээр яг хүүгийн бодит зардал бол 2.3 хувьтай. Ер нь бол маш амжилттай төсөл болсон. Үүний дараа ингээд нийслэлийн бонд гарах юм бол тэр хэмжээгээр Засгийн газрын баталгаатай учраас нийслэлийн гаргасан бонд маань тэр хэмжээгээр зардал нь буурна гэсэн ийм үндэслэлээр ерөнхийдөө нийслэлийн бондоор Засгийн газрын баталгаа гарч байгаа. Яг тухайн үедээ Засгийн газрын нийслэлээс гаргасан бонд нь маркет трейд хэдтэй байна тэрнээс яг хамаарч хамаарч хүү нь тогтох байх.

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар Улсын Их Хурлын гишүүн, Шадар сайд асуулт асууна.

**Ч.Хүрэлбаатар:** Би асуулт бол асуухгүй. Хэдэн зүйлийг л энэ Нямбаатар даргад хэлье гэж бодож байгаа юм. Хот бол анх удаагаа олон улсын санхүүгийн зах зээл дээр бонд гаргах гэж байгаа юм. Тэгэхээр хотоос бол их олон зүйл бол хамаарна. Би хотын төсөв бол их ил тод болох ёстой. Хот өөрөө санхүүгийн сахилга батыг дээд зэргээр баримтлах ёстой. Марзан марзан төсөл бол огтхон санхүүжүүлж болохгүй. Зах зээл рүүгээ биш Монгол Улсын хэмжээгээр тэс хөндлөн төмөр зам барьдаг шиг төслүүдийг санхүүжүүлж болохгүй. Дээр нь цэргүүдээр барина гэж хэлчхээд нийт ажлынхаа 10 хувийг цэргээр хийчхээд үлдсэнийг нь мэддэг, таньдаг компаниудаараа хулгайн замаар санхүүжүүлчхээж болохгүй. Ингэх юм бол эргээд 2 дахь удаагаа хот бонд гаргахад тэр бонд бол арилжаалагдахгүй.

Ийм учраас хот дээр ер нь энэ бонд өнөөдрийн ингээд Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулаад авна гэдэг бол үндсэндээ хот төсөв дээрээ туйлын хариуцлагатай болох шал өөр аргаар хандах иймийг л бол та бүгдээс шаардана. Хэрэгжүүлж байгаа төслийн эдийн засгийн үр ашгуудыг нэлээд шаарддаг болно. Тухайлбал, нэг өдөр бас энэ Улаанбаатар хотод метро барих цаг ирнэ. Яг метроны ажлыг хийхэд би юу гэдэг юм Монголын компаниуд бол хийхгүй байх. Гадаадын томоохон компаниуд Монгол Улсад орж ирж бас Монгол Улсад бүртгэгдэж өөрийнхөө хууль ёсны эрх ашгаа Хөрөнгө оруулалтын хуулиар баталгаажуулж байж хийгдэх байх гэж бодож байна. Алийн болгон хулхины компаниудаар бид нар оруулж ирж үйл ажиллагаа явуулах вэ. Тэгэхээр томоохон компаниуд орж ирж Монголд үйл ажиллагаа явуулах цаг нь бол болсон.

Тэгэхээр томоохон бондтойгоо холбогдуулаад ихээхэн хэмжээний санхүүгийн сахилга батаас гадна хууль, эрх зүйн зөв орчнуудыг шаарддаг ийм цаг бидний өмнө ирээд байгаа юм шүү гэдгийг би бол хэлье. Тэгээд энэ өөрөө хотод их боломж олгож байгаагаасаа гадна, хотоос ихээхэн хэмжээний сахилга бат, зөв бодлого, ер нь эдийн засгийн зөв бодлогууд хэрэгжүүлэхийг л шаардана. Яг өнөөдрийн нөхцөл байдал шиг Хөрөнгө оруулалтын тухай хууль оруулаад ирэхээр Ерөнхийлөгч байсан хүн улсын хэмжээнд тэс хөндлөн төмөр зам барьсан хүн, бүгдийг нь нууцад оруулж байгаад хийчихсэн хүн нь хэдэн тэрбумтан сэтгүүлчээр акт зохион байгуулаад эсэргүүцээд хэвтээд байдаг. Түүнийг нь дагаж намираад байвал энэ Монгол Улс хөгжихгүй. Энэ дотроо Улаанбаатар хотод ийм хандлага Нямбаатар даргаа та бол огтхон гаргаж болохгүй шүү. Би бол таныг энэ бүх ажлыг манлайлаад, зөв хийгээд анхныхаа бондыг амжилттай гаргаад явчихна гэдэгт бол огтхон ч эргэлзэхгүй байна. Энэ бол их, Засгийн газар бондод нь баталгаа гаргаад өгчхөж байгаа учраас хүү нь харьцангуй бас бага байх боломжтой.

Гэхдээ санхүүгийн сахилга бат, хулгай, дээрэм ийм зүйл рүү хутгалдаад эхлэх юм энэ бондын чинь хүү нь эргээд л өсөөд яваад өгнө шүү, өгөөж нь унана шүү гэдгийг би та бүгдэд анхааруулж хэлье. Энэ шийдвэрийн цаана хот өөрөө санхүүгийн хувьд бүрэн хэмжээнд өөрчлөгдөх ёстой шүү гэдгийг хэлье. Дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Хүрэлбаатар гишүүн, Шадар сайд уг хэллээ. Одоо Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. Би бол гайхаж байна шүү. Ялангуяа би Сангийн яамыг гайхаж байна. Яагаад вэ гээд тэгэхлээр энэ чинь өөрөө маш том ийм хаалга нээж байгаа шүү дээ. Тэгээд сонгууль дөхөж байна, чуулган хаах гэж

байгаа. Яг өмнөх 2 өдөр нь түргэвчилсэн байдлаар ийм асуудал оруулж ирж байна гэдэг чинь өөрөө маш том асуултын тэмдэг шүү. Би үүнийг бол Сангийн яамныханд, Монголбанкныханд, энд Төсвийн байнгын хорооныхонд, Эдийн засгийн байнгын хорооныхонд, энд сууж байгаа эдийн засагч нарт, дээрээс нь бас Ардчилсан намынханд анхааруулж байна шүү. Та нар өрийн асуудлаар маш их улс төржүүлдэг, өрийг дарлаа, дараагүй гэдэг. Одоо энэ бол яг адилхан өр юм шүү.

Өөрөөр хэлэх юм бол Улаанбаатар хотын бонд гэдэг чинь өр шүү. Өр үүрэгтэй арилжааны зээл шүү. Хөнгөлөлттэй зээл биш өр. Анх 2012 онд Засгийн газрын авсан тэр 1.5 тэрбум чинь төлөгдөөгүй байгаа шүү. Хойшоо шидэгдсэн байгаа. 130 сая доллар төлөгдсөн байдаг юм. Одоо яг тэр хэмжээгээр бид нар Улаанбаатар хотод өр үүсгэж байна шүү. Өр үүсгэж байна шүү. Улаанбаатар хот тэр өрөө төлж чадахгүй бол Засгийн газрын өр нь дампуурдаг юм шүү. Яг адилхан дефолт зарладаг юм шүү. Кросс дефолт гэдэг юм. Яг ижилхэн шүү эрсдэл нь бол. Ийм болохлоор маш сайн ярилцсан юм уу гэдэг асуудал байгаа юм, асуулт. Сангийн яам үнэхээр дэмжиж байгаа юм уу, нэг.

Хоёрдугаарт нь та нар хүүгийнхээ нөхцөлийг яг ямар байдлаар төсөөлж байгаа юм? Өнөөдөр бол хамгийн тохиромжгүй гадаад бондын орчин байгаа шүү дэ. Федийн хүү чинь 5.5 хувь, 5.5 хувь. Маш өндөр. Энэ бүс нутаг чинь хөрөнгө оруулалт байхгүй байгаа. Хойд хөрш маань дайн өдөөчихсэн. Тэр институционал инвестор /Institutional Investor/ буюу тэр институцийн хөрөнгө оруулагч нар чинь, фикст хөрөнгө оруулагч буюу бондын хөрөнгө оруулагч нар чинь энэ бүс нутагт бол хөрөнгө оруулахгүй байгаа ийм үе шүү, хоёр.

Тэгэхээр ийм үед та нар яг ямар, хэдэн хувийн хүүтэй бонд гаргана гэж төсөөлж байгаа юм бэ? Үүнийгээ

тодорхой хэлээч. Хамгийн сүүлийн бонд бол үнэн 7.1 хувийн хүүтэй. Тэр бол Засгийн газрын бонд байхгүй юу. Засгийн газрын баталгаатай орон нутгийн бонд биш байхгүй юу. Тэгэхлээр тэрэнтэй битгий холиорой. Энэ дээр тодорхой хариулт бас авмаар байна.

Тэгээд гуравдугаарт яг хөгжиж байгаа орнуудын хувьд бол мэдээж дэд бүтцийн санхүүжилт хэрэгтэй байдаг. Үнэн үнэн. Би хотын даргын зовлонг бол ойлгож байна. Санхүүжилт байвал хийчихмээр байна. Гэхдээ үүнийг хамгийн хүнд нөхцөлтэй үед хамгийн өндөр хүүтэй зээл авах ийм л нөхцөл байдал үүсэж байгаа шүү дээ. Ийм нөхцөлийг харин Сангийн яам нээж өгч байна гээд л би гайхаад байгаа юм. Би өөрөө яг энэ асуудлыг 10 жил хариуцаж байсан. Дэлхий дээр яг энэ хөгжиж байгаа улсууд яг энэ хотын бонд гараад амжилттай явсан жишээ бол би мэдэхгүй юм байна. Та нар мэдэж байгаа бол тэрийгээ хэлээрэй. Хөгжилтэй орнуудын хувьд бол ийм жишээнүүд бол байдаг. Манай зээлжих зэрэглэлийн үнэлгээ ямар байгаа билээ.

Тэгэхээр энэ маань өөрөө яаж эргэн төлөлтөө хийх юм бэ? Хугацаа нь хэд байх юм? Засгийн газрын бонд бол 10 жилийн хугацаатай байдаг урт хугацааных. Хамгийн сүүлчийнх арай гэж 5 жил. Орон нутгийн бондууд чинь богино хугацаа шүү дээ. Максимум нь 5 жил. Ер нь бол богино, дунд хугацааны 3-5 жилийн л бонд гарна шүү дээ. Энэ хугацаанд саяын Нямбаатар даргын яриад байгаа шиг ийм байшингуудаа огцом бариад л, хурдан бариад л, эргэлдүүлээд явах боломж байгаа юу? Энэ дээр та бүгд джюу делиженс /due diligence/ буюу үнэлгээ хийлгэсэн үү, шинжилгээ хийлгэсэн үү? Үүнийг би мэргэжилтнүүдээс нь асуумаар байгаа юм. Тэгэхлээр Сангийн яамнаас асууя. Дээрээс нь бас энэ асуудал дээр Төсвийн байнгын хороо юу гэж бодож байгаа юм? Энэ чинь бол шууд механикаар өрийн өр, эрсдэлийг чинь үүсгэнэ шүү дээ.

Хотын бонд, Засгийн газрын бонд ямар ч ялгаа байхгүй төлж чадахгүй бол адилхан дефолт шүү. Энэ дээр.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатар.

**Х.Нямбаатар:** Би Доржханд гишүүний асуултад хариулъя. Юуны хувьд бид нар сая 11, 12 сард үндсэндээ орон нутгийн бондтой холбоотой ажлын хэсэг гаргаад бид гадна дотнын бас зөвлөхүүд аваад ажиллалаа. Манай бас энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хуучин Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Мандуул энэ ажлын хэсгийг бас ороод ингээд өмнөх бас Засгийн газрын бүхий л бондууд дээр ажиллаж байсан ийм бүрэлдэхүүнүүд ажилласан юм. Дотоодын бонд гаргахаар үр өгөөжийн хувьд нэлээн тийм хүнд байгаа. Доржханд гишүүн өөрөө мэдэж байгаа байх дотоодын бонд гаргах бүх эрх нээгдсэн, Засгийн газрын шийдвэр ч гарчихсан. Тэгээд бид нар дотоод бонд дээр бол 17.5 хувьтай энэ 10 сард босохоор байсан. Ийм өндөр хүүтэй бид нар ийм төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд бас үр өгөөж муутай юм. Тэгээд богино хугацаатай гээд дотоод бонд гаргах шийдвэрээ бүр мөсөн Нийслэл дээр цуцалсан. Ингээд гаднын зах зээл дээр бид нар энэ бондыг гаргахдаа сая Сангийн яамныхан бас тайлбар хэллээ. Бид нар сая “Сенчери III” дээр ажилласан энэ загвараараа явъя.

Ингээд орон нутгийн бондыг бид нар 5 жилийн хугацаатай гаргах ийм үндсэн төлөвлөлт барьж ажиллаж байгаа. Сая Хүрэлбаатар сайдын хэлж байгаачлан бид нар бас Нийслэл санхүүгийнхээ сахил сахилга батыг сайжруулах ийм маш их шаардлага байгаа. Тийм учраас бид нар бас гаднын ний зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжийн дагуу энэ үндсэндээ үнэлгээнүүдээ хийгээд энэ орон сууцын “Сэлбэ” дэд төв



дээр энэ хөрөнгө оруулалтыг хийсэн тохиолдолд бид нар 24-36 сарын хугацаанд иргэн бүтээн байгуулалтын ажлуудыг дуусгаад, газрын ийм своп хэлэлцээрүүд хийгдээд, эргээд газраа зах зээлийнх нь жамаар худалдан борлуулах замаар энэ бондын эргэн төлөлтийг хийнэ л гэдэг ийм зүйл байгаа.

Ер нь Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдол, үүнийг шийдэх, түгжрэлийг шийдэх эцсийн арга зам бол энэ дэд бүтэц нь шийдэгдсэн 6 дэд төвүүдийг амилуулах замаар бид нар агаарын бохирдлыг 40-50 хувь бууруулах, түгжрэлийг бас 40, 50 хувь бууруулах ийм үнэлгээнүүд хийгдсэн байгаа. Энэ дагуу л бид нар гаднын өгсөн зөвлөмжүүдийн дагуу энэ бонд гаргах чиглэлээр бид нар ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд би бас Доржханд гишүүнийг, хотын зовлонг бас ойлгох байх гэж бодож байна. Бидэнд өнөөдөр санхүүгийн эх үүсвэргүйгээр энэ агаар, хөрс, усны бохирдлыг шийдэх ямар ч арга зам байхгүй. Бид нар энд өмнө нь маш олон жил ярьсан хувийн секторуудыг орон сууцжуулах, барилгажуулах энэ ажлууд дээр ирэх зөвшөөрлүүдийг маш олон өгсөн байдаг. Эдгээр төслүүд үндсэндээ амжилтад хүрсэн төсөл маш ховор байгаа. Одоо та бүхэн харж байгаа байх бид сүүлийн байсан задгай газар болох Яармагийн дэнжийг бүхэлд нь ингээд аж ахуйн нэгжүүд өгсөн. Ингээд л ширэнгэн хороолол олгосон. Эцсийн үр дүн нь Улаанбаатар руу Яармагаас орж ирэх түгжрэл 90 мянган машин оргил цагийн үед л явж байгаа. Тэгэхээр бид нар Улаанбаатар хотын төлөвлөлтийн алдааг засах эхний.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Жигжидийн Ганбат, 83. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

**Ж.Ганбат:** Доржханд гишүүний асуултад хариулъя. 2024 оны төсвийн

тухай хуульд Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг бол 3.5 их наяд төгрөг байна гээд Улсын Их Хурлаас баталсан. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр өрийн дээд хязгаарыг заасан. Яг энэ хүрээндээ энэ асуудлыг бол Засгийн газар дээр бол авч үзсэн. Мөн Өрийн удирдлагын тухай хууль дээр Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчид тавих шаардлага гэж байдаг. Улсын Их Хурлаас зөвшөөрөл авсан тохиолдолд энэ шаардлагуудыг бол хотоос Сангийн яам бол бүрэн хангуулж бол ингэж бол ажиллана. Яг таны хэлж байгаатай бол санал нэг байгаа нь энэ бондын эргэн төлөлт гэдэг дээр бид бол онцгой анхаарна. Сангийн яамны ганц бид нарын бол болгоомжилж байгаа, анхаарах асуудлаар энэ бонд бол амжилттай нэгд гарах ёстой.

Хоёрт, эргэн төлөлтийн асуудал анх удаа гарч байгаа учраас эргэн төлөлт дээр нь бид бол онцгой анхаарч үүн дээр бол бүх баталгааг нь Сангийн яам хангуулж ингэж бол авна. Сая Засгийн газрын гаргасан бондуудын хүүг Засгийн газраас 18 оноос хойшоо зээлжих зэрэглэл бол ингээд тогтвортой бол мөрдөгдөж ирсэн. Гадаад, дотоод хүчин зүйлүүдээ тооцож үзээд бид аль болох энэ хотын бондыг бол амжилтаа гаргах, хүү бол мэдээж түрүүн дурдсанчлан бас дунджаар 7-8 хувьтай гарах болов уу гэдэг бол ийм төсөөллийг бол бид хийж байгаа. Тэгээд бид аль болох эрсдэлүүдийг Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу эрсдэлүүдийг бүгдийг нь тооцож үзээд аль болох л эрсдэлүүдийг гаргахгүй байх, эргэн төлөлтийг нь төлүүлдэг байх, санхүүгийн сахилга батыг бид ялангуяа онцгой анхаарч энэ бүгдийг зохион байгуулахаар ингэж ажиллаж байгаа.

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя. 1 минут.

**Т.Доржханд:** Тэгэхлээр үе үеийн хотын дарга нар энэ асуудлыг тавьдаг л байсан шүү дээ. Намайг Сангийн яаманд байхад бүх л хотын дарга нар тавьдаг байсан. Тэгэхлээр одоо энэ дээр бол ажлаа хийнэ гээд явж байгаа хүмүүсийг яалтай билээ. Гэхдээ нөгөө талд энэ санхүүгийн сахилга бат шүү дээ Сангийн яамныхан. Тодруулах зүйл байна. Та нар төгрөгийн бондыг гаднын хөрөнгө оруулагчдад зарна гэдэг ийм дил ярьсан уу? Өөрөөр хэлэх юм бол ханшийн эрсдэлийг бид нар өөр дээрээ бол хүлээж авах гээд байна шүү дээ нэг.

Хоёрдугаарт бүгдээрээ л мэдэж байгаа биз дээ Хөгжлийн банкны мөнгө яасан баталгаа гаргасан, байхгүй болсон, хулгайд явсан, энд сонсгол хийсэн, тэнд баахан иргэдээрээ хэлэлцүүлэг хийсэн. Үр дүнд нь арай л гэж дөнгөж сая Хөгжлийн банк өөрийнхөө мөнгөөр төллөө шүү дээ чааваас. Ийм нөхцөл байдал чинь давтагдахгүй гэх магадлал, баталгаа бол байхгүй. Өөрөө энэ чинь сахилга баттай салбар биш байхгүй юу. Биш шүү дээ. Сангийн яам бол маш их мэдэж байгаа. Тэгээд энэ тохиолдолд хувил.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна. Хариулт авъя. Хэн хариулах юм? Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч.

**Х.Нямбаатар:** Доржханд гишүүнээ энэ бид нарын өргөн барьж байгаа төсөл чинь төгрөгөөр гэдгийг валютаар гэж нэмж оруулж ирж байгаа шүү дээ. Яг манай төсөл. Ерөөсөө л ийм заалт байгаа. Тэгээд бид нар сая бас яг энэ чиглэлийн мэргэжилтнүүдтэй ажиллаад гаднын бас байгууллагуудтай энэ 2 сарын хугацаанд ажилласан. Ерөөсөө төгрөгөөр бонд гаргах тохиолдолд энэ хөрөнгө оруулагчид сонирхохгүй гэдгийг шууд илэрхийлсэн.

Тийм учраас бид нар ингээд гадаадад бонд гаргая л гэдэг ийм

агуулгаар өнөөдрийн энэ өөрчлөлт оруулж ирж байгаа. Түүрүүн би танд хэлсэн шүү дээ манайх дотооддоо төгрөгийн бонд гаргахад өөрийнх нь хүү өртөг нь 17.5 хувьтай байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар 17.5 хувьтай ийм юугаар барилгын төсөл хэрэгжүүлнэ гэдэг бол ямар ч боломжгүй. Тийм учраас бид нар сая Сангийн яам сая Америкт “Сенчеру III”-ыг амжилттай борлуулсан. 7.87-гоор борлуулсан. Тэгэхээр бид нар Засгийн газрын баталгаатай ийм орон нутгийн бондыг тэр түвшинд бас гарах болов уу гэж байгаа. Мөн тэр бонд дээр ажилласан хүмүүс бол танай орон нутгийн локал /local/ бондыг сонирхох ийм сонирхол тэр хөрөнгө оруулагчдад маш их байна гэдгийг бас хэлсэн байгаа. Яг энэ чиглэлээр л бид нар сая сүүлийн 2 сар гаран ажилласан гэдгээ хэлье.

Яагаад бас гадаад бонд гэж гаргаж байгаагийн гол агуулга нь барилгын төслүүд нийт худалдан авалтын бараг 70 орчим хувь нь импорттоор барилгын бараа материал худалдаж авдаг. Тэгэхээр ийм хэмжээний 20000 орчим орон сууцын төсөл хэрэгжүүлье гэхэд дандаа гадагшаа валют гарна. Дээр нь ханиш дээр бас хэлбэлзэл үүсэх эрсдэл байгаа учраас бид нар энэ эрсдэлийг бууруулж гадаад бонд гаргаж байгаа гэдгийг бас эцэст нь хэлье.

**Г.Занданшатар:** 2 удаа асуусан. Одоо болсон. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. чухал юм бол ингээд Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя 1 минут.

**Т.Доржханд:** Баярлалаа. Би уг нь санхүүгийн юм асуухлаар дундуур хотын дарга орж ирээд байна. Энэ Сангийн яамныхан хариулаадхаач. Энэ Азийн хөгжлийн банк тухайлбал 2008, 2009 онд Улаанбаатар хотын бондыг сонирхож байна. Гэхдээ төгрөгийн бондыг сонирхож байна, бид нар ийм санхүүгийн хэрэгслээ үүсгэчихлээ гээд уулзаж байсан

байхгүй юу. Олон улсын байгууллагууд дээр тийм платформ байдаг юм. Ганцхан асуудал нь наад хани чинь тогтворгүй байна, хани тогтворгүй валютын нөөц чинь хангалтгүй байна. Хангалтгүй байгаа болохлоор та нар тогтворжуулах боломжтой юу? Үүнийг ханшихаа баталгааг хийж чадах уу? Өөрөөр хэлэх юм бол ханшихаа тэр тохируулгыг хийж чадах уу гэдэг ийм л нөхцөлд асуудаг байсан байхгүй юу. Одоо тийм платформууд бол байгаа, санхүүгийн арга хэрэгслүүд байгаа. Миний асуугаад байгаа зүйл нь юу вэ гэхлээр та нар тийм яриа, хэлцлүүдийг хийсэн үү? Мэдээж бид нар төгрөгөөрөө бонд гаргах юм бол ханшийн эрсдэл хүлээхгүй байхгүй юу. Доллороор бонд гаргасан тохиолдолд, эсвэл “Панда бонд” иений бонд гаргасан тохиолдолд ханшийн.../минут дуусав./

**Г.Занданшатар:** 82, Одсүрэнгийн Номинчимэг.

**О.Номинчимэг:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Бид нар мэдээж энэ нөгөө “И Би Ар Ди”, “Ай Эф Си” гээд гаднын хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудтай бол уулзалтууд хийсэн. Тэд нарын хувьд мэдээж яг энэ нийгмийн ач холбогдолтой хүн иргэдийн амьдрах орчныг сайжруулах дээр нь бид нарын нөгөө төлөвлөж байгаа төсөл маань талбай дээр чөлөөлсөн газрынхаа 60 хувьд нь л барилгажилттай, 40 хувьд нь ногоон байгууламж нийтийн эдэлбэр газар нийгмийн суурь үйлчилгээг нь хангана гэсэн ийм концепцтой явж байгаа.

Тэгэхээр ийм төсөл, хөтөлбөрт нийгмийн чухал ач холбогдолтой төсөл дээр бонд гаргасан тохиолдолд бид нар оролцоход бэлэн байна гэсэн гол тавьж байгаа шаардлага маань төгрөгөөр байх юм бол ханшийн эрсдэл. Тэгэхээр та бас мэдээж байгаа байх хөрөнгө оруулагчдын хувьд төгрөгийн ханшийн эрсдэлийг өөрсдөө хүлээхгүй гэдэг байр сууриа илэрхийлдэг. Тэгэхээр доллороор болон

“И Би Ар Ди”-гийн хувьд еврогоор гаргасан тохиолдол бид нар оролцох их өндөр сонирхолтой байна гэсэн.

Нөгөө талаараа бид нарын хувьд гадаад үнэт цаас гаргаад хэрвээ доллороор гаргасан тохиолдолд энэ дээрээ бас бас ханшийн эрсдэлийг бууруулах хийхдээ ийм арга хэрэгслүүдийг бас мэдээж судална. Үүнийгээ бол бид нар энэ хууль маань батлагдаад санхүүгийн зөвлөх болон хуулийн зөвлөх албан ёсоор сонгож авсныхаа дараа эд нартайгаа бас өөрийнхөө төсвийн болон байгаа нөөц боломжийг харж байгаад энэ тооцооллуудыг хийхээр байгаа юм.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цугларъя. Санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цугларна. Одоо Байнгын хорооны саналаар энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны 7 гишүүн орж ирэх ёстой. Орж ирж байна. Нэг үлдсэн, Нямаагийн Энхболд гишүүн үлдсэн байна. Болчихсон. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

76 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул

төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно.

16.17 цаг.

**““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн. ““Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 12 сарын 2-ны 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолоор ““Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэл хангах санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулж, Улсын

Их Хурлын гишүүн Доржханд, Ганхуяг, Ундрэм, Цогтгэрэл, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа.

Тус Байнгын хороо тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Тус Байнгын хорооноос Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.27 дахь хэсэгт заасныг үндэслэн ““Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааны талаар авах авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд эрх зүйн дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын Тамгын газар тогтоолын төсөлд хийсэн эрх зүйн дүгнэлтээ танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг, Бат-Эрдэнэ, Ганхуяг, Ундрэм, Батлут нар “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компаниас ноогдол ашиг тараах эсэх талаар, тус компанийн өр төлбөрийн талаар асуулт асууж хариулт авсан бөгөөд дээрх тогтоолоор зохицуулагдах боломжгүй зарим асуудлыг Баялгийн сангийн тухай хуулийн төсөлд тусгах талаар саналаа хэллээ.

Байнгын хорооны хуралдаанаас ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал бүрийг хэлэлцэж тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн энгийн хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх, иргэдэд

олгосон хувьцааг тус компанийн энгийн хувьцаанд бүртгэх, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн төрийн мэдлийн хувьцаанд ноогдох ашгаас компанийн өр төлбөрийг барагдуулах зэрэг зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

““Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлт зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль зүйн бодлогын газрын дарга. Дондогмаа хаачсан юм? Тэнд байгаа юм уу? Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Жигжидийн Ганбат Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч, Онцгой бүрэн

эрхт төлөөлөгч, Баттулгын Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга, Эрдэнийн Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер, Хүүгийн Мөнхжаргал “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Туулын Төгөлдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга, Дамбын Нямдэлгэр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын референт.

Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

**Б.Пүрэвдорж:** Өнгөрсөн 2023 оны 12 сарын 12-ны Байнгын хорооны хурал дээр ер нь сарын өмнө гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ 3 сая 400 гаруй мянган иргэндээ “Эрдэнэс Тавантолгой”-н 2022 оны 1.3 их наяд, 23 оны 3 их наядын ашигтай ажиллах байх тэгээд тэндээсээ ингээд 4.3-аасаа 2 их наядыг нь 3 сая 500 мянга орчим мянган иргэндээ ноогдол ашиг болгож өгөх юм бол 580 мянган төгрөг өгөх боломжтой. Үүнийгээ 4 сарын сүүлээр өгнө гэж би хэлж байсан. Тэгэхээр энд тэр үед бол, одоо энэ “Эрдэнэс Тавантолгой” бол 2 сая 500 мянган иргэн хувьцаа эзэмшиж байгаа. Тэр үед 3 сая 500 мянган иргэндээ гэж хэлж байсан нь бол яг энэ тогтоол гарна. Тэгээд бүгд энэ иргэндээ ойролцоогоор хувьцаа тараах юм бол 580 мянган төгрөгийг өгнө гэдэг ийм л зүйлийг хэлж байсан. Тэгэхээр цагаан сарын өмнө өгөхгүй бол болохгүй.

Яагаад гэвэл 4 сарын 1-ээс цалин тэтгэвэр нэмэгдэх дээр барааны үнэд нөлөөл нөлөөлөөд эдийн засагт доржилт авчрах магадлалтай учраас энэ цагаан сарын өмнө өгөх ёстой гэж би ийм

шаардлага тавьж байгаа. Үүний дагуу 22 оны ашиг 120 мянган төгрөгийг цагаан сарын өмнө өгөх юм байна. Тэгээд 4 сарын сүүлээр бол 23 оны ашгийг тараана. Тэр үеэр 400, нийтдээ ингээд 450 мянган төгрөг л өгөх гэж байгаа юм байна л даа. Энэ 580 мянган төгрөг өгөх боломжтой шүү. 580 мянган төгрөг. 450-ийг өгчхөөд тэгээд орхино гэж байхгүй шүү. Би бол яг энэ өгөх боломжтой л мөнгө гэж үзэж байгаа. Өнгөрсөн олон жилүүдэд 2016 онд нэг ногдол ашиг тараасан. Өнгөрсөн 8 жилийн туршид энэ “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани 20 их наяд төгрөгийн 11 оффтейк гэрээг санхүүжүүлж маш их хөрөнгийг энэ дарга нарт ом том төслөөр хувааж идэх ийм боломж боломжийг гаргаж авсан. Одоо тэрний ямар ч хэрэггүй хөрөнгө оруулалтуудын нэг жишээ нь мухар төмөр замууд байна. Тээвэр тэргээр нь явдаггүй ийм л нөхцөл байдалтай байж байгаа. Тэгээд сүүлийн үед нүүрсний хулгайтай тэмцээний үр дүнд бас энэ нүүрсний экспорт нэмэгдэж байгаа.

Дээрээс нь амнаасаа 60 доллароор зардаг байсан энэ 60 долларын борлуулалт нь тухайн үед чинь 450 доллар дунджаар коксжсон нүүрс хүрч байлаа шүү дээ. Тэгэхэд л амнаасаа 60 доллароо зараад л хулгайлаад байдаг байсан. Тэгээд сүүлийн үед бол нүүрсний экспорт нэмэгдсэн. Дээрээс нь амнаасаа 179 доллар-оор борлуулж байгаа. Ийм сайн үр дүн гарч байгаа. Тийм учраас энэ сайн үр дүн гарч байгаа дээр нь ард иргэдэд бас энэ тодорхой хэмжээгээр энэ хувьцааны ногдол ашгийг олох энэ асуудлыг хийх ёстой.

Тэгэхдээ ингээд 120 мянга, тэгээд 450 мянга хүргээд л орхичихно гэж байхгүй шүү. 580 мянган төгрөгөө л нэхэж байж авна. 450-иа өгчхөөд ингээд зогсох юм 580-аа үлдсэн 130-ийг нь хэн хулгайлж байна, хэн хусаж байна гэдэг асуудлыг л ярина шүү дээ. Ийм л зүйлийг хэлмээр байна. Тэгэхээр ер нь бол Монгол ардын анм сонгууль дөхөөд ард түмэндээ

маш их хайртай болж байгаа. Өнгөрсөн хугацаанд бүх мөрийн хөтөлбөрөө бүгдийг нь мартсан. Тийм учраас өнөөдөр ингээд хэдэн төгрөг тоо хуваарилж байгаад бас сонгууль санал авах гэж энэ дөхөөд л энэ асуудлыг оруулж байна. Харамсаж байна. Өнгөрсөн хугацаанд маш их ашигтай ажиллах боломжтой байсныг нь хулгайлсан. Энэ бүх зүйл дээр.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Санал хэллээ Пүрэвдорж гишүүн. Санал хэлсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр би уг нь хувь хүнийхээ хувьд их өөдрөг гишүүн юм байгаа юм. Сайхан юм орж ирвэл өө улс орон маань хөгжих гэж байна аль болохоор л дэмжье гэж ханддаг ийм гишүүн. Сүүлийн үед бол бүүр байхгүй болсон бүүр. Ерөөсөө бүх юманд ингээд харддаг. Одоо юу оруулж ирэх гэж байгаа бол? Сонгууль дөхсөн хэний луйвар, хэний хуйвалдаан орж ирэх гэж байгаа бол, яаж сайхан юмны цаана ард түмнийг хулхидах гэж байгаа бол дандаа тийм юм боддог болсон. Яагаад гэхлээр хууль орж ирэхдээ энэ дэлхий дээр байгаа хамгийн сайхан жишиг, хамгийн сайхан туршилагыг бичиж орж ирдэг. Ийм болох гэж байгаа гээд л. Яг хэрэгжүүлэхдээ болохоор битүү хулгай, битүү луйвар, битүү хуйвалдаан болж орж ирж байгаа шүү дээ.

Тэгэхээр үнэндээ хэлэхэд ямарваа нэгэн юманд итгэхэд хэцүү болж байна. Мэдээж энэ зааланд байгаа бүх хүн л аль болохоор энэ ард иргэддээ хувьцааг өгье, ахиухан өгье л гэж бодож байгаа хүмүүс. Тэгээд ингээд замаас нь нөгөө дахин хуваарилах нэрээр дураараа уг нь иргэдэд чинь 1072 хувьцааг бол ингээд та нар бол хууль ёсны эзэн нь мөн гээд хэлчихсэн шүү дээ. Би бол ХОМ дээрээ хүртэл бичдэг. Гэтэл иргэд тэр хүмүүсээс нь асуухгүй та нар утаагүй түлш гээд л 1 их наяд, баахан мухар

төмөр зам гээд л хэчнээн их наяд юм гээд өгөөд байна шүү дээ.

Тийм учраас ерөөсөө энэ ард түмэн чинь та нарт энэ төрийн байгууллагад итгэхээ больсон, Их Хурлын гишүүдэд итгэхээ больсон. Сая Нүүрсний сонсголоор төрийн албан, төрийн байгууллагын тэр бичиг баримтуудыг яаж хайр найргүй устгадгийг иргэд сонссон. Яаж хэдэн их наядаар нь тэр бүх төрийн байгууллагуудтайгаа гааль хяналт, бүх юмтайгаа хуйвалдаж байгаад хулгайлж болдгийг иргэд сонссон. Энэ Улсын Их Хурлын сонсголоос сонссон. Тийм учраас үнэндээ хэлэхэд амьдрал бол бүрзгэр байна шүү. Ашиг дээр ярих юм бол жишээлэхэд 2014 онд Ардчилсан нам хэчнээн жил хэлэлцэж хэлэлцэж яг олон улсын стандартын нарийн царигтай төмөр замаар батлаад өгсөн шүү дээ энэ бодлогыг чинь. Тэр 2 Гашуунсухайт-Хангийн замыг чинь батлаад өгсөн.

Гэтэл 20 оны сонгуулийн өмнө Ардын нам олонхоороо л яг энэ заланд байж байгаа хүмүүс л кнопдоод л энэ нарийн царигийг өөрсдөө л унагасан шүү дээ. Хэрвээ үүнийг та нар тухайн үедээ зөв шийдвэр гаргасан бол өнөөдөр маш их боломжийг алдахгүй байх байсан. Тэгэхээр наанаа нэг юм ярьдаг, цаанаа дандаа хуйвалдаан. Тэгэхээр бол энэ юманд ерөөсөө итгэхээ больчихоод байна. Тэр ер нь бид нар энэ чинь компани юм уу, төрийн байгууллага юм уу гэдгээ маш сайн салах ёстой. Компани юм бол яг энэ олон улсынх нь жишигээр нь ажиллуулах ёстой, хөрөнгийн биржид бүртгүүлэх ёстой. Энэ 1072 хувьцаа чинь албан ёсны юмаараа баталгаажих ёстой. Хяналтын багц нь ард түмний мэдэлд байж байж энэ ард түмэн чинь өөрөө хяналт тавих боломж өгнө.

Тэгэхгүйгээр сая өнгөрсөн хугацаанд яав? Хэдэн дарга нар нь ТУЗ-ийн гишүүд нь хагартлаа баяжлаа шүү дээ. Хэчнээн их наядаар байр сууц, тендер юу, юу ч гэнэ үү. Зарим нь арай

дага өөр орон бүхэл бүтэн хороолол барилаа энэ тэр гээд л ярьсан. Тэгэхээр энэ ард түмэн чинь ядуураад бүүр үнэхээр тартагтаа тулж байна. Үндэсний статистикийн хороо олон улсын банктай хамтраад 2 жилд хийдэг ядуурлын судалгаагаа гаргахгүй байна шүү дээ. Энэ чинь юугаа нуугаад байдаг юм. Тийм учраас энэ ард иргэдээ энэ хувьцаанаас нь ахиухан олгох хэрэгтэй. Пүрэвдорж гишүүний ярьдаг энэ судалгаа бол их баримжаатай шүү, үндэслэлтэй. Тийм учраас энэ хувьцааг

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Гонгорын Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Ерөнхийдөө тэгээд муу нэртэй, муу данстай ул уурхайн салбар маань л биднийг тэжээх юм даа. Тэгээд үүнийгээ бас нэг их зөв явуулчихмаар байгаа юм. Энэ салбараас орж ирж байгаа орлогыг ард иргэдэд хүртээнэ, байгалийн баялгийг нийтийн хүртээмжид шударга хүргэнэ гэдэг ийм л уриатай бид нар ажиллаж байсан, сонгуульд оригоосон. Үүний нэг хэлбэр болж энэ 1072 хувьцааны хувьцааг ашгүй ард түмэнд нэг амсуулах шийдвэр рүүгээ хэдүүлээ явж байна. Өмнө нь явж байсан ажлууд яаж яваад байсан бэ гэхээр тойрч суусан хэдхэн хүн шийдээд юу болсон нь мэдэгдэхгүй, ТЭЗҮ нь батлагдаагүй, үнэн бодитой биш ийм ТЭЗҮ-тэй том хэмжээний төслүүд рүү хийгээд, тэгээд л төрийн тэргүүн нь баахан тэр үеийн төрийн тэргүүн нь баахан Пи Ар хийгээд л сая аудитын дүгнэлт гарсан. Урьдчилсан ТЭЗҮ-ээсээ бараг 4 дахин их үнээр хийгээд гүйцэтгэсэн Нөгөөдөх нь дуусаагүй.

Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Тавантолгой” компанийн ноогдол ашгийг хууль бусаар зарцуулаад тэгээд тэр нь хэд дахин өндөр үнээр шахагдчихсан ийм л юм руу орсон байсан. Тэгэхээр энэ удаагийн энэ ноогдол ашиг хуваарилалт эрх ч үгүй нэг юм Улсын Их Хурал руугаа орж ирээд хэлэлцэгдэж байна. Зэрэгцээ төсөв, улсын төсвөөс их мөнгийг л нэг

хэдхэн хүн хуваагаад л ингээд л. 10 төгрөгийн юмыг 40 төгрөгөөр шахаад л ингээд л бүтээн байгуулалт нэртэй юм хийгээд Үндэсний аудитын газраас гаргасан дүгнэлт нь ойрын ирээдүйд ашгаа өгөхгүй төслүүд рүү хийсэн байна гэдэг ийм л дүгнэлт гаргасан байсан шүү дээ. Үүнийг ямар хүмүүс хийснийг бүгдээрээ ард түмэн мэдэж байгаа. Нүүрсний хулгайн хамгийн том хэсэг энэ Эрдэнэс Тавантолгойн ноогдол ашгийг болсон, болоогүй тэр сонин төслүүд рүү хийж дамжуулж идэж уусан хүмүүсийн л асуудал байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ удаагийнх энэ Их Хурлаараа орж хэлэлцэгдэж байгаа нь сайн байна. “Эрдэнэс Монгол” нэгдлийн захирлуудаас нэг асуулт байна. Энэ жинхэнээсээ хэзээ хувьцаа болох юм бэ энэ 1072? Хэзээ хувьцаат компани болж Монголын хөрөнгийн бирж, олон улсын хөрөнгийн бирж дээр гарах юм бэ? Хэзээ арилжаалж болдог болох юм бэ? Хэзээ бэлэглэж болдог болох юм, хэзээ өвлүүлж болдог болох юм, хэзээ Монголын ард түмэн жинхэнэ хувьцаа эзэмшигч болж энэ компанийн үйл ажиллагааг бодитоор нь хянаж хэдэн төгрөгийн хувьцаа эзэмшихээ дарга нараас биш өөрсдөө хэдэн хувь төгрөгийн ноогдол ашиг авахаа өөрсдөө шийддэг болох юм бэ? Энэ өөрчлөлтийг л бид нар хиймээр байна шүү дээ. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт байгалийн баялаг хэзээ ч үнэ нь унаад, үнэ нь босоод ингээд явдаг байнга тогтмол байна гэж хэзээ ч байхгүй. 40 доллароор өгье 1 тонныг нь гээд хэн ч авахгүй байсан цаг үе байгаа шүү дээ угаасан нүүрсийг. Түүхий нүүрс битгий хэл. Тэгэхээр хэзээ нэгэн цагт ингээд унахад энэ компани өөрийгөө авч үлдэх энэ өр ширээ дарж байгаа юу? Сөхрөөд уначих юм биш биз дээ? Махыг нь идэх гээд үнээгээ алаад идчихмээргүй байна тийм ээ? Энэ өр шир дээрээ та нар анхаарч байгаа юм байгаа юу? Компания цаашаа тогтвортой авч явах тал дээр ямар анхаарал тавих юм бэ? Олон мянган жилээр, олон зуун

жилээр энэ ард түмэн энэ байгалийн баялгийнхаа үр өгөөжийг шударгаар, бодитой тодорхой хуртмээр байна. Түүнээс биш нэг гишүүн 560 гээд, нэг нь 440 гээд, нэг нь 230 гэж авдаг юм байхгүй. Зах зээл өөрөө үнээ тогтоогоод л явдаг байх ёстой л байхгүй юу. Энэ дээр нь хариулж өгөөч.

**Г.Занданшатар:** Наранцогт дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирал.

**С.Наранцогт:** Дамдинням гишүүний асуултад хариулъя. Хэзээ хувьцаа бодитой болох вэ гээд. Тэгээд 2010 оны 39-өөр яг хувьцааны хэлбэрийг нь зааж өгөөгүй. Тэгээд хязгаарлагдмал ийм эрхтэй хувьцаа гаргасан. Одоо энэ тогтоол дээр бол бид нар эхний заалтаар энэ 2012 оны 4 сарын 11-нээс хойш төрсөн иргэдэд шууд энгийн хувьцааг нь олгож байгаа.

Өөрөөр хэлбэл таны хэлж байгаа яг энэ сонгодог жинхэнэ хувьцаа гэсэн үг. Мөн өмнө нь үнэгүй олгосон хувьцааг энгийн хувьцаанд бүртгэх тухай заалт 2 дугаар заалт болж орж ирж байгаа. Ингээд бол энэ хувьцаа энэ тогтоол батлагдсанаар яг амьд хувьцаа болох ийм боломж нь бүрдэж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Хоёрдугаар асуудал дээр нь өр шир нь ямархуу байдалтай болж байна вэ гэхээр мэдээж энэ компанийн санхүүгийн үзүүлэлт сайжирч, өр ширнээсээ гарч байж бид нар IPO-д гарч хөрөнгийн зах зээл дээр хувиа гаргаж энэ Ашигт малтмалын хуульд заагдсан хувь хэмжээгээ хөрөнгийн зах зээл дээр гаргах энэ үүргээ биелүүлэх боломж бүрдэнэ. Өмнө нь бас хөрөнгийн зах дээр гарах гээд нэлээн оролдоод бас бүтэлгүйтсэн. Ийм юмыг бол та бүхэн мэдэж байгаа. Өр ширийг бууруулаад явж байна. Жилдээ 1 их наяд орчим төгрөгийн богино болоод урт хугацааны өр шир нийт дүнгээрээ багасаж ирж байгаа. Одоогоор үлд 4 их наяд төгрөгийн



хуримтлагдсан өр төлбөр байгаа. Энэ хуримтлагдсан өр төлбөр, өр авлагыг бас хүмүүс ингээд хольж ярьж байгаа.

Тийм учраас нэгдүгээрт 4 их наяд орчим төгрөгийн 3 дугаар улирлын байдлаар бол 3.9 их наяд төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр. Энэ нь ихэнх нь нөгөө урьдчилж худалдсан төлбөрийг нь авсан ийм өр төлбөрүүд байгаа.

Нөгөө талдаа энэ бас гишүүдийн шүүмжилж байгаа төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх замаар энэ тодорхой том төслүүдэд ингээд санхүүжилт хийгээд тэгээд энэ авлага нь нэг талдаа Эрдэнэс Тавантолгойн хувьд бол авлага, нөгөө талдаа төрийн өмчит компаниудын өр төлбөр болсон. Ийм 4.6 их наяд төгрөгийн асуудал байгаа. Тэгээд энэ ноогдол ашиг хуваарилсан тохиолдолд бол энэ бас төр засгийн шийдвэрээр гаргаад ингээд үүссэн өр авлагын асуудлыг бас цэгцэлж, энэ хооронд нь суутган тооцох эрхийг бас Улсын Их Хурлаас авч тэгээд энэ компаниудын энэ өр ширний асуудлыг бас цэгцлэх заалтыг ингээд 3 дугаар заалтаар нь оруулж ирж байгаа юм. Асуултад хариулж дууслаа.

**Л.Мөнхбаатар:** Дамдинням гишүүн тодруулах уу? Гонгорын Дамдинням гишүүн тодруулж асууя.

**Г.Дамдинням:** Тэгэхээр 4.6 их наяд төгрөгийнхөө 2.2-ыг нь төрд ноогдох хувьд ноогдол ашгаар нь хаачихъя л гэж байгаа юм байна шүү дээ тийм үү тээ? Тэгж ойлголоо. Тэгээд ер нь Наранцогт захирлаа бодит жинхэнэ хувьцаат компани болгоод, яваад хяналтыг тогтоож чадах юм бол иргэдийн хяналтыг оруулж чадах юм бол одоогийн бид нарын яриад байгаа мөнгөн дүнгээс ч их хэмжээний ногдол ашиг энэ иргэд авах бололцоотой шүү. Тэр чиглэл рүү нь бас энэ менежментээ чиглүүлж ил тод байдлыг хангаж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, мэдээллээ ил тод болгож, хулгай зэлгийгээс сэргийлж ажиллаарай гэж

захъя. Тэгээд Монголын ард түмэн ямар ч байсан энэ ийм байгалийн баялгаасаа үр шимээ хүртээд энд нэг хувьцаа байгаа юм байна гэдгээ нэг мэдэж авах нь энэ удаагийн хувьд бол маш том үр дүн шүү. Үүнийг бас нэг юм болгоодхоорой гэж захъя. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Дамдинням гишүүн үг хэллээ. Одоо Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Сайн байцаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Тогтоолын төсөлд бол энгийн хувьцааны асуудал орсон байгаа. Яах вэ энгийн хувьцаа иргэд эзэмидэг болсноор бол яг дагаад тэр эрхээ эдлэх үү, үгүй юү? Өмчлөх, шилжүүлэх өвлөх нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Нүүрсний сонсголоор 5.2 сая тонн нүүрсийг алдсан гэж би ойлгосон “Эрдэнэс Тавантолгой” компани. Тэгээд өнөөдрийг хүртэл компаниас бол ямар нэгэн байдлаар мэдээлэл мэдэгдэл, хэвлэлийн хурал хийсэнгүй. Байдаг зүйл мэт, эсвэл яг юу болох гэж байгаа нь тодорхой бус байгаад байдаг. Энэ дээр ямар арга хэмжээ авах талаар мэдээлэл сонсмоор байна. 5.2 сая тонн өнөөдрийн нүүрсний зах зээлийн ханшаар ойролцоогоор бол 750-800 сая доллар болж байна. Тэгэхээр энэ их хэмжээний мөнгө хэзээ, яаж Эрдэнэс Тавантолгойн дансанд хэзээ орж ирэх вэ? Энэ тэгээд хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт. Төмөр замтай холбоотой асуулт. Сая бүтээн байгуулалттай холбоотой асуудал дээр 2009 оны ТЭЗҮ-ээр 750 сая доллароор төмөр замаа бариад, холболтын цэгээ хийгээд, зөрлөгүүдээ бариад, дохиоллоо хийгээд, хөдлөх бүрэлдэхүүнээ аваад 750 сая доллар. Өнөөдөр хөдлөх бүрэлдэхүүн орохгүйгээр тэрбум гаруй доллар даваад явчихсан байна л даа. Тэгээд яг эцсийн байдлаар холбох цэг нь ороод яг ингээд ашиглаж болохоор төмөр зам гэдэг тийм дэд бүтэц маань өөрөө яг хэдээр

босох гээд байгаа юм? Тодорхой тоогоо нэг хэлээд өгөөч. Би өчигдөр Байнгын хороон дээр бас асуугаад хариултаа авсангүй.

Гуравдугаарт, Энэ ноогдолд ашигтай холбоотой асуудлыг бол ер нь бол жил болгон боломж нь байвал олгодог баймаар байна. Энэ 2 талын ач холбогдолтой.

Нэгдүгээрт, иргэд маань юмаа төлөвлөдөг байх боломжтой болно.

Хоёрдугаарт, үнэхээрийн энэ иргэд нь ноогдол хувьцаа эзэмшигч мөн юм бол жилд ядаж 1 удаа компани тайлангаа тавьдаг баймаар байна Эдийн засгийн байнгын хороон дээр. Энэ жил хэчнээн тонн нүүрс гаргасан юм, ямар ашигтай ажилласан юм, ямар өглөг, авлага байгаа юм?

Мөн нөгөө талдаа төр хувь эзэмшидэг болохоор төрийн ноогдох ноогдол ашиг маань тухайн хуулиараа нэг бол ирээдүйд өгөх сан юм уу, эсвэл төсөв рүүгээ тэр мөнгө нь ордог баймаар байна. Тэгээд тэр мөнгөөр нь Улсын Их Хурал нь юугаа хийхээ иргэдэд нээлттэйгээр хөрөнгө оруулалт бол хөрөнгө оруулалт, төсвийн зардал бол төсвийн зардал гээд ингээд тайлагнаад явдаг баймаар байна. Ингэж байж наад компани маань өөрөө бодит утгаараа шилэн, ил тод, нээлттэй, иргэд нь хувьцаа эзэмшидэг гэсэн ийм ойлголттой болох гээд байгаа юм.

Хамгийн сүүлд бол хэлэхэд бол би энэ саяын асуусан 3 асуултаа хариултаа аваад энэ Наранцог захирал, Ганбат захирал нар бол ер нь бол сайн ажилласан. Би бол энэ дээр бас яг иргэдэд бас хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Манай нүүрсний гаргалт ч тэр, экспортын орлого ч тэр хангалттай сайн өсөж байгаа. Энэ жил ч гэсэн өсөхөөр бас хандлагатай байгаа. Тэгэхээр энэ саяын асуултууд дээр хариултаа авчхаад, би тодруулъя.

**Л.Мөнхбаатар:** Хассуурийн Ганхуяг гишүүний асуултад хариулъя. 3 асуулт асууж байна. Тэр дээр нь сая асуугаад байгаа 5.2 сая тонн нүүрс гаалийн бүртгэлгүй гарсан тухай нэлээн шуугиан болж сонсголын үеэр яригдсан. Дараачид нь тухайн компанийнхан хэвлэл, мэдээлэл, дэлгэцэд бусад зүйлүүдээр ярьж байгааг нь харахаар нь шинжээчийн дүгнэлт бас буруу гарсан тухай мэдээлэл хийгдэж байна лээ. Тэгэхээр энэ нь яг аль нь зөв юм? Шинжээчийн дүгнэлт нь зөв гарсан юм уу, аль эсвэл тэр компанийнхны тайлбарлаад байгаагаар шинжээчийн дүгнэлт бас бүрэн дүүрэн гараагүйгээсээ болоод ийм ойлголтын зүү үүссэн юм уу гэдгийг нь бол их тодорхой хариулж, хариулт өгөх нь зүйтэй гэж бодож байна. Эдгээр асуултуудад хариулъя. Наранцогт дарга хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**С.Наранцогт:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Энэ энгийн хувьцаа ингээд болоод ирэхээр энгийн хувьцааны эрхүүд бүгд нээгдэнэ. Энэ тогтоолын ер нь агуулга нь бол ингээд Засгийн газарт эдгээр асуудлыг бүртгэх энэ ажлыг зохион байгуулахүүрэг өгөгдөж байгаа юм тогтоолоор. Тэгэхээр энэ бусад энэ энгийн хувьцаанд байдаг бүх эрхийг нээх, бүртгэх, ингээд зохион байгуулах ажлууд үргэлжлээд энэ тогтоол батлагдвал хийгдээд явчихна.

Тэгээд түрүүн бас Дамдинням гишүүн тодотгож хэлсэн иргэдийн хяналт, ил тод байдлыг сайжруулах гээд бид бас энэ компанийнхаа шинэчлэлийг нэгдлийн компаниудын шинэчлэлийг олон улсын сайн засаглалын түвшинд одоогийн байгаа хууль, дүрмийнхээ хүрээнд сайжруулах чиглэлээр нэлээд ажил хийж байгаа. Тэгээд тухайлах юм бол ТУЗ-ийн хэдийгээр иргэдийн маань хувь ингээд 27 хувьд хүрэхээр байгаа ч гэсэн хараат бус ТУЗ-ийн гишүүдийн тоог бол 49 хувьд хүргэсэн. Ингээд 11 байсан хуучин бол хараат бус гишүүний 3, 4 гишүүн байсан бол одоо 9 гишүүний 4

нь хараат бус гишүүн ингээд ажиллаж байгаа. Тэгээд тэр ажиллаж байгаа 4 гишүүнээ бол ний олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулсан. Бизнесийн нэлээн нэр хүндтэй салбарын бас туршилагатай ийм хүмүүс ажиллаж байгаа.

Тэгэхээр шийдвэр гаргалт, ил тод байдал нэлээдгүй сайжирч байгаа. Тэгээд цаашидаа энэ хувьцаа нь яг хөрөнгийн зах зээлд бирж дээр гараад үнэлгээ юм нь бодитой болоод ирэхлээр энэ таны ярьж байгаа яг энэ хувьцаа бодитоор амилаад явах ийм боломж нь энэ тогтоол батлагдсанаар бий болно гэж ингээж үзэж байгаа юм.

Тэр 2, 3 дугаар нүүрс, мухар төмөр замтай холбоотой асуудлыг Ганбат дарга хариулна.

**Л.Мөнхбаатар:** Ганбат даргын микрофоныг өгье. Ажлын хэсгийн 92 дугаар микрофоныг өгье.

**Ж.Ганбат:** Асуултад хариулъя. Тэр Нүүрсний сонсголын үеэр 5.2 сая тонн нүүрс дутсан асуудал бол яригдсан. Энэ сонсголын тайлан дээр бол энэ Цагаан хад бүсэд байрлах 36 нүүрс ачиж буулгах терминалын нүүний программд бүртгэгдсэн ажилчдын мэдээлэл болон Гаалийн ерөнхий газрын систем дэх гаалийн бүрдүүлэлтийн дотоод манифестын өгөгдлийг программ уншуулан тулган баталгаажуулалт хийхэд энэ дээр бол зөрүү 5.2 сая тонн нүүрсийг улсын хилээр гаалийн бүрдүүл...гаргасан байж болзошгүй байна гэж ингээж үзсэн. Энэ Нүүрсний сонсголын үеэр болон Нүүрсний сонсголын дараа худалдан авагчийн зүгээс “Эрдэнэс Тавантолгой” компанитай тулгалтыг хийсэн. Энэ тулгалтыг хийхэд бол энэ мэдээлэл ямар нэгэн байдлаар зөрүү үүсээгүй гэдэг ийм байдлаар ингэсэн. Бид мэдээллүүдийг бас дахиж нягталж, лавируулж үзэж байгаа.

Тэгэхээр энэ дээр бол яг ингээд дутсан гэдэг нь бол яг сонсголын тайлан дээр болзошгүй гэж бичсэн байгаа ийм байгаа. Бид тулгалт хийгээд энэ дээр бол зөрүү үүсээгүй байна. КОВИД-ын үеэр терминалаар дамжуулан гаргасан нүүрс байж болзошгүй гээд энэ дээр тооны мэдээллийн давхардал байна уу тэр программ ажиллахдаа давхардуулан татсан байна уу, зөрүү гаргасан гэдэг ийм асуудлууд яригдсан учраас үүнийг дахиж бид нар нягталж үзээд энэ талаар “Эрдэнэс Тавантолгой” компаниас албан ёсоор мэдээллийг олон нийтэд бол мэдээлэх болно гэдэг ийм байдлаар харж байгаа.

Нөгөө талдаа бид “Эрдэнэс Тавантолгой” компани дээр хэрэгжиж байгаа нийт 11 төсөл, хөтөлбөрүүд байгаа. Үүний нэг нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам байгаа. Энэ бол оффтейк гэрээ буюу төлбөрийг нь нүүрсээ барагдуулах ийм нөхцөлтэй хийгдэж байгаа гэрээ байгаа. Үүн дээр бид бол “Эрдэнэс Тавантолгой” компаниас энэ оффтейк гэрээтэй холбоотой, нүүрсээр төлбөр хийх гэрээнүүдийг өөрчлөх, дуусгавар болгох асуудлыг үе шаттай авч хэрэгжүүлээд одоо яг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам дээр нэг гэрээ үлдчихсэн байгаа. Энэ оффтейк гэрээний энэ бас гэрээ нь бол энэ 24 онд дуусгавар болоод тэгээд бид дахиж бол оффтейк гэрээ гэдэг асуудлуудыг бол “Эрдэнэс Тавантолгой” компани дээр үүсэхгүй. Мөн газрын тосны дамжуулах хоолой дээр бас энэ оффтейк гэрээний асуудал байгаа. Энэ дээр бид бас худалдан авагч талд хэлэлцээр хийх байдлаар ажиллаж байгаа.

Ер нь “Эрдэнэс Тавантолгой” компани дээр онцгой дэглэм тогтоосноос хойш ямар нэгэн байдлаар бид нүүрсээр төлбөр хийх ямар нэгэн гэрээ байгуулаагүй. Өмнө байгуулсан гэрээнүүдийг дуусгавар болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар илүү ингээж ажиллаж байсан.

Мөн нөгөө талдаа урьдчилж олсон орлого гээд мөнгийг нь урьдчилж авчхаад, дараа нь нүүрс төлөх төлбөртэй 603 сая ам.долларын ийм гэрээ байгуулсан байсан. Үүний төлбөрүүдийг 23 оны 9 сард бол бүрэн төлж барагдуулсан. Тэгээд үүний дараагаас эхлээд 23 оны 9 сараас хойшоо бол “Эрдэнэс Тавантолгой” компанийн борлуулж байгаа нүүрсний төлбөрүүд Монгол Улсад 100 хувь ордог болгосон ийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

**Л.Мөнхбаатар:** Энэ зүйлээ бас тодруулж асуумаар юм байна шүү дээ тээ Ганхуяг гишүүнээ. Нүүрсний сонсголын үеэр 5.2 сая тонн нүүрсийг гаалийн бүрдүүлэлтгүй гаргасан байна гээд яллаад томоохон асуудал болсон. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийт нэлээн цочирдсон. Хил гаалиа манай Монгол Улсын хил маань дархан байна уу, үгүй юү гэдэг асуудал яригдсан. Ер нь ингээд 5.2 сая тонн гэдэг чинь хоёр, гурван зуун мянган машин байх. Ингээд хилээр гараад явчихад нь Хятадын тал хүлээгээд хүлээгээд авчихдаг юм уу, үгүй юү гэдэг асуудлыг хүртэл ярьж байсан шүү дээ. Тэгээд энэ чинь бүрэн эрхт байдал, улсын хилийн хилийн аюулгүй байдалтай холбоотой ийм асуудлууд яригдсан байгаа юм.

Гэтэл өнөөдөр ингээд тулгалтыг хийгээд үзэхэд зөрүү гарахгүй байна гэдэг чинья мар ойлголт вэ? Энэ зүйлүүдийг бол Ганбаатар гуай тодорхой болгоод, олон нийтэд мэдээлэхгүй бол энэ чинь өөрөө ингээд. Хоёрдугаарт энэ шинжээч маань хэр үнэн, зөв энэ шинжээчийнхээ баримтыг судалж үзэж гаргасан бэ гэдэг асуудал бас яригдах нь байна шүү дээ тээ. Ингээд шинжээч буруу дүгнэлт гаргачих юм бол хэн яаж, ямар хариуцлага хүлээх вэ гээд ийм олон талаас нь ярих л асуудлууд байна даа Ганхуяг гишүүн хөндөж асууж ярьж байгаагаараа энэ асуудлаа тодорхой асуучих тийм ээ.

Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Саяын Мөнхбаатар даргын хэлсэнчлэн миний түрүүний асуултад яг бүрэн дүүрэн хариулт авчихмаар байна. Бодитой юм уу, бодьгүй юм уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Тэр алдсан 5.2 сая тонноос гадна ер нь яг Эрдэнэс Тавантолгой яг ямар хэмжээний ямар хохирол амсчихсан юм гэдгийг яг бодитой тоон илэрхийллээр „мөнгөн дүнгээр илэрхийлэл хэлээд өгөхгүй юү дээ. Тэгэхгүй бол 5.2 сая тонн гэдэг маань үндсэндээ бол 5200 ширхэг ачааны тэрэг гэсэн үг шүү дээ. 5200 ачааны машин ямар ч хяналтгүйгээр гараад явчихсан гэсэн байдлаар л ойлгогдсон байгаа юм. Нүүрсийг нь ачиж өгөөд хилээр хулгайгаар гаргачихсан гэдэг л ойлголт авсан байгаа би бол. Иргэд маань ч гэсэн тийм ойлголт байгаа. Тэгээд энэ дээр яг тодорхой хариулт авчихмаар байна.

Хоёрдугаарт энэ сая тэр яриад байгаа мухар төмөр зам яг бүрэн гүйцэт ашиглалтад ороход холбогдох цэгтэйгээ хамт яг хэчнээн доллароор энэ босож байгаа вэ? Энэ бид нарын хувь эзэн.../минут дуусав./

**Л.Мөнхбаатар:** Хассуурийн Ганхуяг гишүүний тодруулгад хариулъя. Ганбат дарга хариулах уу? Ажлын хэсгийн 92 дугаар микрофоныг өгье.

**Ж.Ганбат:** Эхний асуудал бол тэр Нүүрсний сонсголын шинжээчийн өгсөн дүгнэлтээр бол болзошгүй гэж биччихсэн байна лээ. Би сая тэр яг өгүүлбэрийг нь уншсан. Яг тэр тайланд тусгагдсанаар бол дутсан байж яах вэ ийм зөрүүтэй байдал үүссэн байж болзошгүй гэж үзээд, тэрнээс биш яг дутчихсан гэж бол хэлээгүй. Тэр нүүрсний сонсголын үеэр худалдан авагч тэр зөрүү үүссэн гэж яригдаад байгаа юмнууд бол “Эрдэнэс Тавантолгой” компани тулгалт хийж бол үзсэн. Бид дахиад нарийвчилж тэр КОВИД-ын үеийн юмнуудыг шалгаж

үзэж байгаа. Тэгээд энэ талаар албан ёсоор бол байр сууриа илэрхийлнэ гээд ингэж үзэж байгаа.

Төмөр замын төсөл, тэр хил дамнасан төмөр замын Тавантолгой-Гашуун сухайт төмөр замтай холбоотой мэдээлэл дээр мэдээлэл өгье. “Эрдэнэс Тавантолгой” компани дээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг бол санхүүжүүлэгч байдлаар бол оролцсон. Энэ дээр бол Тавантолгой-Зүүнбаян, нөгөөдөх нь бол Тавантолгой.../минут дуусав./

**Л.Мөнхбаатар:** Ганбат дарга гүйцээгээд хариулчихъя. 92 дугаар микрофоныг өгчих.

**Ж.Ганбат:** Тавантолгой-Гашуун сухайт төмөр замын төслийг бол санхүүжилт нь бол шаардлагатай 1.1 тэрбум 282 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар энэ төсөл боссон. Энэ дээр мөн, хоёр дахь нь Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян төмөр замыг холбох төмөр зам дээр бол нийтдээ шаардлагатай хөрөнгө оруулалт нь 218 тэрбум төгрөгийн ингэж шаардагдсан. энэ Тавантолгой”-Гашуунсухайт төмөр замын одоо энэ холболтгүйгээр одоо хийгдчихсэн бүтээн байгуулалтын ажил бол санхүүжилт нь ер нь одоо 46, 47 сая ам.доллар дутуу байгаа. Энэ бол зүтгүүр нь энэ онд ороод ирчих юм бол энэ ажил ингээд бүрэн дуусаад өөрөөр хэлэх юм бол 1.3 тэрбум ам.доллароор энэ төмөр замыг бол санхүүжүүлж “Эрдэнэс Тавантолгой” компани оффтейк гэрээ буюу нүүрсээр санхүүжүүлээд ингэсэн. Одоо үлдэгдэл 46 сая доллар үүний зүтгүүр нь ороод ирчих юм бол бүрэн санхүүжүүлээд энэ дуусчихна.

Төмөр замын холболтын ажил бол яг одоо энэ асуудлаар Улсын Их Хурлаас шийдвэр гарчихсан, Засгийн газар дээр бол энэ асуудал ярьж яг хэлэлцээрийн шатдаа явж байгаа. Энэ төмөр замын яг Гашуунсухайт чиглэлийн төмөр замын

төсөл дээр 800 гаруй тэрбум төгрөгөөр холболтын ажил бол хийгдэнэ гэж ингэж урьдчилсан байдлаар ТЭЗҮ, зураг төслийн юм нь яригдаад, үүнийг аудит оруулаад нягтлах байдлаар хийж байгаа. Энэ ажил 2 жилийн хугацаанд хийгдэнэ гэж ингэж тооцож байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хариулт болсон тиймээ Ганхяг гишүүн ээ? Тилеуханы Аубакир.

Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Сонгуулийн жил эхэлсэн. Одоо хэн нь илүү ард түмэндээ хайртай вэ гэдэг уралдааны ингээд эхлэлийн бэлтгэл хангасан ийм төслүүдийн л нэг, тогтоолуудын нэг ингээд хэлэлцэгдэх гэж байна л даа. Өнөө үндэстэй үндэстэй нь хамаагүй, цаана нь мөнгө байгаа эсэх нь хамаагүй хэн нь илүү ард түмэндээ хайртай вэ, хэн нь илүү мөнгө өгнө гэж хэлэх вэ? Одоо Тавантолгой дээр бараг л 100 хувь хувьцааг нь бүгдийг нь тараагаад өгчихье гэсэн хүн нь гоё л сонсогдоно. Нэг жил биш хэдэн жилийнх нь ашигийг нь урьдчилаад тараагаад өгчихье гэсэн хүн нь гоё л сонсогдоно. Яг л энэ нөгөө социалист уралдаан ингээд эхэлж байна. Социалист уралдаан. Бодит байдал дээр энэ компани маань 4 их наядын өр, алдагдалтай юун ноогдол ашиг, төлбөрийн чадвар, ноогдол ашиг өгчихсөний дараа олон зүйл байхгүй. Яг л нэг ноогдол ашиг гээд нэг зүйлд бэлдэж байгаа ухаан нь ноогдол ашиг гэдэг чинь уг амьд хувьцаатай, хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн хувьцаа дээр ноогдол ашиг, тэр өмч дээр ноогдол ашигийн тухай ярьдаг байх. Яг одоо 1072 гээд нэг бид нар гоёор яриад байгаа болохоос энэ яг үнэндээ зүгээр л халамжийн нэг бичилтийн данс болчихсон шүү дээ. Халамжийн данс. Байж байгаад нэг улс төрийн хэрэгцээ гарахлаар энэ халамжийн данс руугаа мөнгө хийдэг, үүнийгээ гоё хувьцаа, хувьцааны ноогдол ашиг олон юм ярьдаг. Тэгэхээр эндээс

жинхэнээсээ бид нар 10, 20 жил лав л 10 гаруй жил, 12 жилийн өмнө хоёр намын дарга Баяр, Элбэгдорж дарга нар амлаад л ийм л зүйл рүү бид нар ороод л халамжийн уралдаанд орж байсан. Яг энэ 12 жилд Монголын төр ер нь ямар сургамж авсан юм бол? Яг одоо энэ нөхцөл байдлыг дахин ингээд л хэлэлцээд сууж байна. Саяын хэлдэг дээр ерөөсөө л нэ социалист уралдаан.

Гэтэл сууриа засах чиглэлд, сууриа засах чиглэлд буюу үүнийг тогтоолоор биш, хуулиар энэ суурийг зөв зүйтэй бол энэ энэ компанийг засаглалтай болгох, менежменттэй болгох, хувьцаат компани болгох. Зөвхөн өнөөдөр ноогдол ашигийн тухай ингээд л яриа ярихад бэлтгээд хувь, хувьцааны тухай ярьж байна. Энэ компани дээр гарсан нь тэр их олон 10 сая тонн гэж яригддаг, олон 10 их наяд гэж яригддаг тэр мөнгөн дүнтэй хулгайн асуудал яг энэ менежментийнхээ хувьд засагдах бид нар ямар алхам хийлээ. Тэгэхээр хуулиар энэ бүхнийгээ бид нар өөрчилж засаж залахгүй юм уу? Хуулиар, тэр тусмаа Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар энэ бүгдийг чинь, энэ бүгдийг чинь засаж залах боломжийг олох байтугай бүүр үүрэгдчихсэн 2019 оны Үндсэн хуулийг дагасан тэр үзэл санаа тогтоол байгаа шүү дээ. Тэгэхээр тэрийгээ яагаад оруулж ирэхгүй байгаа юм бэ? Үндэсний баялгийн сангийн тухай хууль Ардчилсан намын бүлгээс өргөн барьсан, Засгийн газраас өргөн барина гэж ойлгосон. Үзэл баримтлал ойролцоо хэлэлцээд явахыг дэмжинэ гэж бид нар бас ойлгодог.

Тэгэхээр энэ суурь өөрчлөлтөө хийхгүйгээр яагаад энэ хуулиасаа түрүүлж энэ тогтоолоор энэ нэг ийм социалист хуралдааны бэлтгэл хангасан зүйл оруулж ирээд байгаа юм бэ гэдэгт л хариулт авмаар байна. Яагаад хуулиас, энэ хуулиас түрүүлж энэ орж ирэх энэ яг ач холбогдол нь юу юм? Ач холбогдол нь? Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг маш яаралтай, шаардлагатай бол ээлжит бус чуулганаар хэлэлцээд үүнийг

батлаад, тэгээд энэ асуудлаа зөв зүйтэй ном ёсных нь зөв дараалалд нь оруулъя л даа. Яг 12 жилд бид нар ямар ч сургамж авахгүйгээр яг 12 жилийн өмнөх тэр нэгэн хаврын цэг дээр бараг ингээд л зогсож байна шүү дээ. Тэгэхээр үүн дээр хариулт өгөөч.

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл даргын асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Баагаагийн Баттөмөр хариулъя. Ажлын хэсгээс дараа нь нэмж хариулж болно.

**Б.Баттөмөр:** Цогтгэрэл гишүүнтэй санал нэг байна. Энэ баялгийн үр өгөөжийн асуудал, баялгийн менежментийн асуудал ярьж байна л даа. Ер нь ардчилал зах зээлийн нийгэмд шилжсэн энэ гучин хоёр, гурван жилийн хугацаанд энэ баялгаасаа ард иргэд олгодог юм бол ер нь төрөөс өөрөөр хэлбэл ард иргэд олгож байгаа энэ хувьцааны ашиг бол энэ баялгаас, “Эрдэнэс Тавантолгой”-оос л олгож байгаа шүү дээ. Өөр одоо би санахгүй байна.

Тэгэхээр баялгийн менежментээ их зөв хийх ёстой. Бид нар бол худалдаа хийж чадахгүй байгаа. Баялаг ашиглах бодлого тодорхойгүй байгаа. Баялгийг хэнд өгдөг вэ гэхээр нэгдүгээрт нь мэргэжлийн, хоёрдугаарт нь хөрөнгийн биржид бүртгэлтэй, гуравдугаарт санхүүгийн чадвартай ийм компаниуд өгдөг. Манайхан бол тэр чигээрээ ингээд тараачихсан. Тэр нь яг наймааны хэрэгсэл болчихсон ингээж явж байгаа юм.

Тийм учраас бол Цогтгэрэл гишүүнтэй санал нэг байна. Баялгийн менежментээ маш сайн хийх ёстой, баялгаа зөв ашиглах ёстой. Баялгаа тэр дэлхийн зах зээлийн үнэд биш гэхэд бол бүс нутгийн үнэд хүрч худалддаг энэ саналтай бол санал нэг байна. Энэ Баялгийн сан одоогийн хуулийг яаралтай гэж батлах ёстой. Ардчилсан намаас тусгаар тогтнол гээд Баялгийн сангийн

хуулийг өргөн барьчихсан байгаа. Ардын намаас бол өргөн барьж байна одоо. Шаардлагатай Цогтгэрэл дарга та Ардчилсан намын бүлгийн даргын хувьд бол ээлжит бус чуулган хийе. Хэзээ байдаг юм тэрийг нь ярьж байгаад ээлжит чуулган хийгээд ганц асуудал хэлэлцэнэ. Энэ бол Баялгийн сангийн хуулийг батлах асуудал.

Баялгийн сангийн хуулийн өмнө яагаад энэ тогтоол орж ирж байна гэж. 2012 онд Монголын хүн ам 2 сая 500 мянга байж. 2 сая 500 мянган хүнд 1072 хувьцаа эзэмшүүлсэн. Үүнээс хойш өнөөдөр хүртэл 1 сая 5 мянган хүүхэд мэндэлсэн байна. Энэ хүүхдүүд өнөөдөр хувьцаа байхгүй. Тийм учраас юу гэхээр бид энэ Баялгийн сангийн хуулийн өмнө Монголын 3.5 сая хүн 1072 хувьцаа эзэмшигч байх ёстой хуулийн ижил тэнцүү нөхцөл байдлыг үүсгэхийн тулд энэ төслийг оруулж ирж байгаа юм. Энэ төсөл дотор мөнгө өгнө ингэнэ, тэгнэ гэсэн юм байхгүй. Баялгийн сангийн хууль тэрийг дагалдаж гарах, тэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дагалдаж гарах хуулиуд дээр 2022, 2023 оны ноогдол ашгаас 1072 хувьцаа эзэмшиж байгаа Монголын 3 сая 500 иргэнд хэдэн төгрөг өгөх вэ гэдгийг бол тэр үед тэр хуулийн хүрээнд шийднэ. Энэ энэ 10 хэдэн жил болчихсон байгаа энэ хувьцаагаа авч чадаагүй энэ хүүхдүүдийн асуудлыг шийдэж байгаа юм. Ийм учиртай юм. Үүнийг өнөөдөр ингээд хэлчихье гэж. Тэр бүртгэлтэй гээд сая яригдаад байна. Энд энэ хуулийн 2 дахь заалт нь бүртгэлтэй болгоё. Энгийн хувьцаагаа энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн баланст бүртгэлтэй болгоё. Ингэснээрээ энэ хувьцаагаа захиран зарцуулдаг, өвлүүлдэг, ингээд цаашаа дамжаад тэр хөрөнгийн бирж дээр гардаг энэ бүх эрх зүйн орчнууд нь ингээд бүрдэж байгаа юм. Ийм 2 заалттай.

Гурав дахь нь юу вэ гэхээр өнөөдөр сая ярьж байгаа тэр 3.9 их наяд төгрөгийн өр байна энэ бол тэр Монголын төмөр зам, Тавантолгой түли

гээд энэ бол өөр юм байна лээ. Тэрийг улс зүгээр бичилт энэ тэр хийх боломжууд юу байдаг юм? Ингээд энэ санхүүгийн асуудлыг нь бас давхар авч үзэх нь зүйтэй юм гэдэг ийм 3 заалттай л.../минут дуусав./

**Л.Мөнхбаатар:** Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундрам:** 2010 онд Улсын Их Хурлын тогтоол гараад иргэдэд энэ 1072 хувьцааг эзэмшүүлэх шийдвэр гараад 10 хэдэн жил болж байна. Тэгээд үүнээс хойш зарим нэгэн Монгол Улсын иргэд янз бүрийн хэлбэрээр тодорхой хэмжээний хувьцааны үр шимийг хүртсэн бол бас нэлээн олон иргэд огт хүртээгүй. Тэгээд 12 оноос хойш төрсөн сая орчим хүүхдийн асуудал гээд ер нь маш олон зүйл нь ингээд хуримтлагдаад, замбараагүй болчихсон.

Дээрээс нь компани өчнөөн оффтейк гэрээ, нүүрсний хулгай гээд маш тийм дамнуу байдалд орчихсон байсныг цэгцлэх хамгийн бодитой тогтоол өнөөдөр орж ирж байгаа юм. Энэ цэгцлэх тогтоолын арим гишүүд бас анзаарахгүй байж магадгүй. Гол зүйл нь энэ энгийн хувьцаанд бүртгэнэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Хувьцаа бол давуу эрхийн хувьцаа, энгийн хувьцаа гэсэн 2 төрөлтэй байгаа шүү дээ. Тэгээд өмнөх тогтоолууд үүнийг нь аль нь юм бэ гэдгийг тодорхой зааж өгөөгүй. Үүнээс үүдэж ойлголтын зөрөөнүүд үүсээд, тэгээд яах нь тодорхойгүй байгаад байсан бол өнөөдөр энэ ажлын хэсэг энгийн хувьцаанд бүртгэнэ гэж асуудал оруулж ирж байгаа юм. Энгийн хувьцаанд бүртгэнэ гэж энэ тогтоол гарснаар иргэд жинхэнээсээ өмчөө өмчлөх тэр эрх нь үүсэж байгаа. Тэр үүднээсээ энэ хувьцаагаа цаашид Баялгийн сангийн хуулийн дагуу эзэмших, өвлүүлэх, арилжсаалах, шилжүүлэх гээд ийм өмчийн харилцаанд орох бүрэн боломжтой болж байгаа. Тэгээд энэ ноогдол ашгийн асуудлыг гишүүд бүгд ярьж байна. Мэдээж Улсын Их Хурлын

гишүүний хувьд үүнийг өгөх ёстой гээд өнөөдөр энэ чуулган дээр хэлэхээс өөр аргагүй, хэлж байгаа. Би ч гэсэн бас өгөх ёстой гэдэг байр суурь дээр байгаа.

Гэхдээ энэ бол компанийн ТУЗ нь ишийдэх ёстой асуудал. Компанийнхаа тухай хуулиар. Тэгэхээр энэ төрийг төлөөлж тэр ТУЗ-д сууж байгаа хүмүүс 2023 оны тайлан аудитаар орсны дараа энэ хувьцаа эзэмшигчдийн ноогдол ашигийг тодорхой өр төлбөрөө төлсний үндсэн дээр өр төлбөрөө бүгдийг нь төлбөл ноогдол ашиг тарааж чадахгүй л дээ. Тэгэхдээ өр төлбөрийг бас ингээд тодорхой хугацаанд төлж болох учраас заримыг нь төлөөд үлдсэнийг нь ноогдол ашиг хэлбэрээр иргэддээ өгөх ёстой. Яагаад энэ ноогдол ашигийг өнөөдөр өгөх ёстой гэж хэлж байгаа вэ гэхээр ноогдол ашиг авснаараа иргэд хувьцаа эзэмшигч юм гэдгээ бүрэн дүүрэн мэдрээд, ойлгоод энэ компанид тавих хяналт нь сайжрах юм.

Тийм учраас гишүүд заавал энэ сонгууль болох гээд байгаадаа ч биш. Тэгээд ер нь цаашид бол энэ компанийн тайланг олон нийтэд нээлттэй бас жилдээ 1 тавьж байх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ улсын чинь бүх иргэн 1072 хувьцаа эзэмшиж байна шүү дээ. Эзэмшигчийнхээ хувьд компанийн тайланг нээлттэй хараад, ойлгоод энгийн хүмүүст ойлгогдох байдлаар тайланг телевиз, олон нийтийн сүлжээ ашиглаад тавиад, мөн мэдээж ард иргэдийг төлөөлж байгаа Их Хурлын гишүүдэд энэ Эдийн засгийн байнгын хороогоороо ч юм уу дамжуулаад тайлангаа тавиад ингээд явах юм бол хүмүүсийн хяналт сайжирна.

Цаашид мөн энэ компани энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлаа энэ компани хариуцаад, хөөцөлдөөд араас нь хуульчдын багаа ажиллуулаад энэ цагдаа, прокурортой ажиллах хэрэгтэй. Шүүх дээр ч гэсэн. Тэгэхээр яг үүнийг өмчийн эзний өмнөөс хариуцаж байгаагийн хувьд та бүхэн үүнийхээ

араас явах ёстой шүү. Тэгж байж тэр алдагдсан мөнгө төгрөгөө олж авч, буцаж энэ компанийн өр төлбөрт тодорхой хувийг нь бас зарцуулах ёстой гэсэн ийм байр суурь.../минут дуусав./

**Л.Мөнхбаатар:** Ундрам гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ерөнхийдөө санал хэлчэв үү? Тогтоолын талаарх санал хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг. Одоо Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя. Энхтүвшин гишүүн, Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Дараа нь Бат-Эрдэнэ гишүүн.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Би энэ ажлын хэсэгт орж ажилласан байж байгаа Баттөмөр даргаар ахлуулсан. Энэ Байнгын хорооны тогтоолын гол ач холбогдол нь бол Монгол Улсын иргэн бүрд 1072 хувьцааг эзэмшүүлэх ийм л зүйлийг бол нэлээн тод томруун тусаж өгсөн ийм ач холбогдолтой. Ихэнх гишүүд маань бас энэ хувь хувьцааны энэ ноогдол ашигын талаар бас яриад байх шиг байж байна. Энэ ноогдол ашигийг тараах асуудал бол тухайн компанийн ТУЗ, тухайн компани л өөрсдөө ишийдээд явах асуудал байж байгаа.

Хоёр дахь асуудал бол юу гэдэг юм “Эрдэнэс Тавантолгой” ашигтай ажилласан. Цаашидаа “Эрдэнэс Тавантолгой”-н үйл ажиллагаа бол тогтвортой байх ёстой, хөрөнгө мөнгөний чадалтай байх ёстой. Тийм учраас ашигтай ажилласан мөнгөөрөө “Эрдэнэс Тавантолгой” дээр үүссэн өр авлагаа бас барагдуулах, мөн төрийн өмчтэй “Шивээ-Овоо” ч гэдэг юм уу, Багануур дээр үүссэн өр, авлагаа барагдуулах энэ ажил дээр бас чиглэлүүд өгсөн ийм тогтоол байж байгаа юм. Чиглэл өгсөн. Тэгэхгүй бол “Эрдэнэс Тавантолгой” дээр үүссэн өр, авлагууд бол дандаа л Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хурлаар гаргасан шийдвэрүүдийг бас хэрэгжүүлснийхээ төлөө “Эрдэнэс Тавантолгой” бол асар



их өртэй болсон байж байгаа. Өртэй болсон байж байгаа.

Тийм учраас цаашидаа бол бид нар энэ төрийн өмчит компани тогтвортой, ашигтай ажиллуулахын тулд энэ өр, авлагыг энэ ашигаараа бас төлж барагдуулах, өр, авлагаа багасгах энэ үйл ажиллагааг бас хэрэгжүүлж яваач л гэдэг ийм заалтыг Байнгын хорооны тогтоол дээр бас хийж өгсөн байж байгаа.

Цаашидаа бол Баялгийн сангийн тухай хуулиа бид нар яаралтай батлах хэрэгтэй. Баялгийн сангийн тухай хуулиа. Баялгийн сангийн тухай хууль дээр тэр хөрөнгийн сантай холбоотой заалтууд байж байгаа. Тийм учраас тэр баялгийн сангаараа дамжуулаад тэр хөрөнгө оруулалтын асуудлаа шийддэг, Баялгийн сангаараа дамжуулаад бусад томоохон хэмжээний төслөө хэрэгжүүлдэг ийм чиглэл рүү л бид нар явах ёстой. Тэгэхгүй ингээд янз янзын шийдвэр гаргадаг, төмөр зам ч барьж л байдаг, баяжуулах болон боловсруулах үйлдвэр барьж л байж байдаг гээд. Мөн Улаанбаатар түлш гээд түлшний томоохон хэмжээний өр, авлагыг энэ компани хариуцаад явж л байдаг. Төрийн өмчтэй бусад компаниудын өр авлагыг хариуцаад явж байдаг гээд бүхий л төрийн өмчтэй компаниудын бүх хөрөнгө, мөнгөний асуудлыг л зөвхөн энэ “Эрдэнэс Тавантолгой” дээр бүгдийг нь ингэж овоолсноос болоод ийм их өр, авлага л ингээд үүссэн байж байгаа юм.

Тийм учраас үүнийг цэгцэлье, энэ компанийг цаашидаа тогтвортой ажиллая. Ер нь цаашидаа энэ төрийн өмчтэй компаниудаа бас нэгтгэж, нийлүүлж, тогтвортой ажиллах ийм бололцоо, боломжийг нь хангаж өгье л гэдэг л ийм тогтоол байгаа юм гэдгийг бас хэлмээр байна. Тэгээд би өөрөө ажлын хэсэгт орж ажилласан учир энэ зарим хүмүүсийн асуусан асуултад ингээд давхар бас хариулаад явж байгаа

юм шүү гэдгийг бас хэлмээр байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Энхтүвшин дарга эд нарын, та нарын орсон ажлын хэсгийн санал 6 санал байгаа. Нэг гишүүн үг хэлсний, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Одоо Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ асуултаа асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тогтоолын төслийг дэмжиж байгаа, дэмжиж байгаа. Би түрүүн бас чуулганы чуулган эхлэхэд хэлсэн дээ. Ер нь энэ тогтоолын төсөлтэй холбоотой асуудал чинь анхлан энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль анх батлагдсантай холбоотойгоор, түүнийг дагаж гарсан Монгол Улсын Их Хурлын тогтоолтой холбоотойгоор энэ асуудал ингэж орж ирж байна гэж ойлгож байгаа. Тэгээд би энэ тогтоолынхоо төслийг өөрөөр хэлбэл энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг боловсруулсан, боловсруулах явцад, хэлэлцүүлэх явцад бид нар энэ нүүрстэй холбоотой асуудал, тэгээд “Эрдэнэс Тавантолгой” компанийн үйл ажиллагааг сайжруулах, цаашидаа үр өгөөжийг сайжруулж, ноогдол ашгийг олгох асуудлууд нэлээн яригдсан юм байхгүй юу даа. Энэ чинь ч бүтэн жилийн өмнө ярьсан асуудал шүү дээ.

Тэгээд үүний дагуу наадах анхан шатынх нь зүйл нь та бүхэн ингээд орж ирж байна. Энэ асуудлуудыг дэвшүүлээд орж ирж байвал сайн байна. Ганцхан нэг асуудлыг хаячихлаа гэж би яриад байгаа байхгүй юу даа. Би энэ тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Энд нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэ-д даалгасгай гэж байгаа юм. Үүн дотроо “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэхэд, эзэмших хүрээнд 2012 оны

4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьца эзэмшүүлэх асуудлыг судалж, 2023 оны 1 дүгээр улиралд багтааж Улсын Их Хуралд оруулж ир гэсэн. 1 дүгээр улиралд багтааж орж ир гэсэн. Одоо орж ирж байна тийм үү? Энэ бол бүүр 24 ондоо орж ирж байна шүү дээ бараг л. Нэг.

Хоёрдугаарт, 21, 22 онуудад гэж байгаа шүү. 21, 22 онуудад 1072 хувьцааны ноогдол ашгаа авч чадаагүй иргэдэд хувьцааны ноогдол ашгийг нөхөн олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх гэж байгаа. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэе. Би яагаад үүнийг Баттөмөр гишүүн маш сайн өөрөө мэдэж байгаа. Бид хамт хамт сууж байгаад энэ Уул уурхайн биржийн тухай хуулийг баталсан. Бид нар ажлын хэсгийг ахалсан, энэ Монгол Улсад нэлээн том эдийн засагт нөлөө бүхий ийм хуулийг нь баталж өгсөн. Үүнийг дагаад саяын энэ миний уншсан энэ тогтоолын төслийг бид нар гаргасан шүү дээ. Та өөрөө мэдэж байгаа байхгүй юу. Маш ач холбогдолтой тогтоолын төсөл. Ганцхан энэ дотор нөгөө зүйл маань үлдчихээд байгаа байхгүй юу. Ард иргэдэд ноогдол ашгийг олго гэсэн зүйл маань олгох асуудлыг шийдвэрлэх гэдэг асуудал маань үлдчихээд байгаа юм. Тэгэхээр яг энэ тогтоолын төслийн дагуу өнөөдөр та бүхний Засгийн газар тогтоолоо төслөө ингээд боловсруулаад жилийн дараа оруулж ирж байна нэгдүгээрт хоцорчихсон байна.

Хоёрдугаарт, нөхөн олговрыг хувьцаа ноогдол ашгийг олго, шийдвэрлэ гэсэн асуудал маань яагаад хаягдчихав, яагаад үлдчихэв? Одоо хэзээ шийдэх юм бэ? Улсын Их Хурал үүнийгээ авч хэлэлцээч. Өнөөдөр бид нар энэ ноогдол ашгаа олгох шаардлагатай байна. Өчнөөн хууль юмнууд үзээд хууль зөрчөөд нүүрсний хулгай энэ тэрээ гээд л сонсгол эд нар гээд өчнөөн олон зүйлүүд чинь ил тод болчихоод байдаг. Гэтэл ард

иргэдээсээ л атганаад 5 төгрөг харамлаад байдаг гэдэг чинь юу вэ, ямар учиртай юм бэ гэдэг асуудлыг л би тавиад байгаа байхгүй юу даа. Тийм болохоор энэ дээр бас Баттөмөр гишүүн тодорхой хариулж өгөөч. Та бидний санал нэг байгаа. Энэ хууль дээр хамт суусан. Гагцхүү хэзээ дараагийнх нь энэ заалт шийдвэрлэгдэх юм бэ гэдэг тал дээр би танаас асуулт асуугаад байгаа юм шүү. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн ахлагч Баагаагийн Баттөмөр гишүүн хариулъя Тэгээд санал хураалт явагдана гишүүд байраа эзэлье.

**Б.Баттөмөр:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энд Монголын эдийн засагт маш том өөрчлөлт авч ирсэн хууль бол Уул уурхайн биржийн хууль. Энэ дээр Бат-Эрдэнэ гишүүн бид нар яг хамтарч сууж, үүнийг хийсэн. Яг 2023 он гэхэд нийт экспортод гарч байгаа нүүрснээс 12.5 сая тонн бүс нутгийн зах зээлийн үнэд хүргэж худалдсан. Энэ болгоны үр дүнд Монгол Улсын санхүүгийн дансууд ашигтай гарсан. Тэгээд цаашаагаа төлбөрийн тэнцэл ашигтай, төсөв ашигтай, Монгол улсын валютын нөөц 5 тэрбум доллар болсон. Үүний шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм бол энэ Уул уурхайн биржийн хууль юм. Үүнийг бид нар хамтарч гаргасан. Үүнийг хэлье. Энэ ноогдол ашгийн юмыг үүгээр шийдээгүй юм. Энэ яах вэ гэхээр зэрэг байна шүү дээ. Энэ Үндсэн хуулийн 6.2-т бидний өөрчлөлт оруулсан сая 19 онд өөрчлөлт оруулсан энэ 6.2-т энэ стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлнэ, түүний өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гээд ингээд заачихсан.

Тэгэхээр энэ тогтоолоор бол тэр ноогдол ашгийн асуудлыг хөндөж болохгүй байгаа. Тийм учраас би түрүүн Цогтгэрэл гишүүний асуултад

хариулахдаа хэлсэн. Ингээд чуулган маргааш завсарлалаа гэхдээ энэ ээлжит бус чуулган хийгээд ард иргэдэд энэ ноогдол ашгийг нь олгох эрх зүйн үндсийг нь бүрдүүлье. Ингэж би Улсын Их Хурлын гишүүдэд уриалж байна. Хуулиар үүнийг тогтоохгүй бол энэ тогтоолоор тогтоож болохгүй байгаа. Үүнийг Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хуульчдын дүгнэлтэд бас тэгээд гарчихсан байгаа.

Тийм учраас Баялгийн сангийн хуулиа баталъя, тэгээд тэрийг дагаж мөрдөх хуулиа хууль дээрээ энэ ноогдол ашгийг олгох, тэгээд цаашаага тэр хувьцаагаа худалдсан хүмүүс байгаа тэрний асуудлыг шийдэх. Тэгээд цаашаага юу вэ гэхээр зэрэг үүнийг тэр энгийн, бүртгэлтэй ийм хувьцаа болгох, хөрөнгийн бирж дээр арилжаалах энэ бүхий эрх зүйн үндэсүүдийг нь тэр Баялгийн сангийн хуулиараа шийдье гэж. Энэ тогтоолын ач холбогдол бол юу вэ гэхээр 2 сая 500 мянган хүн бол хувьцаатай, 1 сая хүүхэд хувьцаагүй байгаа. Тийм учраас 1 сая хүнийг нь хувьцаатай болгоод Монголын 3.5 сая хүн бүгд жигд 1072 хувьцаатай болж байгаа энэ эрх зүйн үндсийг өнөөдөр энэ тогтоолоор бүрдүүлж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя, 1 минут.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тийм тийм. Баттөмөр гишүүн наад хажууд чинь үймүүлээд байгаа Чинзориг гишүүн ч гэсэн бид нар хамт гурвуулаа, хэдүүлээ сууж байгаад энэ асуудлыг дэвшүүлсэн шүү дээ. Тийм дэвшүүлсэн юм байгаа юм. Тийм ярих боломжийг маань олгочихвол зүгээр байна.

Тэгэхээр хамгийн гол нь Засгийн газар яагаад энэ асуудлуудыг оруулж ирсэнгүй гэдгийг л би яриад байгаа байхгүй юу даа. Яагаад жилийн дараа энэ асуудлуудыг оруулж ирсэн мөртлөө жилийн дараа, эхний улиралд оруулж ир

гэснийг жилийн дараа оруулж ирчхээд байна?

Хоёрдугаарт ноогдол ашиг олох асуудлыг “Эрдэнэс Тавантолгой” компани ТУЗ-аараа шийдчих байхгүй юу даа. Энэ жил чинь 3 их наяд гаран төгрөгийн ашигтай ажилласан гээ биз дээ? Үүнийгээ ядаж 1.5-ыг нь эд нар өгөх боломж бололцоо байхгүй юм уу? Яагаад үүнийгээ ингээд шийдчихээгүй юм, яагаад Засгийн газар үүнийгээ оруулж ирчхээгүй юм бэ гэдэг асуудлыг л би яриад байгаа байхгүй юу даа. Одоо өгөх асуудал нь болчихсон шүү дээ. Өгөх хугацаа чинь болчихсон. Өгөх, энэ чинь 2012 оноос хойш бид нарт чихэр юу гэдэг билээ шилний цаанаас чихэр долоолгосоор байгаад одоо энэ чинь 10 хэдэн жил болчихлоо шүү дээ. Тийм болохоор одоо өгөх цаг нь болчихоод байна. Тийм болохоор энэ асуудлаа

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 6 санал байгаа. Үг байхгүй ээ. Зарчмын зөрүүтэй санал дээр үг хэлж бол болно. Гишүүд танхимдаа байраа эзэлье. Санал хураалт явагдана.

Төсвийн байнгын хорооны гишүүд орж ирлээ. Төсвийн байнгын хороо хуралдаж байгаа. Санал хураалт явагдана. Гишүүд байраа эзлээрэй.

““Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг холбогдох

хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын нийт иргэдэд адил тэнцүү хэмжээгээр эзэмшүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, Ганхуяг, Доржханд, Оюунчимэг, Ундрам, Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэнэ/ санал хураалт явуулъя.

**Г.Занданшатар:** 65.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 1072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хурааа.

Дэмжиж хэлэх үү, дэмжихгүй үг хэлэх юм уу? Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ шүү дээ. Дэмжихгүй үг. Адьшаа гишүүн дэмжихгүй үг хэлнэ.

**Ш.Адьяа:** Дэмжиж үг хэлж байгаа шүү. Та бас ийм...болиорой.

**Г.Занданшатар:** Та өөрөө дэмжихгүй үг хэлнэ гэж хэлчээд.

**Ш.Адьяа:** Үүнийг энэ Улсын Их Хурлын тогтоолын Засгийн газраас оруулж ирсэн үүнийг дэмжиж байгаа юм. Тэгэхдээ энэ Улсын Их Хурал дээр би бас энд энэ хувьцааг нь худалдаж авсан сая гаруй хүний хувьцааны асуудлыг л оруулж ир гэхээр нь оруулж ирэхгүй байгаа юм. Энэ зөв зүйтэй. Ингээж Монгол Улсынхаа ард иргэдийг байгалийн баялгийн үндсэн хуулийн 6.2-т заасан үүний дагуу энэ стратеги ордуудын хувьцааг эзэмшүүлэх нь энэ Монгол

Улсын төрийн үүрэг. Үүнтэй санал нэг байгаа. Үүнийг дэмжиж байгаа.

Тэгэхдээ тэр 12 онд, 16 онд Монгол Улсынхаа сая гаруй иргэний хувьцааг Монголын төр сонгууль бүрийн өмнө мэдээлэл, дутуу хөрөнгө мөнгөний боломжгүй байдлыг далимдуулан авчихсан байгаа ийм асуудал байгаа юм. Энэ асуудлыг нь шийдэх тогтоолын төсөл өргөн бариад энэ нь ерөөсөө хэлэлцэгдэхгүй байна. Үүнтэй хамт яагаад шийдэх боломж байхгүй байсан юм бол доо гэж бодож байна. Эдийн засгийн байнгын хороогоор энэ ороод хэлэлцэгдсэн асуудал байна шүү дээ. Тэгээд одоо 50 хэд хоноод, тэгээд л үүнийг оруулж ирж өгдөггүй ийм л их хүнд байдалд оруулчихаад л байгаа юм. Тэгэхлээр энэ асуудлыг Баттөмөр даргад би олон удаа ярьсан, Цэрэнпунцаг дарга ч бас ярьж л байсан. Тэгээд энэ 1 сая гаруй иргэнээ нэг өмч хөрөнгөтэй болгох асуудлыг л үүнийг шийдэж өгөөч гэж ингээд л гуйгаад байгаа юм. Хэлэлцээд өгөөч гээд.

Тэгэхлээр энэ үнэгүй авъя гээгүй. Өнөөдөр 500 гаруй мянган төгрөг байна гэж байна шүү дээ нэгж хувьцааны үнэ. Тэгэхлээр энд 300 мянган төгрөгөөр ахмадууд өгсөн, сургуулилтын төлбөр гээд л энэ асуудлууд байгаа шүү дээ. Энд нь суутгаад шийдье л гэдэг ийм шийдлийг л яриад байгаа байхгүй юу.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулъя. Энэ шинээр төрсөн иргэдэд хувьцаа эзэмшүүлэх тухай энэ тухай саналтай холбоогүй санал хэлж байна. Санал хураалт явуулъя.

Ер нь сонгуулийн жил болохоор их хайр зарлаж байна. Тэгэхдээ Сонгуулийн тухай хуулийн 48.2-т билүү заасан хишиг хувьцаа амлах, санал болгох байна шүү дээ. Үгүй одоо, сонгуулийн жил эхэлснээс хойш гэж байгаа юм. Одоо ярих асуудал ярьж байгаа юм. Одоо ярьж байгаа чинь өөрөө Сонгуулийн хууль зөрчиж байгаа шүү гэдгийг би бол хэлчихье.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр олгосон “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг тус компанийн энгийн хувьцаанд бүртгэх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн эрх бүхий этгээд ноогдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, “Эрдэнэс Монгол” нэгдлийн болон бусад төрийн өмчит оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр, авлагад суутган тооцох;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

70.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхдээ бас Адьшаа гишүүнийг гүйдгийг ойлгох хэрэгтэй юм байна шүү. Төрөлх нутаг руугаа гүйж байгаа гэсэн үг.

5.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

6.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ эхний ээлжид 20 хүртэлх хувь гэсэн зөвхөн тэр хэсгийг хасах юмыг тэр 39 дүгээр тогтоолыг бас тэр чигээр нь хүчингүй болгочих юм бол эрх зүйн үр дагавар үүснэ гэж байгаа юм. Тамгын газар энэ дээр сайн үзэх хэрэгтэй. Тийм учраас тэр 20 хувиас дээш болчхож

байгаа учраас тэр үед эхний ээлжид 20 хувийг хувьцаалсан, одоо хорин долоо, найман хувь болж байгаа юм. Тэгэхээр үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгчихье.

Тэгэхээр зөвхөн тэр 39.2 дахь заалтыг хүчингүй болгох гэдгээр явсан.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Байгаа. Одоо 15 асуудлаас 3-д оруулсан.

““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Их асуудалтай чухал тогтоолыг бас.

17.30 цаг.

**Хэлэлцэх асуудал дөрөв.Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Яах уу хойшлуулах. Төслийн анхны хэлэлцүүлгийн явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төмөртогоогийн Энхтүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

**Т.Энхтүвшин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хууль, хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад

хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тулд Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг

Сандагдоржийн Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хүчитбаатарын Итгэлт тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын газрын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Сүхээгийн Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга.

Асуулт байхгүй байна. Тэгээд Байнгын хороо Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасан байна.

Үүнийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Төсвийн байнгын хорооныхон санал хураалтад ор. Баттөмөр Цэрэнпунцаг 2 гишүүн суудалдаа суувал хүрэх гэж байна. Санал хураалтад бэлтгэе. Адьшаа гишүүнээ тэнд 3 суудал эзгүй байгаа 1 суудлыг тэнд шилжүүлж өгч болж байна. Санал хураалт. Дэлгэрсайхан гишүүн гүйгээрэй. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Амжсангүй гэж байхгүй. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Би сая энэ нойтон юм барьчихсан чинь ерөөсөө арчиж амжилгүй ерөөсөө ажилласангүй. Энэ цай барьж байгаад. Тийм болохоор дахиж явуулж өгөөч л гэж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтыг хүчингүй болгож байж л.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тийм, хүчингүй болгож өгөөч гэж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя. Хөөе гишүүд. Санал хураалтыг Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний саналаар хүчингүйд тооцох санал хураалт явуулна. Гишүүд анхаарал тавья. Санал хураалт.

Санал дэмжигдлээ. Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хүчингүй болгох саналыг олонх дэмжлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулна.

Анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

54.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

17.38 цаг.

**Иргэний нисэхийн тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшин танилцуулна. Индэрт хүрч байна.

**Т.Энхтүвшин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг хэлэлцэж шийдвэрлэж төслийн анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал гараагүй тулд Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ажлын хэсгийн гишүүд дээр

нэг хүн нэмэгдсэн чинь нэрээ өгөөгүй байна шүү. Асуулт, хариулт алга байна.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт хариулт байхгүй тул Байнгын хороо Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжсэе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт Пүрэвдорж гишүүнээ.

58.7 хувийн санал саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

17.41 цаг.

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Цэндийн Мөнх-Оргил гишүүн ажлын хэсгийн ахлагчийг дуудъя. Байхгүй бол төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Хууль зүйн байнгын хорооны хорооны дарга Дамдины Цогтбаатар танилцуулна.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

**Г.Занданшатар:** Ганбаатар сайд, Жамбалын Ганбаатар сайд гишүүн. .../ үг тасрав.

**Д.Цогтбаатар:** Хууль зүйн байнгын хорооны хороо 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бол болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурал чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 1 санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 2 санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрроос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын та бүхэнд хүргүүлсэн болно.



Улсын Их Хурлын эрхэм гишүүд  
ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Хууль зүйн байнгын хорооны хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Батаагийн Батцэрэн? Алга байна. Мөнхөөгийн Пүрэвсүрэн? Алга байна. Батзэвэгийн Энхболд? Энхболд Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн хаачсан юм? Максимын Чинбат? Алга байна. Отгонбаярын Мөнхбаатар? Алга байна. Ганзоригийн Эрдэнэбулган, Дашийн Энхтөр, Лхамдоржийн Нямдаваа, Баттөмөрийн Батсуурь, Энэбишийн Бадамсамбуу, Хүрэлбаатар Эрдэм-Ундрах, Шагдарсүрэнгийн Цолмон, Бадамын Батзориг? Байгаа нь энэ Лхагвын Данзанноров байсан байна. Доржсүрэнгийн Батсүх Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, гишүүн хоёр ирсэн байна.

Энэ ажлын хэсгийн гишүүдийн талаас илүү нь байхгүй байгаа учраас хойшлуулдаг юм уу Мөнх-Оргил гишүүнээ? Ингээд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүд байхгүй байна. Энэ Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын Хууль зүйн байнгын хороо дэмжсэн 2 саналаар санал хураалт явуулъя. Энэ чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заалтын дагуу буюу хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу боловсруулсан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 11, 12 дахь хэсэг болгох:

“11.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй. Санал гаргасан Хууль зүйн байнгын хорооны хороо. Санал хураалт.

60.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “19.14/Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/,” гэсний дараа “19.18/ Ард нийтийн санал асуулга хууль бусаар явуулах/,” гэж, “20.2/ Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/,” гэсний дараа “20.19 /Улсын онц чухал объект, онц чухал мэдээллийн дэд бүтцийн байгууллага, байгууламжийн үйл ажиллагаанд саад учруулах/, гэж,”

гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хууль зүйн байнгын хорооны хорооны дэмжсэн санал.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хорооны хороо. Санал хураалт.

63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хорооны хороонд шилжүүлж байна.

Маргааш хуулиудыг эцэслэн батална. Дараагийн асуудалд оръё .

17.48 цаг.

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Хууль зүйн байнгын хорооны хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хорооны хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны хороо 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 1 санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын

зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хургүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар танилцуулгыг Хууль зүйн байнгын хорооны хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Яг тэр чигээр нь 1 санал болгоод л оруулаад ирсэн учраас үүнийг хойшлуулах уу? Ер нь бас энэ эрүү, иргэний хэрэг дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хөрөнгийг нь тусгаарлахгүй бол ингээд баахан, нэн ялангуяа иргэний хэрэг дээр ч гэсэн ингээд явж явж байгаад хөрөнгө нь байхгүй болчихдог. Тэгээд шүүхийн шийдвэр хөрөнгө байхгүй, дансыг нь царцаагаагүй, битүүмжлээгүй, тэгээд сүүлд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хувь бага байдаг. Тэрийг удаан үе шаттай шүүхийн процессоор явцаах хооронд хөрөнгийг нь нуудаг, дарагдуулдаг энэ процессыг уул нь, бас оруулна энэ тэр гэж ярьж байсан. Оруулаагүй л юм байна лээ л дээ. Асуулттай гишүүн байхгүй юу? Ажлын хэсэг.

Нямдаваагийн Баярмаа Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч.

**Л.Мөнхбаатар:** Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Эрдэнэбулган чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар бүлэг нэмсүгэй:

#### “ДОЛДУГААР БҮЛЭГ

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

75<sup>1</sup> дүгээр зүйл.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг

75<sup>1</sup>.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75<sup>1</sup>.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75<sup>1</sup>.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75<sup>1</sup>.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75<sup>1</sup>.2.Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75<sup>1</sup>.2.2.энэ хуулийн 75<sup>1</sup>.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75<sup>1</sup>.2.3.ажилд эргүүлэн тогтоосон, эгүүлэн тогтоосон гэж байгаа тээ? хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75<sup>1</sup>.3.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75<sup>1</sup>.4.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75<sup>1</sup>.5.Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

**75<sup>2</sup> дугаар зүйл.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа**

75<sup>2</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.2.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх

нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75<sup>2</sup>.3.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75<sup>2</sup>.4.Энэ хуулийн 75<sup>2</sup>.3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

**75<sup>3</sup> дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах**

75<sup>3</sup>.1.Шүүгч энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75<sup>3</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup> дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75<sup>4</sup>.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75<sup>3</sup>.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

**75<sup>4</sup> дүгээр зүйл.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх**

75<sup>4</sup>.1.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75<sup>4</sup>.2.Энэ хуулийн 75<sup>4</sup>.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75<sup>4</sup>.3.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75<sup>4</sup>.4.Энэ хуулийн 75<sup>4</sup>.2, 75<sup>4</sup>.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

**75<sup>5</sup> дугаар зүйл.Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох**

75<sup>5</sup>.1.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан

шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75<sup>5</sup>.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75<sup>5</sup>.3.Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75<sup>5</sup>.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75<sup>5</sup>.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75<sup>5</sup>.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

**75<sup>6</sup> дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг**

75<sup>6</sup>.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан

гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.3.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75<sup>6</sup>.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

**75<sup>7</sup> дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх**

**ажиллагаа үргэлжлэх**

75<sup>7</sup>.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75<sup>7</sup>.1.1.Нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75<sup>7</sup>.1.2.Тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75<sup>7</sup>.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75<sup>7</sup>.3.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75<sup>7</sup>.4.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

**75<sup>8</sup> дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх**

75<sup>8</sup>.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

**75<sup>9</sup> дүгээр зүйл.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн**

**шүүхийн шийдвэр**

75<sup>9</sup>.1.Энэ хуулийн 75<sup>7</sup>.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75<sup>1</sup>.1, 75<sup>1</sup>.2-т заасан хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75<sup>9</sup>.2.Энэ хуулийн 75<sup>9</sup>.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75<sup>9</sup>.3.Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 119 дүгээр зүйлд заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75<sup>9</sup>.4.Энэ хуулийн 75<sup>9</sup>.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

**75<sup>10</sup> дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх**

75<sup>10</sup>.1.Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлиггүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

**75<sup>11</sup> дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах**

18.07 цаг.

75<sup>11.1</sup>. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75<sup>9.3</sup>-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75<sup>11.2</sup>. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт явагдана. Гишүүд байраа эзэлье. 1 зүйл болгоод хийчихсэн юм байна шүү дээ Мөнх-Оргил сайд аа. Нэлээн ойлгомжтой болсон байх шиг байна. Өмнө нь бол нэлээн гишүүдийн шүүмжлэл нэлээн өрнөсөн. Ойлгомжгүй зүйлүүд бас нэлээн их байсан. Тодорхойгүй зүйлүүд, тодруулах зүйлүүд нэлээн байсан. Эдгээрийгээ бол нэгтгээд 1 зүйл болгоод санал хураалтыг явуулж байгаа юм байна. Гишүүд байраа эзэлье. 1 л санал хураалт байгаа.

Саналын томъёолол уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүд ээ.

**56.1 хувиар санал дэмжигдлээ.**

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийнхаа асуудалд оръё. Дараагийнхаа асуудалд оръё гишүүд ээ,

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 45.5-д заасныг баримтлан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хорооноос боловсруулан анхны хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хийлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуулийн төслийн хэрэгжих хугацаатай холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцэн батлах шаардлагатай талаар Байнгын хороодын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй

холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг баримтлан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Батаагийн Батцэрэн, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн

хэргийн танхимын шүүгч Мөнхөөгийн Пүрэвсүрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль зүйн газрын шадар зөвлөх Максимын Чинбат, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Батзэвэгийн Энхболд, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Отгонбаярын Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ганзоригийн Эрдэнэбулган, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Дашийн Энхтөр, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Лхамдоржийн Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга, цагдаагийн хурандаа Баттөмөрийн Батсуурь, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Энэбишийн Бадамсамбуу, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Монголын криминологичдын холбооны Удирдах зөвлөлийн дарга, доктор, профессор Бадамын Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Лхагвын Данзанноров, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч асан, өмгөөлөгч Доржсүрэнгийн Батсүх нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их хурлын гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хороо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд ээ.

54.8 хувиар санал дэмжигдлээ.



Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

Ингэхдээ Чинзориг гишүүний хэлж байгаа саналуудыг Мөнх-Оргил гишүүн бас анхаарна биз ээ. Дараагийнхаа асуудалд оръё.

18.12 цаг.

**“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг баримтлан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль зүйн байнгын хорооноос боловсруулан анхны хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хийлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс “Хуулийн төсөлтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж хэлэлцэн батлах шаардлагатай гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж уг тогтоолын төслийг боловсруулсан.

Тогтоолын төсөлд хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруу зохих зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах, шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулдаг үндэслэл нөхцөл боломжийг бий болгож байгаа хуулийн хийдлийг судалж, түүнийг арилгах, зохицуулалтыг боловсронгуй болгох, хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, түүнийг үнэлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах, Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах, хүн ямар хэрэгт ялагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж ялагдагчаар татсан тогтоолыг гардуулан өгөх зохицуулалтыг хуульд тусгах зэрэг асуудлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн боловсруулж 2024 оны 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болголоо.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хорооноос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн тогтолцоог бүрдүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах талаар тогтоолын төсөлд тусгах нь чухал талаар, мөн шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах нь давтан гэмт хэрэг байнга үйлддэг гэмт этгээдийг цагдан хорих хугацааг тоолох асуудлыг нэг мөр цэгцлэх зэрэг ач холбогдолтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчээр дуудан байцаалт авах, ялах дүгнэлтийг танилцуулах зэрэг ажиллагаа нь практикт хүний эрхийг зөрчиж буй талаар, мөн тогтоолыг хэрэгжүүлэхэд уг асуудлыг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд тогтоолыг хэрэгжүүлэх хугацааны талаар, мөн тогтоолын дагуу төслийг боловсруулахдаа асуудалд бодитой хандаж хүний эрхийг зөрчихгүй байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан тогтоолын төсөлд туссан өмгөөлөгчийн эрх, үүргийг баталгаажуулах асуудлыг анхааралдаа авах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх асуудалд анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Адьшаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг олон хохирогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг боловсронгуй болгох талаар, мөн хэргийг тусгаарлах, нэгтгэх явцад үүсэж байгаа асуудлын талаар саналаа илэрхийлж уг хэлсэн болно.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 83.3 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явах үед тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. 18 цаг болсон байна. Гэхдээ өнөөдөр хэлэлцэх асуудлууд олон бий. Одоо нийтдээ 7 асуудал байна уу тээ? 6 асуудал байна. Тийм учраас чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлэх цагийг сунгаж байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух

*Их хурлын гишүүн байна уу? Байхгүй байна.*

*Содномын Чинзориг гишүүн үг хэлье.*

**С.Чинзориг:** Энэ Мөнх-Оргил гишүүнээс л асууя. Энэ “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” гээд Их Хурлын тогтоол гаргах гэж байгаа юм байна л даа. Тэгэхээр одоо тэгээд ер нь цаашид ийм жишиг тогтох юм уу? Нэг хууль батлуулаа, батлаад тэгээд хууль баталсантай холбогдуулах арга хэмжээ гээд л ингээд л юм авдаг л даа. Энэ чинь Хууль батлагдсантай холбогдуулж авах арга хэмжээний тухай гээд бүтэц юм уу, тогтолцоо өөрчлөлттэй холбоотой, төсөвтэй холбоотой юмаар бараг л бол ийм тогтоол гаргаж л байдаг л даа.

Тэгээд одоо энэ тогтоолын чинь төслийг харахлаар Мөнх-Оргил гишүүнээ хуулийг боловсронгуй болгох чиглэлээр ийм ийм зохицуулалтуудыг хийж, хууль боловсруулж оруулж иргээд л ийм л юм үүрэг өгөөд байна шүү дээ. Үүнийг заавал ингээж Их Хурлын тогтоол гаргаж ингээж хийх юм уу? Эсвэл Засгийн газар, Хууль зүйн яам энэ хуульдаа өөрчлөлт оруулах шаардлагатай бол тэгээд л тэр хуулиа боловсруулаад л, Засгийн газраараа оруулаад л Их Хуралд оруулна л биз дээ? Эсвэл энэ Хууль зүйн сайдынхаа ажилд энэ Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн дарга нар нь хэт оролцоод байгаа юм уу? Засгийн газрын үйл ажиллагаанд бас хэт оролцох оролцож байгаа юм уу, эсвэл энэ яам нь юмаа хийхгүй болохлоор ингээд хүчээр энэ Байнгын хороо нь үүрэг, даалгавар өгч ийм юмыг хий гэж байгаа юм уу? Энэ чинь тэгээд ийм нэг сонин юм руу л явлаа шүү дээ.

Одоо үүнийг чинь дагаад бүх Байнгын хороо ингээд нэг тогтоол гаргаад л сайд нарыг, Засгийн газрыг ийм ажлыг хий, ийм хуулийн төсөл оруулж ир, ийм зохицуулалтаа нарийвчилж

орүүлж ир гээд л ингээд л үүрэг өгөөд байх юм уу? Би бол энэ тогтоол гарах шаардлагагүй юм шүү л гэж л ойлгоод байна шүү дээ. Тэгээд үүнийг яагаад ийм тогтоолд ингээд оруулж ирж байгаа юм? Шаардлагатай гэвэл тэр хуулиуддаа өөрчлөлт оруулах асуудлаа Засгийн газар нь, Хууль зүйн яаманд боловсруулаад л оруулаад л ирнэ биз дээ. Тэгээд ерөөсөө удаа дахин ийм үүрэг өгөөд, хийхгүй байгаа учраас ингээж байгаа юм уу? Би бол нэг их л тийм сайхан зөв юм бол биш л гэж харах гээд байна л даа. Тэгээд манай Хууль зүйн байнгын хорооны дарга сайн бас анзаарч байгаа байлгүй дээ.

**Л.Мөнхбаатар:** Дэгээрээ дэмжсэн эсхүл дэмжээгүй 3 хүртэлх гишүүн үг хэлж болдог. Сая та бол дэмжээгүйг үг хэлж байна тийм ээ? Одоо асуулт, хариулт бол байхгүй. Үг хэлж болно. Цэндийн Мөнх-Оргил гишүүн үг хэлье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ яагаад ийм тогтоолын төсөл боловсруулах шаардлага гарчав гэхлээр гишүүд ээ сая бид нарын эцсийн хэлэлцүүлэг хийж баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь Засгийн газраас нэмэлт, өөрчлөлтөөр өргөн баригдчихсан байхгүй юу. Засгийн газраас нэмэлт, өөрчлөлтөөр өргөн баригдсан учраас өөр заалтуудад нь ажлын хэсэг, Их Хурал засвар хийж болохгүй болчихоод байгаа юм.

Гэхдээ ямар шаардлага үүссэн гэхлээр сая бид нарын баталсан тэр нэмэлт, өөрчлөлтүүдтэй яг уялдаж байгаа бас олон заалтууд энэ дотор явж байгаа байхгүй юу. Шууд уялдаж байгаа юм. Жишээ нь тэр өмгөөлөгчтэй байцаалт авах асуудлыг бид нар бол жишээ нь баривчилгааны шүүхээр хэлэлцүүлэхэд заавал өмгөөлөгчтэй байх зохицуулалтууд оруулчхаж байгаа юм.

Гэтэл үүнтэйгээ уялдаад өмгөөлөгчөө яг хэзээ, хаана байлгаж

байх вэ, яаж оролцуулах вэ, бусад үйл ажиллагаанд нь яаж оролцуулах вэ, хэргийн материалтай нь яаж танилцуулах вэ, хавтаст хэрэгтэй нь яаж танилцуулах вэ, энэ шүүх хуралдааныг удаа дараа янз бүрийн шалтгаанаар хойшлуулдаг энэ үндэслэлүүдийг арилгах шаардлага гарч байгаа юм. Гэх мэтийн энэ нөгөө баталсан хуультай маань шууд уялдаж гарч ирж байгаа заалтуудыг л бид нар энд тусгачхаад байгаа юм. Тэгээд энэ ажлын хэсгээс боловсруулаад, Байнгын хорооноос дэмжсэн тогтоолын төслийг бол Засгийн газар дэмжиж байгаа. Энхбаяр сайд Байнгын хорооны хуралдаан дээр үг хэлэхдээ энэ заалтуудыг бол Засгийн газар дэмжиж байгаа. Хуулийн төслийг бололцоогоороо цаг хугацаанд нь багтааж боловсруулж оруулж ирнэ гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл бүхэлдээ эрүүгийн процесс илүү хүний эрхийг хангах талдаа, яллах, өмгөөлөх үйл ажиллагаа 2 талдаа тэнцвэржих чиглэлийг л барьж байна гэж ойлгох хэрэгтэй. Баярлалаа. Дэмжиж өгөхийг хүсэж байна.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Гишүүд байраа эзлээрэй. Байнгын хороо “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн. саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд ээ.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул тогтоолын төслийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөлтэй хамт эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

Ажлын хэсэг, гишүүдэд баярлалаа. Хамтад нь батлах нь байна шүү дээ тийм ээ? Дараагийнхаа асуудалд оръё гишүүд.

18.23 цаг.

**Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ундрам нарын 6 гишүүнээс 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Болорчулуун, Бат-Эрдэнэ нар асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж ажлын хэсгийн гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 3 саналаар санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Наранбаатар гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Засгийн газрын Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мэндбаярын Дондогдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав, баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Даваагийн Тунгалаг, Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн профессор, доктор Нямдаваагийн Отгонсайхан, Тогтвортой хөдөө аж ахуй төслийн мэргэжилтэн Балганы Алтанцэцэг нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр асуултаа асууя. Асуулт биш, үг хэлье. Асуулт авч болно. Тийм, асуултаа асууя.

**Б.Энхбаяр:** Баярлалаа. Энэ органик бүтээгдэхүүнийг хэрэглэдэг байх, үүний хэрэглээг дэмжих төрийн бодлогыг бол дэмжиж байгаа. Би энэ хэлэлцэх эсэх асуудлыг ярьж байх үед асууж байсан юм. Ялангуяа энэ хуулиар татварын, гаалийн хөнгөлөлтүүд бас нэлээн үзүүлэх юм байна. Тэгээд энийг ер нь яаж зохицуулж байгаа вэ гэдэг ийм асуудлыг бол хөндөж тавьж байсан юм. Хууль тогтоомжийг хийхдээ аливаа байдлаар төрийн байгууллагууд авлигажих ийм нүх сүв олгосон ийм зүйлээс аль болох хууль тогтоох зайлсхийж байх учиртай. Тэр ч утгаараа төрийн нэг сайд, эсвэл нэг агентлагийн

дарга, нэг улсын байцаагч үзэмжээрээ шийдвэр гаргаад тэгээд том хэмжээний татварын хөнгөлөлтүүдээс чөлөөлөх энэ боломж гэдэг бол цаанаа дандаа авлигыг бас боломжийг нэмэгдүүлж байдаг. Тэгэхээр үүнийг хэр зэрэг хаасан бэ гэдэг ерөнхий асуудал ажлын хэсэг дээр, Байнгын хороон дээр харсан бэ?

Тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр бол тухайн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ноогдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний 5 жил 100 хувь, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө гэж байгаа юм. Тэгээд сая сар гаруйн өмнө Засгийн газар дээр миний бие энэ манай улс чинь журмын улс болчихжээ. Хэдхэн жилийн өмнө 800 хэдэн журамтай байсан улс одоо ингээд 2000 гаруй журам гаргачихсан. Тэгээд баахан ийм журмуудаар ийм эрх олгосон, дур зорго шингэсэн, авлигажих ийм боломжийг олгосон байна гээд. Тэгээд энэ төсөл дээр бас нэлээн хэдэн журмууд яваад байгаа юм. Найруулга дээр ч гэсэн яваад байгаа юм.

Тухайлбал, энэ дэвшилт 17.2.3 дээр дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, нутагшуулсан шинэ нэр төрлийн органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийтийн хэрэгцээнд нийлүүлсэн нь технологи дамжуулах хуульд заасны дагуу нотлогдсон тохиолдолд судалгаа хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс олгох гэж байгаа юм. Энэ ямар хэмжээний мөнгөний тухай яригдаад байна? Энэ төрөөс үзүүлэх дэмжлэг урамшуулалтай холбогдох журмыг нь болохоор Хөдөө аж ахуйн сайд дангаараа батлах гээд байгаа юм. Ер нь нэг сайд ийм журам гаргаж ийм их хэмжээний мөнгөн дүнг улсын төсвөөс гаргах, хөнгөлөх ийм журам гаргадаг явдал бол маш буруу. Үүнийг бол хууль тогтоох арга техникээс хасах учиртай.

Тухайлбал, энэ Боловсролын сайдад хүртэл ийм эрх олгогчлоод байгаа байхгүй юу. Боловсролын сайд бас нэг журам гаргаад, тэгээд энэ төрөөс үзүүлэх энэ дэмжлэг дээр нь бүх шатны боловсролын байгууллагад иргэд энэ органик туслах аж ахуй хөгжүүлэх, үүнийг нь болохоор Боловсролын сайд батална гээд ингээд. Ер нь энэ хууль тогтоогч энэ хууль тогтоохдоо энэ Засгийн газрын гишүүн юм уу, нэг сайд, агентлагийн дарга ийм мөнгөн дүнг дураараа хөнгөлөх, чөлөөлөх ийм журам гаргах эрх олгогчийг болимоор байна. Энэ санхүү мөнгөний бодлогыг хууль тогтоогч ард түмний төлөөллийн байгууллага өөрөө мэддэг байх ёстой. Энэ төрийн өмчийн компаниуд дээр энэ эрх шилжүүлж байгаад л энэ баахан хулгай араас нь ярьдаг болчихоод байгаа байхгүй юу. Үүний дараа энэ Боловсролын сайд, Хөдөө аж ахуйн сайдын араас яг хулгайны энэ 2 сайд бол дараа нь шоронд орно. Чи хэнд яахаараа энэ давуу байдал олгосон.../минут дуусав./

**Л.Мөнхбаатар:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Баагаагийн Баттөмөр хариулъя.

**Б.Баттөмөр:** Татварын хувьд энэ нэмэгдсэн өртгийн албан татвар, хувь хүний орлогын албан татвар, НӨАТ-өөс чөлөөлнө гэсэн орж ирсэн юм. Энэ дээр ерөөсөө ярьж ярьж байгаа хамгийн сүүлд Байнгын хороон дээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт өөрчлөлт оруулъя. 22.5.10<sup>1</sup> гэсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 4.2.1-д заасан органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ноогдох албан татварын орлого олж эхэлсэн эхний 5 жилд 100 хувиар, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлье гэж байгаа юм.

Үүнд өнөөдөр органик бүтээгдэхүүн үйлдвэрлээд ашиг олж байгаа юм байхгүй шүү дээ. Монгол

Улсад органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа гэж 14 аж ахуйн нэгж байдаг. Жижигхэн. 31-50 сая төгрөгийн орлоготой. Маш жижигхэн. “Алсын хараа-2050”-д бол 2030 гэхэд Монгол Улс хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүнийхээ 5 хүртэл хувийг, 5 хувийг органик болгоно гээд үүрэг, амлалт авчихсан байдаг. Дэлхийн хэмжээнд 2030 гэхэд 15 хувь болно гээд ингэж явчихсан. Тийм учраас энэ органик бүтээгдэхүүн гэдэг бол Монголд ер нь бараг байхгүй. Байхгүй байгаа юм. Тийм учраас бол энэ аж ахуйн нэгжид байхгүй татварыг та нар бий болгох юм бол хөнгөлөлт үзүүлнэ гэсэн ийм юм оруулсан юм.

Хоёр дахь асуудал сая Энхбаяр сайдын хэлсэн үгэн дээр сургуулийн өмнөх болон бүх шатны боловсролын дэргэд органик туслах аж ахуй хөгжүүлэх. Туслах аж ахуй байхгүй юу. Сургуулийн дэргэд үүнээс нэг их мөнгө олоод л нэг их айхтар юм үүсээд л, хуйвалдаан үүсээд л эндээс юм болохгүй болов уу л гэж бодож байна. Энд бас юу ч байхгүй. Өнөөдөр Монголын энэ сургуулиудын дэргэд, бүх шатын сургуулиудын дэргэд энэ органик аж ахуй гэж байхгүй. Үүний цаад талд юу гэхээр хүүхдүүдийг багаас нь энэ органик хүнсний ач холбогдлыг бас хүүхдүүдэд ойлгох ийм л зорилготой. Энд бол ямар нэгэн хөнгөлөлт эндээс бол юу байхгүй гэдгийг хэлье.

Дараагийнх нь энэ тэр 17.2.3-д дэвшилт технологид нэвтрүүлж, нутагшуулсан шинэ төрлийн органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийтийн хэрэгцээнд нийлүүлсэн Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу нотлогдсон тохиолдолд судалгаа хөгжүүлэлтийн зардлын 75 хувьтай тэнцэх хэмжээний. Тэгээд энэ дээр яг манай Хүнс, хөдөө аж ахуйн яамных нь бас тодорхой тоо хэлэх байгаа. Үүнийг би ажлын хэсгийн ахлагчийн хувьд бол дэмжсэн юм. Монгол Улсын шинжлэх ухаан гэдэг юмандаа бас эрдэмтдээ дэмжих ёстой. Дандаа гаднаас юм

хуулах биш, өөрснөө хийчихсэн маш их ноу хау, шинэ бүтээл, шинэ санаанууд байна. Энэ тэрийгээ үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь урамшуулъя гэж. Тэгээд энэ хууль 2025 оны 1 сарын 1-ээс эхлээд мөрдөгдөнө. Үүний үр дүн бол 26, 27 онд гарна. Тэр болтол бид нар харъя. Үнэхээр улсын төсөвт их хэмжээний дарамт, шахалт болоод тийм дарамт учраад байдаг юм бол тухайн үеийн жил жилийнх нь Төсвийн хууль дээр энийг зохицуулаад явах боломжтой гэж ингэж үзэж байгаа. Яамныхан тэр судалгаа хөгжүүлэлтийн ажил дээр энэ 75 гэсэн хувийнхаа тэр тоо хэмжээний юунуудыг хэлчих.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулах юм уу? Хариулт болох юм уу? За за. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 3 санал байна. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтаар хураалгасан санал хураалт байна.

1.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн органик бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн санд илгээнэ.”. Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт.

61.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан,

мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашигласан тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт.

18.39 цаг.

**“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэн танилцуулах билээ? Саранчимэг гишүүн танилцуулна. Сарангэрэл гишүүн танилцуулах уу? Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын газраас 2024 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд төслийн 1 дэх заалтын үе шаттайгаар нүүлгэн байршуулах арга хэмжээ авах гэснийг нүүлгэн байршуулах талаарх бодлого боловсруулах гэж өөрчлөх, мөн 2 дахь дэд заалтаас шаардлагатай бол гэснийг хасах талаар зарчмын зөрүүтэй санал

61.9 хувиар санал дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёололыг танилцуулъя.

Аж ахуйн нэгжийн орлоын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5.10<sup>1</sup>. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 4.1.2-т заасан органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний 5 жилд 100 хувиар, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.”. Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт.

59.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ. Дараагийнхаа асуудалд оръё.



гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Хэлэлцүүлгийн үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй. Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцээж санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Сарангэрэл гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын референт Очиржавын Дөлгөөнтуул, Эдийн засаг хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Даваасамбуугийн Эрдэнэбаяр нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Салдангийн Одонтуяа даргаар тасаллаа.

**С.Одонтуяа:** Тэгэхээр энэ Улаанбаатар хотоос үе шаттай шилжүүлэн байршуулна гэж байгаа юм. Тэгэхээр төрийн байгууллага гэдэгтээ яг ямар байгууллагуудыг ойлгож үе шаттай шилжүүлэх юм бэ? Яагаад гэхээр Үндсэн хуулийн 13-д заасан байгаа төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот байна гээд. Тэгэхээр одоо бол миний ойлгож байгаагаар төрийн захиргааны төв байгууллага гэхээр яамууд, төрийн захиргааны байгууллага гэхээр агентлагууд байгаа. Тэгэхээр яг эд нараас алийг нь ямар үе шаттай шилжүүлэх юм бэ?

Хоёр дахь асуулт энэ шилжүүлэхтэй холбоотой зардлын тооцоо, судалгаа ерөөсөө байхгүй байна. Энэ дээр хариулт авъя.

Гурав дахь нь төрийн албан хаагчид ингээд яам, тамгаа дагаад ингээд шилждэг юм байж. Тэгэхээр энд чинь энэ орон нутгаасаа голцуу яам, тамгын ажилчдаа сонгон шалгаруулах юм уу, эсвэл энэ чинь гэр бүл нь хөөрхий ажлаа дагаад тийшээ явдаг, хотод хэсэг гэр бүл нь гээд л энэ асуудлуудыг ер нь нийгмийн асуудлыг нь яаж шийдсэн юм болоо? 3 асуулт асууя.

Тэгэхээр энэ жишээлэхэд бусад оронд бол энэ том компаниудыг бодлогоор өөр хот руу аваачдаг ийм бий л дээ. Жишээлэхэд Оросууд Санкт Петербургт тэр хамгийн том Газпром энэ тэрээ шилжүүлээд бүх татвар нь тэндээ төлөгддөг, тэр хотыг эдийн засгийн аргаар дэмжих ийм зүйлүүд бол байгаа даа. Гэтэл энэ чинь төрийн захиргааны байгууллагууд гэхээр их л ойлгомжгүй л байна даа. Үүнийг тодорхой нэг хариулаад өгөөч.

**Л.Мөнхбаатар:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд хариулъя.

**Н.Энхболд:** Энэ ийм байгаа юм Одонтуяа гишүүнээ. Хэрэв та тогтоолоо ингээд хоёрхон заалтаар эхний заалт дотроо 3 задарсан. Тогтоолоо Засгийн газраас оруулж ирэхдээ шууд төрийн байгууллагуудын эрхлэх чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, энэ юмнуудыг нь харгалзаад үе шаттайгаар нүүлгэн байршуулах арга хэмжээ авах гэгчихсэн ийм орж ирсэн юм нэгдүгээрт.

Хоёрт, яг төрийн албан хаагчид дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг нь яах вэ гээд, 3 дахид нь энэ мөнгийг нь хаанаас гаргах вэ гэдгийг нь заасан ийм заалтуудтай. Тэгээд энэ, бид нар Байнгын хороон дээр ярьж байгаад шууд ингээд тогтоол гаргангуут нүүлгэн байршуулах тухай асуудал байхгүй. Яг саяынх шиг олон асуудлууд гарна тийм ээ? Тэгэхээр үүнийг нь нүүлгэн байршуулах арга хэмжээ авах гээд эхлээд та нар бодлогоо боловсруул, тэгээд түүнийгээ дагаад танаас саяын асуусан шиг жишээ нь төрийн албан хаагчид нүүвэл тэд нарын нийгмийн асуудлыг нь, цалин хөллийг нь яаж дэмжлэг үзүүлэх, яаж урамшуулж явуулах юм гэдэг юмнуудыг нь дараа нь боловсруулж оруулж ирлээ. Хуульд заавал тийм шаардлага гарна. Тэрийг боловсруул гэж. Тэгээд дараа нь тэд нарынхаа дагуу санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нь тооц гэсэн. Энэ бол ерөнхий чиглэл өгч байгаа ийм тогтоол юм байгаа юм.

Яг ямар ямар байгууллагууд яаж явах гээд байна вэ гэдгийн хувьд энэ зөвхөн төрийн захиргааны байгууллагууд биш, төрийн өмчтэй таны сая хэлсэн шиг төрийн өмчтэй байгууллагууд, томоохон аж ахуйн нэгжүүд байж болно. Төрийн өмчийн оролцоотой компаниуд, төрийн өмчийн компаниуд, бололцоотойг нь бас заавал Улаанбаатарт шавуулаад байхгүйгээр нүүлгэх ийм зүйлүүдийг эхлээд бодлогоо гарга, тэгээд хуулиа оруулж ир, тэрнийхээ дагуу нөгөө нийгмийн асуудлуудыг нь шийд, санхүүгийнх нь эх үүсвэрийг тухай тухайн жилийн төсөвт

тусгаад, шат дараагаар нүүлгэж байршуулах юмнуудыг ав гэсэн ийм ерөнхий Их Хурлаас үүрэг өгч байгаа юм уу, даалгавар өгч байгаа гэх юм уу ямар ч байсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалынхаа хүрээнд багтаагаад ийм ажлуудыг хийе гэсэн чиглэл Улсын Их Хурлаас өгч байгаа л гэж ойлгож болно.

**Л.Мөнхбаатар:** Яах юм та нэмж хариулах юм уу айн? Нямаагийн Энхболд дарга нэмээд хариулчихъя. Гүйцээгээд хариулчихъя.

**Н.Энхболд:** Жишээ нь т сая тэр нүүлгэн байршуулах арга хэмжээ авах гээд шууд л энэ тогтоол гарахаар бараг зарим газруудыг нүүлгээд байх юм шиг ийм агуулгатай заалт орж ирснийг нь Байнгын хороон дээр бид нар ярьж байгаад эхлээд бодлогоо боловсруул, түүнийхээ дагуу хууль тогтоомжоо өөрчлөөд тэгээд шат дараатай арга хэмжээ ав гэсэн агуулгатай болгоод гаргаж байгаа юм тийм.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Гишүүд танхимдаа орж ирье. Байраа эзлээрэй. Гишүүд байраа эзлээрэй. Одоо санал хураалт явагдана. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. 2 санал байна.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “арга хэмжээ авах” гэснийг “талаарх бодлогыг боловсруулах” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их

Хурлын гишүүн Нямаагийн Энхболд.  
Санал хураалт.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “шаардлагатай бол” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд.  
Санал хураалт.

Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр горимын санал гаргая.

**Б.Баттөмөр:** Би дэмжиж кноп дарсан боловч эсрэг гарчихлаа. Саналыг дахиж хураалгаж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хүчингүй болсон. Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалтыг явуулъя. Хөөе, Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут горимын санал гаргая.

**Д.Батлут:** Саяын санал дээр дэмжиж санал өгсөн боловч энэ тоног төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Дамбын Батлут гишүүний гаргасан горимын саналаар санал хураая.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Батлут гишүүний горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байрлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ. Дараагийнхаа асуудалд орно. Дараагийнхаа асуудалд оръё.

18.53 цаг.

**“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Монгол Улсын Их Их Хурлын тухай хуулийн 22.22-т хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасан. Одоо хэлэлцэх гэж байгаа асуудал төрийн нууцтай холбоотой учир нэгдсэн хуралдааныг хаалттай хэлэлцүүлгийн горимд шилжүүлъя.

19.22 цаг.

**Г.Занданшатар:** Дараагийн асуудалд орно.

**Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна.

**Ц.Сандаг-Очир:** Хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анх анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Г.Занданишатар:** Хөндөгдөөгүй заалтыг хөндөж болохгүй л гэж хариулна. Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж, танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя. Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа.

**Б.Пүрэвдорж:** Сандагдорж шүү дээ тээ, Сандагдорж билүү?

**Г.Занданишатар:** Сандаг-Очир.

**Б.Пүрэвдорж:** Сая ер нь бол Их Хурлын гишүүдэд өдөр тутмын сонин нэгдсэн холбооноос мессеж ирээд, ер нь бол энэ өдөр сонин захиалгын зардлыг энэ гаргахыг шийдэж өгөөч гэдэг ийм хүсэлт

ирээд байгаа. Тэгэхээр ер нь бол өдөр тутмын сонинг бас тодорхой хэмжээгээр дэмжих нь зүйтэй. Гэвч яг энэ Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээрээ яг энэ хэвлэл захиалгын мөнгөтэй холбоотой заалт орж ирээгүй учраас, энэ хөндөгдөөгүй сэдэв учраас, заалт учраас үүнийг оруулж шийдвэрлэж болохгүй байна. Хэрвээ дараагийн асуудал дээр яг энэ Хэмнэлтийн хууль дээр Засгийн газар дахиад асуудал орж ирвэл яг энэ өдөр тутмын сонин асуудлыг бас дэмжиж, шийдвэрлэж, заалтыг нь оруулж ирж өгөөч гэж хүсэх байна.

**Г.Занданишатар:** Уул нь тэр хэвлэл захиалгын зардлыг шийдэх нь зөв юм шиг байгаа юм хөдөө орон нутагт. Тэгэхдээ хөндөгдөөгүй заалтыг хөндөж болохгүй учраас Байнгын хороо тэгж хариулах байхгүй. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.5.21 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.5.21.нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар;”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ер нь энэ Цэндийн Сандаг-Очир гишүүний буянаар нийслэлийн 3 дүүрэг хууль болгон тусгалаа олж, хуучин чинь нөгөө нийслэл, аймаг, сум, дүүрэг гэсэн статусаар яваад байдаг байсан бол одоо

аймгийн статусаар Багануур, Налайх, Багахангай дүүргүүдийн статус бол их өндөрсөн. Тэгээд энэ заалт ч гэсэн энэ дээр ингээд Сандаг-Очир гишүүний заалтаар дэмжигдэж байна.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн” гэсний дараа “8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хуульд заасан тусгай хувцас” гэсний дараа “болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас” гэж” нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ 3 дүүргийг Төв аймагт гэх биш Багануур, Налайхыг бол хот болгох асуудлыг нэг шийдмээр байна. Ингээж байж хот, хөдөөгийн сэргэлт Дэлгэрсайхан сайдаа ингээж байж Улаанбаатар хотын чинь түгжэрэл буурч, энэ хот болох Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа харин та оруулж ирэх асуудлыг яаравчилж байж, дагуул хотууд чинь тэгж хөгжиж байж энэ Улаанбаатар хотын чинь түгжэрэл буурна шүү. Дэлгэрсайхан гишүүнд үүрэг өгч байна.

Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу боловсруулаад Тогтохсүрэн даргатай ажлын хэсэг тэгээд Засгийн газар санаачлах ёстой. Одоо хотууд Сайншианд хот болох, хөөө Сайншианд хот болох ёстой байхгүй юу. Замын-Үүд хот болох ёстой. Ингээд нэг сум гээд ингээд яваад байдаг. Аймаг гэж. Хаа аймаг гэж орж явж байна гэж ярьж байгаа юм. Гэтэл үүнийг тэр аймаг дотроо явж байгаа байхгүй юу. Нутаг дэвсгэр. Тийм учраас сая бид нар Багануур дүүрэгт, Багануур, Төв аймагт ажилласан манай Батжаргал гишүүн, Сандаг-Очир гишүүн. Багануур дүүргийнхэн бол тэр хот болох асуудлаа

манш их ярьж байна лээ шүү. Их сэргэчихсэн ч байна лээ. Дараагийн санал хураалт. Энэ санал хураалтаа явуулъя. 3 дахь санал.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг,”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт.

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ манай Батжаргал гишүүн бас энэ яг амьдралдаа энэ аюулгүй байдал, эрүүл ахуйн талаасаа энэ тусгай хувцаснууд заавал хэрэгтэй байдаг. Тэгээд үүнийг хасчхаад байдаг юмнуудыг дандаа форм хасчихсан байхгүй юу. Хэрэглэхийг хэрэгтэй саналуудыг оруулсан байгаа юм.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдэж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Төсвийн байнгын хороо хуралдаад эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ. Дараагийн асуудалд оръё.

19.29 цаг.

**Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Өнөрболор:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал,

дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруул тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн. Төсвийн байнгын хороо үүний дараа хуралдчихна биз дээ? Одоо Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1</sup>.1 дэх хэсгийн “дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно.” гэсний дараа “Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно.” гэж нэмсүгэй.”. Санал гаргасан Улсын Их

Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.  
Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын “арга хэмжээг” гэснийг “арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1</sup>.1, 28<sup>1</sup>.3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. Ганзоригийн Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн үг хэлнэ.

**Г.Тэмүүлэн:** Энэ тогтоолын 1 дүгээр энэ зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр гүйцээн боловсруулах чиглэл авах гэсэн юм дарга. Энэ сүүлийн энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт, бичигт тусгасан гэдэг маань өөрөө 28<sup>1</sup>.1 болоод 1.3-тайгаа бас давхцаж байгаа юм байна. Тэгэхээр хуулийн давхцал үүсэж байгаа учраас үүнийг гүйцээн бус болгох чиглэл өгнө үү л гэж хүсэж байна.

**Г.Занданшатар:** Санал хураачхаад редакцаар засах юм уу? Хууль дээр давхцаж байгаа юм бол. 28<sup>1</sup>.3-ийг хасчихаар чинь гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Өнөө орой хуралдчихаад маргааш юу яачихна. Дараагийн санал хураалт руу орёё.

2.Тогтоолын төслийн 2 дугаар заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ тогтоолыг Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт.

28 гишүүн чинь дэмжиж, 71.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Ер нь энэ Сангийн яамны үүргээрээ л тодорхой байх хэрэгтэй. Төсвийн сахилга бат, төсвийн нэгдсэн бодлогын бодлого байх ёстой. Гадаад зах зээлд гаргахад бас. Одоо дараагийн асуудалд орно.

19.36 цаг.

Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хянан шалгах түр хорооны тайлан болон санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хянан шалгах түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо манай орны стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын томоохон ордод үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, “Тавантолгой” компаниудад хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгаж, хийж гүйцэтгэлээ.

Энэ удаагийн Улсын Их Хурлын хяналт шалгалтын хүрээнд Түр хороо нь “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, “Тавантолгой” хувьцаат компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой 3.1 сая гаруй хуудас баримт, материалыг хамруулсан хяналт шалгалтыг 72 хоногийн хугацаанд хийж, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг 2 үе шаттай зохион байгуулсан бөгөөд сонсголын үр дүнд үндэслэн дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

1.Тавантолгой хувьцаат компанийн хувьд.

Өмнөговь аймгийн ИТХ нь 51 хувийн хувьцаа эзэмшигчийн төлөөллөө үр нөлөөтэй хэрэгжүүлээгүйгээс нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон түүний хамаарал бүхий этгээд компанийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан төдийгүй зарим улс төрд нөлөө

бүхий этгээд, ИТХ-ын төлөөлөгч, ТУЗ-ийн гишүүдийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхол бүхий этгээдийн компани их хэмжээний нүүрсний гэрээ, хөрс хуулалтын ажлын гэрээ байгуулж байсан байна.

Хөрс хуулалтын ажил гүйцэтгэгч болон бусад бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, нүүрс худалдан авагчийг хэрхэн сонгон шалгаруулж байсан нь тодорхойгүй, ТУЗ-ийн тогтоолоор нүүрсний үнэ их хэмжээний хэлцэлд хамаарахгүй гэрээ хэлцэл болон ажил гүйцэтгэгч нүүрс худалдан авагчийн жагсаалтыг баталж ирсэн байна.

Өмнөговь аймгийн ИТХ-ын зүгээс компанийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд тавих хяналт хангалтгүй, ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, эрх бүхий хөндлөнгийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалт үр нөлөөгүйгээс худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим бүрэн хэрэгжээгүй байна. Архивын сан хөмрөгийн бүрдэл бүртгэл хангалтгүй, анхан шатын нотлох баримтууд иж бүрэн бус, архив болон цахим системийн дата бүрэн хадгалагдаагүй, баримт материалаа хүлээлцээгүй, устгасан болон цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал нь хяналт шалгалтын цар хүрээг хязгаарлахад хүргэж байсныг энэ таширамд дурдъя.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьд.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш тус компанийн орлого ашигаас төрийн шийдвэрээр нийт 1 их наяд 196.5 тэрбум төгрөгийг нийгмийн



болон төсвийн шинж чанартай асуудлыг санхүүжүүлэхэд зарцуулсан нь компанийн хувьцаа эзэмшигчийн хурал болон ТУЗ бие даан шийдвэр гаргах боломжийг хязгаарлаж, компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, компанийн үнэ цэн, олон улсын зах зээлээс санхүүжилт босгох сайн засаглалыг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлсөн байна.

Тавантолгойн ордын Цанхийн хэсгийн батлуулсан ТЭЗҮ-д тусгасан нэмүү өртөг шингээх төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалан нүүрсний 3, 4 дүгээр давхаргын сайн чанарын коксжих нүүрсийг сорчлон олборлож байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахид заасантай нийцээгүй байна. Нийт олборлосон нүүрсний 92 хувь нь коксжих нүүрс байна.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 2011-2023 онуудад нийт 944 гэрээгээр 13.3 их наяд төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд хяналт шалгалтад 500 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хяналт шалгалтад нийт 11.5 их наяд төгрөгийн 92 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг нягтлахад 4.8 их наяд төгрөгийн дүн бүхий 40 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа хуульд нийцээгүй байна.

2011-2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан тус компанийн архивд байхгүй тул хяналт шалгалтын нэгдсэн дүнд ороогүй болно. Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн 2011-2023 оны 10 сар хүртэл хугацаанд 398 гэрээгээр 100.1 сая тонн буюу 20.20 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд нийт нүүрсний борлуулалтын гэрээний сарын дундаж үнийг “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн тухай бүр мөрдөгдөж байсан үнэ тогтоох аргачлалын үнэтэй

харьцуулан нийт гэрээний үнийн зөрүүг тооцоход алдагдсан боломжийн зардал ойролцоогоор 826.4 сая ам.доллар байна.

Засгийн газрын 2010 оны 350 дугаар тогтоолын 3-д “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны үнэлгээг зөвлөх үйлчилгээний компанитай хамтран тогтоох талаар үүрэг өгсөн боловч “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн эзэмшиж буй Тавантолгойн ордод үнэлгээ хийж, компанийн хувьцааны нэршээний үнийг тогтоохгүйгээр Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор нэгж хувьцааны үнийг 933 төгрөгөөр тооцож ордын үнэлгээг бодитой тогтоогоогүй байна.

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын 2.11-д бонд гаргаж бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ гэж заасан боловч үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42 хувийг гэрээт олборлогчдын төлбөрийг барагдуулахад зарцуулсан байна.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамж, кокс, эрчим хүчний үйлдвэр зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамаарах нэмүү өртөг шингээх 8 төсөлд нийт 5 их наяд 24.7 тэрбум төгрөг, Засгийн газар ТУЗ-ийн холбогдох шийдвэрийн дагуу компанийн үндсэн үйл ажиллагаанд үл хамаарах “Богд хаан” төмөр зам, газрын тос дамжуулах хоолой зэрэг төсөлд нийт 463.2 тэрбум, “Тавантолгой түли” ХХК-д 1 их наяд 69.4 тэрбум төгрөгийн санхүүжилт, Багануур ХК, Шивээ-Овоо ХК-д нийт 63.3 тэрбум төгрөгийн зээл тус тус олгосон байна.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани Төмөр замын 5 төсөлд мөнгөн хөрөнгө болон нүүрсээр нийт 4 их наяд 643.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл бүрэн

хэрэгжиж, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажил дууссан бөгөөд “Богд хаан” төмөр замын төсөл судалгааны ажлын түвшинд зогссон байна.

Төмөр замын төслийн захиалагч болох “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөр зам” ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг үндэслэн төслийн ерөнхий гүйцэтгэгч Барилга инженерийн цэргийн удирдах газар, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг, “Бодь интернэйшнл” ХХК-тай шууд гэрээ байгуулсан холболтын төмөр замын 218 тэрбум төгрөгийн Тавантолгойн нүүрс ачилтын логистикийн төвийн 217.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий “И Пи Си” гэрээг магадлалаар баталгаажуулаагүй зураг төсөл үнийн дүнд үндэслэн байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн бөгөөд ТЭЗҮ-гийн дүнг үндэслэн гэрээний үнийн дүнг 95.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар нийт 2.3 сая тонн ачаа тээвэрлэсэн хэдий ч зүтгүүр вагоны тоо хангалтгүйгээс төмөр замын ашигт ажиллагаа ТЭЗҮ-д заасан хэмжээнд хүрээгүй байна.

Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замаар нийт 488.4 мянган тонн нүүрс тээвэрлэсэн бөгөөд одоогоор зураг төслийн ажил үргэлжилж буй хил холболтын төмөр зам ашиглалтад орсноор эхний жилд 10.6 сая тонн, 2 дахь жилд 21.1 сая тонн, 3 дахь жилд 26.4 сая тонн, 4-20 дахь жилүүдэд тус бүр 31.9 сая тонн, 21-30 дахь жилүүдэд тус бүр 50.2 сая тонн нүүрс тээвэрлэхээр байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-аас нүүрс худалдан

авч экспортолсон аж ахуйн нэгжүүдэд олгосон “Си” төрлийн зөвшөөрлийн бичгийн 2010-2017 оны анхан шатын бичиг баримт төрийн байгууллагуудад хадгалагдаагүйгээс хяналт шалгалт хийх боломжгүй. “Си” зөвшөөрлийн бичиг олголтын үйл ажиллагаа түүнээс төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн зарцуулалтад дээд шатын болон хөндлөнгийн аудитын байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй, холбогдох ажлын хэсгийн дарга нар нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдож ял шийтгэгдэж байжээ.

Хяналт шалгалтын бусад асуудлын хүрээнд.

Монгол Улсын гаалийн байгууллага экспортолсон нийт нүүрсийг бүртгэхдээ тухайн худалдан авч буй талын бүртгэлтэй улсын нэрээр статистик мэдээлэлд оруулдаг байна. Манай улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас бусад улс орнууд руу экспортолж буй нүүрс нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилээр гарч бүртгэгдэж байгаа бөгөөд тус улсын гаалийн байгууллага хэрхэн бүртгэж байгааг тодорхойлох боломжгүй байлаа. Хятадын нүүрсний экспорт импортын статистик мэдээллийн платформ дахь Монгол Улсаас импортолсон нийт нүүрсний хэмжээг Дэлхийн банк, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн худалдааны байгууллагын статистикийн нэгдсэн мэдээллийн платформ дахь мэдээлэлтэй харьцуулахад зөрүү 39 мянган тонн байна.

Манай Улсын 2013-2022 оны хооронд экспортолсон нийт нүүрсний биет хэмжээг Хятадын нүүрсний экспорт, импортын статистик мэдээллийн платформ дахь Монгол Улсаас импортолсон нүүрсний тоон мэдээлэлтэй тулган шалгаж Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас бусад улс орон руу экспорт хийсэн дүнг оруулж тооцоход 980 мянган тонн илүү,

оруулаагүй тохиолдолд 6.1 сая тонны дутуу зөрүү үүсэж байна. Цагаан хад бүсэд байрлах 36 нүүрс ачих, буулгах терминалын нүүний программд бүртгэгдсэн ачилтын мэдээлэл болон Гаалийн ерөнхий газрын “Си Эй Ай Эс” систем дэх гаалийн бүрдүүлэлтийн дотоод манифестийн өгөгдлийг Эм Эс аксесс /MS access/ программ уншуулан тулган баталгаажуулалт хийхэд олон улсын тээврийн “Си” зөвшөөрөл бүхий 487 хуулийн этгээдээс 246 тээвэрлэгч нь нийт 52030 удаагийн тээвэрлэлтээр 5.2 сая тонн нүүрсийг улсын хилээр гаалийн бүрдүүлэлтгүй гаргасан байж болзошгүй байна.

Өмнөговь аймгийн Ханбогд сумд гаалийн хяналтын талбай, авто тээврийн зогсоол, кемпийн зориулалттай газрыг 2020-2022 онд дуудлага худалдаагаар худалдаагүй бөгөөд дуудлага худалдааны анхны үнэ төлөгдөөгүй байхад газар болгон дараа нь нөхөн төлүүлж, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай 34 аж ахуйн нэгжид 42 эзэмших эрхийн гэрчилгээгээр 475.3 га газрыг олгосон байна. Мөн 2 хуулийн этгээдэд 4100 га газрыг эрчим хүчний зориулалтаар хууль бусаар газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна.

Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр 3 удаа зохион байгуулахдаа тендер шалгаруулалтын шаардлагыг хангаагүй этгээдийн ерөнхий нөхцөл, санхүү болон техникийн чадавхад нийцүүлэн тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулан шалгаруулж, гэрээ байгуулсан нь нэг этгээдэд давуу байдал үүсгэсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д хамаарал бүхий этгээд, 3.1.6-д нэгдмэл сонирхолтой этгээд, 3.1.11-д ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл

байдлыг тус тус хэрхэн хуульчлан тодорхойлсныг үндэслэн улс төрийн нөлөө бүхий этгээдийн хамаарлын тодорхойлж ажилласан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хянан шалгах түр хорооноос дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

“Тавантолгой” хувьцаат компанийн талаар.

“Тавантолгой” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн 51 хувийн хувьцааг Улсын Их Хурлын 1999 оны аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай 29 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчлөлд шилжүүлсэн асуудал болон хувьцаа эзэмшигчийн төрийн өмчийн төлөөллийн үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан үзэж, шаардлагатай арга хэмжээг авах.

Бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтыг төлөвлөх, сонгон шалгаруулах, тайлагнах, олон нийтэд мэдээлэх, архивын баримтыг бүрдүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллах, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг мөрдөж ажиллах, нүүрс ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны анхан шатын баримт, түүний программын мэдээллийн сангийн иж бүрэн үнэн зөв байдлыг хангуулж ажиллах.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн талаар.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн үйл ажиллагаа улс төрөөс хэт хамааралтай байгаа нь ТЭЗҮ нэгдсэн

төлөвлөлтийн дагуу ордыг ашиглах боломжгүй байдалд хүргэж байх тул компанийн засаглалыг сайжруулах хүрээнд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан компанийн засаглалын суурь зарчмын баримт бичгүүдэд засаглал, удирдлагын тогтолцооны үе шат бүхэнд баримтлах зарчмууд, дотоод хяналт ба эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүтэц, эрх хэмжээг тусгасан засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх. баримт бичгүүдэд үндэслэн компанийн засаглалын бодлого, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Тавантолгойн ордын нөөцийн зэрэглэлийг нэмэгдүүлэн, орд ашиглалтыг зохистой төлөвлөж, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасны дагуу сорчлон ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн төлөвлөлт, удирдлагаар хангаж ажиллах, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн эзэмшиж буй 8 зөвшөөрлийн талбайд хамаарах газар эзэмших эрхийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч, гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэх. Цаашид төсвийн шинжтэй компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт төслийг санхүүжүүлэхгүй байх, бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээж борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд шаардлагатай төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хяналтыг сайжруулах.

Бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтыг төлөвлөх, сонгон шалгаруулах, тайлагнах, олон нийтэд мэдээлэх, архивын баримтыг бүрдүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах.

Нүүрсний салбарын статистик мэдээлэл бүх шатдаа нэришил, ангилал,

тоо хэмжээ, үнийн дүнгийн бүртгэл, зөрүүтэй байгаа тул хоёр улсын гаалийн байгууллагуудын мэдээллийн урсгалын солилцоог сайжруулах, бүртгэлийн нэг стандартад оруулах, холбогдох бусад төрийн байгууллагуудын мэдээллийн урсгалыг нэг болгож хяналтыг сайжруулах.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны үнэлгээ хийлгэж, хөрөнгийн биржид нээлттэй арилжаалж олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос зохион байгуулсан энэ удаагийн хяналт шалгалт нь шударга ёсыг тогтоож, иргэдийн мэдэх эрхийг хангах, байгалийн баялгийг нийтийн эрх ашигт нийцүүлэн ард түмний ахуй амьдралыг сайжруулж улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд зориулан зүй зохистой ашиглах, Монгол Улсын үндсэн хуулийн үзэл баримтлал заалтыг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх арга хэмжээ болсон гэж үзэж байна.

Мөн түүнчлэн энэ удаагийн хяналт шалгалт нь Монгол төрийн хуулийн биелэлттэй холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг ард түмний төлөөллийн байгууллагаас хянан шалгах эрх зүй орчныг бүрдүүлэх зорилгоор 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үр дүн бөгөөд ард түмний өмч болох байгалийн баялгийг зүй бусаар ашигласан, хууль зөрчсөн олон үйл ажиллагааны нотлох баримт,

мэдээллийг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй болгож чадсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна гэж заасныг үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” хувьцаат компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан бөгөөд тогтоолын төсөлд дараах асуудлыг тусгалаа. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль зөрчиж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар эзэмшүүлсэн асуудлыг иуурхай шалгаж, холбох шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авч, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх.

2. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТҮЗ-ийн бүрэлдэхүүнд улс төрд нөлөө бүхий этгээд, тэдгээрийн хамаарал бүхий этгээд ажиллах, аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд улс төрийн нам, улс төрчид оролцохыг таслан зогсоох, хязгаарлах арга хэмжээ авах.

3. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” хувьцаат компани болон төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс цаашид төсвийн шинжтэй компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө

оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээг авах.

4. Төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс аливаа хэлбэрээр оролцохыг хязгаарлах, тэдгээрийн компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, үйл ажиллагаагаа иргэд олон нийтэд ил тод, нээлттэй явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төсөл боловсруулж 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

5. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” хувьцаат компани болон төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулах чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

6. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, ус, усны нөөц, ан амьтан, төрийн нийтийн өмч мөн гэж тус тус хуульчилсан тул “Тавантолгой” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн 51 хувийн хувьцааг орон нутгийн өмчлөлд шилжүүлсэн Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29

дүгээр тогтоолын холбогдох заалтыг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах.

7.Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордын Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн тул “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн “МТАС” түншилэлтэй 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан Тавантолгойн ордын “Бортээгийн уурхайн хөрс хуулалт, өрөмдлөг, тэсэлгээ, нүүрс олборлолт, нүүрс баяжуулалтын ажил, гүйцэтгэх гэрээг холбогдох хуульд заасан журмын дагуу хүчингүй болгох арга хэмжээ авах.

8.Татварын хяналт шалгалтыг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүйгээс нүүрс олборлогч зарим хуулийн этгээд татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлж, татварын нөхөн ноогдуулалт болон алданги, торгууль ноогдуулах боломжийг алдагдуулсан албан тушаалтанд холбогдох хуульд заасан журмын дагуу хариуцлага хүлээлгэж, цаашид дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж 24 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

9.Монгол Улсын хилээр гаалийн бүрдүүлэлтгүй нүүрс тээвэрлэх, экспортлох, татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасан журмын дагуу хариуцлага хүлээлгэж, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах. Гааль болон хилийн хяналт шалгалтын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хуулийн төслийг боловсруулж

2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

10.“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” хувьцаат компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтад хийсэн Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Түр хорооны үйл ажиллагаанд саад учруулсан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын асуудлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

“Тавантолгой” хувьцаат компани “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнд үндэслэн боловсруулсан Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Хянан шалгах түр хороо татан буугдахаасаа өмнө өнөөдөр багтааж нийт хяналт шалгалтаар илэрсэн нотлох баримт 9177 хуудас бичиг баримтыг өнөөдөр Монгол Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагуудад шилжүүлж, гэмт хэргийн шинжтэй асуудлыг шалган холбогдох хүмүүст хариуцлага тооцуулах асуудлыг шилжүүлсэн болно.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Эрдэнийн Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хуулийн газрын дарга, Хүүгийн Мөнхжаргал “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын

газрын дарга, Чулуундаваагийн Анхбаяр Хянан шалгагч, Идэрийн Уянга хянан шалгагч, Чулуунбилигийн Ням-Оюун хянан шалгагч, Батмөнхийн Хишигтогтох хянан шалгагч, Очирбатын Лхагвадорж шинжээч, Очирхуягийн Мөнхбат шинжээч, Гантөмөрийн Жавхлан шинжээч, Соёлсайханы Энхзориг шинжээч, Болдын Ариун шинжээч, Чагнаагийн Баярмаа шинжээч, Баясгалангийн Сугармаа шинжээч, Балдоржийн Сүнжидмөнх шинжээч, Шагдарын Ариунболд шинжээч, шинжээч Буянхүүгийн Батдэлгэр.

Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлт болон тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд?

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүнийг нэмье. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу сонсголыг зохион байгуулж байгаа. Ер нь бол парламент дээр бол асуудлаа авчирч ярина, олон түмэнд мэдээллийг хүргэнэ гэдэг бол маш чухал асуудал. Тэгээд энэ сонсголыг бас тодорхой хэмжээнд олон нийтийн тэр мэдэх эрхэд нэлээн сайн мэдээллийг хүргэсэн ийм сонсгол болсон гэж бас Энхбаяр сайдад бас талархах нь зүйтэй. Тэгэхдээ энд оролцож байгаа оролцогч нарт, ялангуяа бизнесийнхэнд хэтэрхий ийм хатуу хандсан ийм тохиолдлууд гарсан. Өөрөөр хэлбэл, нүүрсний жолооч нар. Тэр хүмүүс чинь жишээ нь Улаанбаатар-Увс хоёрын хооронд 14 хоног хийгээд 1 сая төгрөгийн ашиг олдог байсан тэр жолооч нар тэнд ашигтай тээвэр байна гэх дээр тийшээ л явцаасан улсууд байхгүй юу даа. Тэнд очиж өөрсдийнхөө үр хүүхдийг сайхан амьдруулахын төлөө, ашиг олохын төлөө л тийшээ явцаасан. Тэдний буруу гэж ерөөсөө байхгүй. Тээврийн хэдэн машинтай компаниуд байгаа. Өөр бизнес хийж байгаад тэнд ашигтай бизнес

байна гэхлээр нь тэнд машин худалдаж аваад оруулсан тэр компанийн буруу гэж ерөөсөө байхгүй. Тэр хүмүүс өөрсдийнхөө тэр ажилчдыг ажилтай болгохын төлөө л тэр компаниуд зүтгэсэн. Хөрс хуулагч оператор олборлогч компаниуд байна. “Мак махан”, “Ти Ти Жи Ви Ко” энэ тэр чинь дээр үед Мак мах нь жишээ нь 8 доллароор хөрс хуулдаг байсан шүү дээ. Энэ Монголын хэдэн компаниуд чинь үзэж тарж, үсэрч наалдаж, Монголынхоо ард түмний төлөө энэ үнийг буулгасаар байгаад буулгасаар байгаад өнөөдөр 3 доллар дээр буулгасан байгаа шүү дээ. 8 доллароос 3 доллар руу. 70 хувиар, 60 хувиар буулгасан. Энэ хүмүүс тэр их хөрөнгийг алдаг байсныг буцааж энэ Монголдоо хямдхан хөрс хуулсны төлөө энд бас ингэж чичлүүлэх ёсгүй л байсан гэж би үздэг.

Ер нь энэ хүмүүс дээр асуудлыг ярих биш, харин авлигал хээл хахуулийг цэцэглүүлсэн тэр төрийн албан хаагч нартай асуудлаа ярих ёстой байсан байхгүй юу даа. Тэгээд би 2024 оны сонгуулийн дараа энэ Нүүрсний сонсголыг хийнэ. Нүүрсний сонсгол хийхдээ тэр тээврийн компаниуд, тээврийн жолооч нар, хөрс хуулалтын компанийн жолооч нар, дээрээс нь энэ асуудалд огт холбогдоогүй энэ Их Хурал, Засгийн газрын арваадхан гишүүн байгаа. Тэр хүмүүсийг авчирч ер нь бол энэ нүүрс Монголчуудыг тэжээж байгаа. Гол орлого оруулж байгаа 10 доллар тутмын 6-г нь оруулж байгаа ийм бүтээгдэхүүн энэ нүүрсийг магтаж тэнд оролцсон тэр тээврийн компани, жолооч нар, олборлогч компани, тэгээд дээрээс нь асуудалд холбоогүй Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүдийг оролцуулсан тийм дэмжсэн нүүрсний сонсголыг хийнэ.

Харин тэрний дараа нүүрсний хулгайн сонсгол хийнэ. Нүүрсний хулгайн сонсголыг. Энэ сонсохлоор тэр “Си” зөвшөөрлийн хулгай, тэр бөмбөлөг, бөмбөлөгтэй холбоотой ХӨСҮТ-ийнхөн, хуулийнхан, хил, гаалийнхан, тэгээд энэ

авлигыг, системийн авлигыг бий болгосон энэ төрийнхөн, энэ бүх зүйлийг хүмүүсийг авчирч, дуудаж тэр тонн тутамд 2, 3 долларын авлигал авдаг албан тушаалтнууд, эрх мэдэлтнүүд, энэ бүх хүмүүсийг дуудаж авчирч нүүрсний хулгайн сонсголыг хийнэ. Энэ сонсгол дотор бол эрх баригч зарим нэгэн хүмүүсээ хамгаалаад үлдсэн, гол нөхдүүдийг дуудаагүй ийм асуудлууд ард түмэн дотор яригдаад байж байна. Бүх хүмүүс бүгдээрээ мэдээлэлтэй шүү дээ. Тэнд явж байгаа жолооч нар, тэнд явж байгаа тээврийнхэн бүх хэн энд юманд оролцдогийг.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

**Д.Өнөрболор:** Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны хяналт шалгалтын ажлыг үндсэндээ дэмжиж байгаа. Улс төрийн эр зориг гаргаж байгаад бас талархаж байна. Гэхдээ цаашид бас энэ арга замаар улс төрийн өрсөлдөгчдөө намнах ийм арга хэрэгсэл болж даамжрах вий дээ гэсэн болгоомжлол ч нөгөө талдаа бас байна.

Тэгээд 30 гаруй жил ер нь манай улс орон нэлээн л ололт, амжилттай байсны хажуугаар энэ гажуудуулсан алдаа үнэхээр савнаасаа хальж гарчээ. Товчхондоо төр өөрөө алдаа гаргаж, хяналтаа ч алджээ гэж бол харагдаж байна. Бид энэ сонсголын ачаар ер нь Өмнөговь аймагт үүрлэсэн байж байгаа улс орноо томж дээрэмдсэн энэ түүхийг бас ил болголоо. Энэ тайлангаас харвал шулуухан хэлэхэд орон нутгийн жижиц Тавантолгойг Ардчилсан нам ер нь эзэн суужээ. Энэ орон нутгийн ИТХ ер нь дураараа дургиад зогсохгүй үр хүүхдүүдээ хүртэл энэ компани байгуулаад ханцуй шаналж, цаашид ер нь энэ хулгай луйвар тасрах биш харин ч үргэлжлэх ийм болгоомжлол байна гэж бол харагдаж байна.

Ялангуяа энэ жил сонгуулийн жил байгаа. Тэгэхлээр тойрог томсохын

хэрээр өндөр зардалтай. Тэгээд энэ нүүрсний хулгайгаар мөнгөжсөн хүмүүс тэр хэмжээгээрээ орж ирээд энэ хэн ч хариуцлага хүлээхгүй үлдэх вий дээ гэдэг дээр бол ард түмэн бас ма нэлээн санаа зовж байна. “Эрдэнэс Тавантолгой” ер нь энэ эрх баригч хоёр нам, тэр дундаа бол манай нам ч гэсэн асар их алдаатай бодлого явуулж ер нь хяналтаа алдсан байна. Энэ нүүрсний хулгай сүүлийн 10-15 жилд нүүрлэсэн. Энэ сонсголын үйл явцаас ингээд харахад ер нь ард түмнийг төлөөлж, төр түшиж эрх мэдэлд байсан зарим хүмүүс энэ сонсголд дуудагдаад тэгээд гайхаад сууж байгаад бол үнэхээр харамсаж байна. Ер нь энэ төр чинь ер нь эзэн байгаа юм уу? Хариуцлага ёс зүй гэж зүйл ер нь хаа байна ?

Тийм учраас ер нь ядаж энэ 2013 оноос хойш үе үеийн Улсын Их Хурал, энэ гишүүд, энэ ерөнхийлөгч нар, Засгийн газар, хоёр нам бас ард түмний өмнө бас уучлалт гуйх энэ наад захын соёлыг бол хангах нь бол чухал байна гэж харагдаж байна. Тэгээд энэ “Эрдэнэс Тавантолгой”-н энэ 110 сая тонн нүүрс олборлосон юм байна гэж бол ойлгож байна. Тэгээд энэ хилээр гаалийн бүртгэлгүй гарсан нүүрсний хэмжээ энэ хэмжээнд орсон юм уу, ороогүй тоо хэмжээ байгаа юм уу гэдгийг бас асууя. Энэ сонсголыг ер нь үр дүнтэй, ийм хариу үйлдэлтэй байгаасай гэж бас миний бие бас хүсэж байгаа юм. Энд тэндгүй ингээд бариад орхичихсон байж байгаа энэ төмөр зам, мухар төмөр замуудаа ер нь цаашидаа яах юм бэ? Энэ замуудаа яаралтай холбож, экспорттоо нэмэгдүүлэх шаардлага өнөөдөр Монгол Улсад тулгарч байна. Хятад бол ер нь дэлхийн хамгийн том нүүрс хэрэглэгч, импортлогч орно шүү дээ.

Тэгээд өнөөдөр Монгол Улс ер нь яг энэ зах зээлийн өрсөлдөөнд ер нь яг хаана нь яваа юм бэ? Бизнесийн өрсөлдөөн талаас нь ингээд аваад үзэх юм бол газар зүйн байршлын хувьд бол Монгол Улс хамгийн давуу талтай болчихоод байдаг. Нүүрсний бизнес



ерөөсөө уул уурхайн бизнес гэхээсээ илүү ер нь тээврийн л бизнес шүү дээ. Тэгээд хэн бага өртөгтөө хүргэж чадсан тэр нь л илүү ашигтай ажиллах боломжтой. Тийм учраас энэ асуудлуудаа яаралтай ишийдэх хэрэгтэй. Ер нь энэ өнгөрсөн хугацаанд энэ худалдааны эрх зүйн бодлого ер нь зохицуулалтгүй явж ирсний хар гай юм. Үүнтэй бол шууд холбоотой. Мэдээж энэ биржийн зохицуулалттай болсноор өнөөдөр тодорхой эерэг үр дүнгүүд гарсныг бол үгүйсгэхгүй. Гэхдээ бирж бол худалдааны нэг л арга зам.

Цаашидаа бол энэ тээвэр логистик, олон улсын гэрээ хэлцэл, тэгээд л татвар, гадаад харилцаа, эдийн засгийн үр өгөөж гээд маш олон нарийн ийм дэг журмуудтай.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр асуултад хариулна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын гол үүрэг бол ард түмний төлөөллийн байгууллага. Тэр утгаараа ард түмний мэдэх эрхийг хангах. Мэдээж бие биеийгээ хардсан, сэрдсэн ийм юм бол Хөгжлийн банк дээр ч байсан, сая нүүрс дээр ч байсан. Баттулгын хулгайг ярингуут Хүрэлбаатар баярлаад л сэвж өгнө. Тэгээд нөгөө талыг нь хулгай нь ярингуут Баттулга нь баярлаад л сэвж өгнө. Тэгээд энэ Түр хорооныхных чинь сүүлдээ тэрний хүн, энэний хүн, ер нь бүх хүний хүн болсон шүү дээ. Анхнаасаа чи үүнийг мэдэж байсан. АН нь яригдахаар МАН-ынхан захиалгаар хэллээ гэнэ. Манайхан баярлаад л байсан.

Сүүлдээ манайхан яригдаад эхэлсэн чинь сүүлдээ АН-ныхны захиалгаар ингэлээ гээд л ингэсэн. Пүүжээ гишүүний хэлж байгаачлан хэдхэн жолооч авчраад байцаагаад, жижгэрээд байсан юм ерөөсөө байхгүй. Гаалийн бүрдүүлэлтгүй тээврийн хэрэгсэл гарсан 3 мянга орчим тээврийн хэрэгслээс 5-хан жолоочийг түүвэрлэж

сонсголд авчирсан. Тэр нь тэдгээр хүмүүсийг яллах гэхээсээ илүү тухайн жолооч нар ер нь гаалийн бүрдүүлэлтгүй гарч байсан эсэх, тээвэрлэлтийг яаж хийдэг юм, асуудал тээврийн хэрэгслийн жолоочтой байна уу, тээвэр хийлгэж байгаа компани байна уу, тэнд хил, гаальтай холбогдсон асуудал байна уу, татвараас зайлсхийж байгаа асуудал байна уу, эсвэл өөр үгсэн хуйвалдсан санаа зорилготой үйл явц байна уу гэдгийг тодруулах, ард түмний мэдэх эрхийг хангах хүрээнд асуулт асуугдаж, хариулт авагдсан. Энэ нь тэр хүмүүс огт буруугүй гэдгийг та ч нотлохгүй, би бас нотлохгүй. Яагаад?

Яагаад гэхээр энэ нотлох баримтын шинжлэн судлах сонсголд зөвхөн нотлох баримтаар нотлогдсон асуудал яригдсан. Нотлох баримтаар нотлоогүй буюу эдгээр хянан шалгах шинжээчдийн хүрээнд нотлох боломжгүй, гэмт хэргийн шинжтэй мөрдөн шалгах үйл ажиллагааны хүрээнд шалгагдаж, илэрвэл зохих үйл баримтууд бол байсан. Энэ нь тухайн мөрдөх алба, хууль хяналтын байгууллагаар эцэслэн нотлогдоогүй байсан учраас яригдаагүй байхгүй юу. Тэрнээс биш огт нотлох баримтгүйгээр хүн дуудаад, ялаад асуугаад байсан зүйл байхгүй. Түүрүүн “Тавантолгой” компанийн талаар авах юун дээр 5.2 сая тонноор худлаа дүгнэлт гаргачихсан юм шигээр “Эрдэнэс Тавантолгой”-н БЭТ хариулж байна лээ. “Эрдэнэс Тавантолгой” компанийн архивын материал өөрөө ямар ч эмх цэцэггүй, компаниараа, тээврийн хэрэгслийн дугаараараа биш бөөнөөрөө агуулахад хадгалагдаж байгаа. Бид нарыг зүгээр ороод үзээд шалга гэж хэлж байсан. Өөрөөр хэлбэл энийгээ илрүүлэхгүй байх зорилгоор архивын нэгж бүрдүүлэхгүйгээр зориуд ийм эмх замбараагүй байдлаар одоог хүртэл архивлаад хадгалаад явж байгаа. Тэгээд яаж гэм буруугүйгээ өөрсдөө нотлоод байгаа юм?

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Асуулт, үг хамт явж байгаа.

**М.Оюунчимэг:** Ямар ч байсан Улсын Их Хурал бол парламент ард түмний төлөөллийн байгууллага. Ард иргэдийнхээ мэдэх эрхийн тал дээр энэ Хянан шалгах түр хороо бол бас бүх бололцоогоороо бол сайн ажилласан, энэ ажиллах бололцоогоороо бас хангаж өгсөн Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Улсын Их Хурлын дарга Занданшатар даргад бол бас бид талархах ёстой. Яагаад гэвэл ард түмэн энэ Түр хорооны мэдээллээс, Хөгжлийн банкны, сая Нүүрсний мэдээллээс бас нэг ийм дүр зураг бол олж харсан. Ямар дүр зураг байна гэхээр энэ ард түмний өмч шүү дээ. Байгалийн баялаг бол бүгд тэгш хүртээх ёстой.

Гэтэл энэ бас нэг тал нь нэг хэсгээрээ үнэхээр алдагдсан боломж болгож, хулгайн зам руу нэлээд их хэсэг нь бол урссан нь бол шинжээчдийн маань дүгнэлтээр ерөнхийдөө бол зарим нь тодорхой болсон. Энэ 5 сая гээд яриад байгаа тоо нь буурч ч болно, дээшээ ч болж магадгүй. Үүнийг хэн тогтоох юм? Хууль хүчний байгууллага, цагдаа хүчин л тогтоох ёстой одоо. Харин үүнийг тэрнээс бид зүгээр л ард түмэнд мэдэх эрхийг нь нээгээд, гэрчдээс мэдээлэл авсан, шинжээчид нэлээд нарийн дүгнэлтүүд хийсэн. Гэхдээ шинжээчдийн дүгнэлт бүгд үнэн гэсэн юм бас биш. Энийг харин гаргаж ирснийг нь тэр холбогдох хуулийн, хүчний байгууллагууд нь энэ нь үнэн байна, энэ нь ийм байна, үнэхээр гэмт хэргийн шинжтэйг нь харууцлага тооцох ёстой. Өнөөдөр ард түмэн бол энэ мөрдөн шалгах байгууллагуудын үйл ажиллагаа руу нэхэл хатуутай нийгэм харж байгаа гэдэг нь бол бас үнэн шүү. Тэрийг бас хэлье гэж бодож байна.

Монгол Улсын нүд чих болсон байгууллага, хил, гааль, татвар, Үндэсний архивын газрын хоорондын

мэдээлэл гэхэд үнэндээ бүгд хоорондоо эрс зөрүүтэй. Ямар ч тэд нараас бодит мэдээлэл авах нэгдсэн платформ байхгүй гэдгийг сая энэ Нүүрсний сонсгол бол бүүр баталгаатай харуулсан. Тэр тухайн байгууллагууд нь ч өөрсдөө үүнийг бараг хүлээн зөвшөөрөхөд хүрч байна шүү дээ. Гааль нь тодорхой бас юм гаргаад өгчихсөн байхад тэр нь татварынхтайгаа зөрчихдөг, татварынх нь хилийнхтайгаа зөрчөөд байдаг. Тэгээд ийм зүйлүүд байгаад байна шүү дээ. Тийм учраас бид нар энэ тогтоол дээр ч гэсэн энэ Монгол Улсын нүд чих болсон байгууллагуудын нэгдсэн мэдээллийн платформтой болох энэ хууль, эрх зүйн актуудаа гаргаж өгөх энэ зүйлүүдийг бол бодитоор бас тусгаж оруулж өгсөн байгаа.

Нөгөө талаасаа үнэхээр алдагдсан боломж бол байна. Одоо яах вэ сая 826 сая ам.доллар нь алдагдсан боломж гэж яриад байгаа ч энэ яг хэд юм гэдгийг бид бол тодорхой бас дараа нь бол тодорхой болох байх. Уг нь яг үнэнийг хэлэхэд үүгээр Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллыг байшин хороолол болгоод бүрэн дэд бүтэц татчих мөнгө зүгээр л хулгайгаар гарсан гэдэг нь бол бас тодорхой байгаад байгаа шүү. Энэ дүр зураг дээр. Бид энэ үнэхээр байгалийн баялгийг бид Үндэсний баялгийн сангаараа дамжуулаад улс орны урт хугацааны хөгжилд, өнөөдөр болоод маргааш ирээдүйд олон түмэн ард иргэдийнхээ тэгш хүртээмжтэй байхаар ингэж бий болгоно гээд Үндсэн хуулийнхаа 6 дугаар зүйл дээр бид зааж өгсөн.

Гэтэл энэ үнэхээр өөр замаар яваад байгаа. Бүүр бүхэл бүтэн нээрээ түрүүн хэлж байна авлигын систем яаж барьж болохыг бас үзүүлээд байна гэдэг шиг ийм зүйлүүд бол бас байгаад байна. Одоо үүнийг бид таслан зогсоохгүй бол Монгол Улс маань өнөөдөр энэ агаар, хөрсний бохирдол энэ эрүүл мэндийн салбарын хүндрэл энэ боловсрол нь нөгөө дүгээр зууныхаа ширээ, сандалдаа сууж

байна гэдэг бол байж байх л юм байна. Тэгэхээр энд хяналт хэрэгтэй байна. Үүнийг сая Улсын Их Хурлын энэ Нүүрсний хянан шалгах түр хороо тодорхой хэмжээгээр бас бид үүнийг харууллаа. Харин энэ нь ажил хэрэг болгох нь саяын хэлээд байгаа мөрдөн шалгах байгууллагуудын үйл ажиллагаанаас бол хамааралтай. Үүнийг бас би хэлчихье гэж бодож байгаа.

Нөгөө талаасаа бас энэ Хянан шалгах түр хорооны ажлын дүгнэлтийн үр дүн бас тодорхой хэмжээгээр гарч байх шиг байна. Манай энэ мөрдөн шалгах ажиллагааныхан сая жишээ нь жижиг Тавантолгойтой холбоотой тэр Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж газар гаднынханд бүүр хууль зөрчиж өгсөн тэр асуудлаар шалгаад эхэлчихсэн юм байна лээ. Үнэн мөн нь тогтоогдох байх нэгдүгээрт.

Хоёрт нь өнөөдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зүгээс “Эрдэнэс Тавантолгой” компанид манай энэ тогтоол дээр бас орж өгсөн байгаа энэ Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулахдаа шалгаруулахад оролцсон “МТАС” түншлэлтэй 2021 оны 11 сарын 17-ны өдөр байгуулсан Тавантолгойн ордын.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Хариулт. Баттөмөрийн Энхбаяр. Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн асуултад хариулна.

**Б.Энхбаяр:** Оюунчимэг гишүүн өнөөдөр энэ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гараад байгаа Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас Бортээгийн нүүрсний уурхайн гэрээт борлуулагчийг сонгон шалгаруулах тендерийг цуцлах үүргийг өгсөн. Үүнтэй холбоотойгоор Монгол Улс 50 сая долларын өрөнд энэ түр хорооны хяналт шалгалтаас болоод орж, орох эрсдэл үүсэж байгаа мэт энэ асуудал дээр асуулт асууж байна л даа. Өөрөөр хэлбэл, Энхбаяраа, чиний хяналт

шалгалтаас чинь болоод Монгол Улс 50 сая долларын өрөнд орчхож байгаа юм биш биз дээ гэж асууж байх шиг байна. Тийм юм байхгүй. Саяын хэлсэнчлэн Улсын Их Хурлын хяналт шалгалтаар энэ асуудал анхнаасаа дуусах хүртлээ Монгол Улсын хуулийг зөрчсөн нөхцөл байдал тогтоогдсон. Нотлох баримтаар. 1 компанид давуу байдал олгосон хүмүүсийн албан тушаалын гэмт хэргийн асуудал үүний дараа яригдана.

Мөн үүнтэй холбоотой хууль хяналтын байгууллагаар нэмж тодруулах шаардлагатай 30 сая долларын асуудал шалгагдах ёстой. Энэ ямар учиртай бэлэн мөнгө хэнд цаашаа өгөгдсөн, хаанаас эх үүсвэртэй, яаж Монгол Улсын хилээр орж ирсэн асуудал шалгагдах ёстой. Үүнээс болоод Монгол Улс 50 сая долларын өрөнд орчих асуудал байхгүй. Харин үүнийг хүчингүй болгох өнөөдөр Түр хороо тайлангаа тавихаас өмнө тайлан тавиад бид тогтоол гаргаад угаасаа үүнийг хүчингүй болгох гэж байгаа. Улсын Их Хурал шийдвэр гаргах гэж байгаа. Үүнээс өмнө амжиж тухайн зүйлийг хууль бус байдлаар хүчингүй болгоод, хууль зүйн үндэслэлгүй хүчингүй болгосон гэдгээр Монгол Улсыг харин өрөнд оруулах операц явагдаж байгаа эсэх, байхыг үгүйсгэхгүй. “Эрдэнэс Монгол” компаниас “Тавантолгой” компанийн БЭТ-д өнөөдөр үүнийг яаралтай хүчингүй болгох бичиг явсан байна лээ. Энэ асуудал хууль тогтоомжийнхоо дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу хүчингүй болох ёстой. Тэгж байж тэр шийдвэр хууль зүйн үндэслэлтэй буюу Монгол Улс ямарваа нэгэн компанийн өмнө үүрэг хүлээсэн хууль зүйн үр дагавар үүсэхгүй.

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тогтоолоос өмнө, Түр хороо тайлангаа тавихаас өмнө урьтаж хууль зүйн үндэслэлгүйгээр хүчингүй болгож Монгол Улсыг олон сая долларын өрөнд унагаах санаархалтай үйл ажиллагаа явагдаж байхыг би харин үгүйсгэхгүй. Тийм ч учраас “Тавантолгой” компанийн бүрэн

эрхт төлөөлөгч Ганбатад энэ асуудлыг Улсын Их Хурлын шийдвэр гаргахаас өмнө шийдвэрлэхгүй байхыг сануулса. Хууль сануулсан байгаа би урьдчилж.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Тэгэхээр Хянан шалгах түр хороо гэдэг бол багийн ажил. Дарга нь ч, гишүүд бид ч гэсэн хамтдаа бол энэ бүхнийг хийж байгаа учраас бид нар үүнийгээ бас өнөөдөр чуулган маань нээлттэй хэлэлцэж байгаа нь маш сайн байна. Тэгэхгүй бол бас үүнийг хаалттай хэлэлцье гээд л асуудал гаргаад байсан. Сая Их Хурлын дарга үүнийг нээлттэй хэлэлцье гээд ингээд явж байна. Тэгэхээр бид нээлттэй хэлэлцэж байгаа учраас бас энэ иргэддээ зөв мэдээлэл өгч байна. Тэгэхгүй бол олон нийтийн сүлжээгээр бас ийм юм яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр сая Хууль зүйн сайд хүн өөрөө хариуцлагатай мэдээлэл өгч байгаа юм байна. Тэгэхээр энэ асуудал дээр бол “Эрдэнэс Тавантолгой” компанийнхан маань бас анхаарах байх гэж бодож байгаа.

Ер нь бол энэ хяналт шалгалтын үр дүнд зөвхөн Цагаан хад суурьшлын бүсэд байрлах мэдээллээ явуулсан 36 НАБТ-д бүртгүүлсэн хэмжээнд явсан. Тэгэхээр өөр зөндөө асуудлууд байгаа. Тэгэхээр үүнийг бас шалгах шаардлага байгаа гэдгийг манай шинжээчид хэлээд байгаа. Тийм учраас бид нар энэ байгалийн баялаг бол хулгайн замаар орохгүй, харин үндэсний баялаг болоод үндэсний сандаа хуримтлагдаад улс орны хөгжил, иргэдийнхээ амьжиргаа, орлогод нөлөөлдөг байх тийм асуу.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Би шууд сайн, муу талыг нь бүгдийг нь зэрэг дурдаад явчихъя. Сайн тал бол их байсан. Монгол Улсын Их Хурлаар энэ хяналт

шалгалтын хуулийг бол гишүүд санаачилж батлуулсан. Би бас энэ санаачлагч нэг гишүүний хувьд бол бас энд бол их баяртай байна. Түр хорооны дарга Энхбаяр, энэ гишүүдэд бол бас баяр хүргэе. Энэ бол маш их хүч хөдөлмөр орсон бас нэлээд галтай ийм том зориг шаардсан ийм ажил байсан. Монгол Улсын энэ сонсголоор анх удаа Улсын Их Хурал иргэдийн мэдэх эрхийг хангасан. Энэ бол хамгийн чухал. Өмнө нь бол хуулийн байгууллага мэдээлэх боломжгүй энэ олон асуудлуудыг гаргаж ирсэн сонсголоор. Хуучин бас найз дундаа явдаг нам, нэг нам ч гэдэг юм уу ингээд хаацайлдаг байсан зүйлүүдийг төгсгөл болгож гаргаж ирсэн. Өөрөөр хэлбэл хонгилын үзүүрт гэрэл харагдаж байна гэсэн үг.

Хоёрт, энэ оролцогчид өөрсдөө презентаци бэлдээд ,тайлбар хийх боломжийг олгосон. Энэ их чухал байсан.

Гурав дахь зүйл бол энэ ТӨК дээр төрийг төлөөлж байсан хүмүүс, иргэдийг төлөөлж байсан хүмүүс ямар хариуцлагагүй, санаатай ийм үйлдлүүд гаргасныг ил тод болгосон. Өөрөөр хэлбэл, дэлхийд бид нар, төрийн байгууллага нь хавсарсан ийм мафиин сүлжээ байдаг юм байна гэдгийг бол харуулсан. Тэгэхдээ энэ бол шившигтэй л юм л даа нэг талаасаа. Нэг сайн тал юу вэ гэхээр бас энэ баялаг бүтээгч аж ахуйн нэгжүүдэд ерөөсөө тэгш боломж олгодоггүй юм байна. Хэн даргад ойрхон, хэн тамгад ойрхон аж ахуйн нэгжүүд эд энэ боломжийг эдэлдэг юм байна гэдэг нь ил тод болсон. Гэхдээ бизнес эрхлэгчдийн маш их урмыг хугалсан. Баялаг бүтээгчид энэ бид нар тэгш боломжийг хангах ёстой хангах чиглэл рүү төрийн бодлогыг чиглүүлэх ёстой байтал энэ оролцсон аж ахуйн нэгжүүд хулгайн замаар татвараас зугтаасан нь энэ маш ноцтой ийм гэмт хэрэг дэмжсэн ийм үйлдэл болсон.

Нэг нотой асуудал юу вэ гэхээр төрийн маш чухал бичиг баримтуудыг

устгасан гэсэн ийм зүйл гарч байгаа. Би дүүрэгт байсан. Маш нарийн архивын стандартыг мөрддөг. Гэтэл яагаад энэ бичиг баримтуудыг устгав? Одоо Энхбаяр сайд эдгээр хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээх, ялыг чангатгах ийм хуулийг оруулж ирэх ёстой. Яахаараа энэ төрийн бичиг баримтыг ингээд дураараа устгадаг юм?

Сөрөг талууд бол байсан. Сөрөг талууд дээр юу байсан бэ гэхээр энэ мэдээж анх удаа хийж байгаа учраас энэ асуудал бол хэцүү л байсан л даа бас ингээд туршилага хэрэгтэй, парламентын мэтгэлцээний соёлд бид нар сурах хэрэгтэй. Гэрчлэх гэж ирсэн хүмүүсийг бүгдээрэнг нь ерөөсөө нийгэм нэг ийм гэмт хэрэгтэн юм шиг бас хүлээгээд авчихсан тал бий. Ингээд сошиалаар гарч байгаанууд нь. Тийм учраас энэ дээр бид нар жоохон ялгаатай хандах байсан. 2

Хоёрдугаарт онцын хамааралгүй хэт олон гэрчийг дуудсан энэ цаг алдсан нь яг гол буруутай, энэ бүхний ард байдаг энэ бүхнийг зохион байгуулсан гол толгойлогчид, гол улс төрчдийг оролцуулж чадаагүй. Тийм учраас энэ дээр бол иргэд бол бас нэлээд сэтгэл дундуур байсан. Маш олон хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд рүү буруутай мэтээр гаргаад байсан боловч яг энэ төрийн байгууллагын хариуцлага алдсан хүмүүсийг ерөөсөө бурууг нь энэ дээр төдийлөн ингэж гаргаж бол чадаагүй. Бүгдээрээ л буруугүй юм шиг. Тийм учраас энэ дээр ийм сөрөг зүйлүүд гарсан.

Тэгэхээр яаралтай одоо энэ хууль, хяналтын байгууллага, шүүхийнхээ ажлаа хий. Гэм бурууг нь яаралтай тогтоо. Энэ бол энэ дээр бол нэг их.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Нүүрсний сонсгол явлаа. Тэгээд ард түмэн мэдэх

эрхээрхийнхээ дагуу зарим зүйлүүдийг мэдэж авсан байх гэж ингэж бодож байгаа. Энэ Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийг санаачлагчийн нэг нь сая Одонтүяа гишүүн, бид нар юм байгаа юм л даа. Бид нар бүгд санаачилсан юм хамтарч. Энэ Нүүрсний сонсгол гэдэг юмыг бас санаачлагч хүний нэг нь би юм байгаа юм. Бас гарын үсгээ зурсан, хоёулаа байгаа. Ер нь бол явлаа. Яах вэ энэ дээр бол бас ололттой талууд бас байна, дутагдалтай юм байна. Шинэ юм болохоор бас засаж сайжруулах, цаашаа янзлах барих зөндөө юмнууд байгаа байх л гэж ингэж бодож байгаа юм.

Хамгийн гол нь бол ард иргэдийн хувьд тэр гэрчүүдийг байцуул гэсэн шүү дээ. Ер нь тэгээд цаашидаа яах юм? Энэ дараагийн дараагийн иймэрхүү сонсголуудтай гэрчүүдийг яаж байлгах, тэр яллагдагчаар татагдсан хоригдож байгаа улсуудыг цахим махимаар ч оролцуулах уу яах вэ? Үгийг нь сонсдог ч юм уу, ямар юм байх юм үүнийгээ үзэх л ёстой л гэж ингэж бодогдож байсан.

Ер нь Тавантолгойн нүүрсний асуудал гэхэд хэдхэн л асуудал байгаа шүү дээ. Том асуудал гэх юм бол.

Нэгдүгээрт нь ямар вэ тэр оптек гэрээ тойрсон 11 гэрээ байгаа. Энэ бол бүрхэг л байгаад байгаа.

Хоёрдугаарт нь 5.2 сая тонн бүрдүүлэлтгүй гарчихсан гэсэн шүү. Энэ асуудал маш ноцтой хэрэг шүү дээ. Энэ чинь гаалийн бүрдүүлэлтгүй улсын хилээр гарсан.

Гурав дахь асуудал. Энэ 7 сая тонн коксжих нүүрс эрчим хүчний нүүрс болоод гарчихсан гэж байгаа юм. Би дандаа энэ хэвлэл мэдээлэл, янз бүрийн юмнаас олж авсан мэдээллээ хэлж байна шүү. Хятадын зах зээлд 1 тонн коксжих нүүрс 400-700 доллар байхад 60 доллароор манайхан гаргаж байсан. 570 орчим гэрээ байгаа. Сая тэр Энхбаяр

сайдын ярианд гарч байна 13 их наяд төгрөгийн худалдан авалт гэж байна. Энэ дотор бол маш ноцтой юмнууд байгаа.

Тэгээд энэ хууль, хяналтын байгууллагууд нь үүнийг одоо шалгаж байгаа биз дээ. Маш нүсэр ажил л даа. Энэ яаж шалгаж дуусах юм байгаа юм. Аймшигтай л том хэрэг шүү дээ. Тэгээд алдагдсан боломжийн өртөг гээд 826 сая доллар гээд хэлчих шиг боллоо. Энэ үүнээс маш том байгаа шүү. Энэ бол монгол төгрөгөөр бол 2.7 их наяд төгрөг л гэж л гарч байна л даа.

Ер нь энэ Тавантолгойн асуудал өнөөдөр Монголын нийгэмд Монголчуудын байж байгаа юм л яг л харагдаж байгаа шүү дээ. Бүх юм нь л энэ шүү дээ. Хулгай, авлигал ийм л байгаа байхгүй юу. Тэгээд энэ яах вэ дэ энэ сонсголын үр дүнг цаашаага тэр холбогдох хууль, хяналтын байгууллагууд нь өгөх юм байна, ингээд шалгагдаад явах юм байгаа биз гэж. Энэ сонсголоор хүний нэр төрд халдаж болохгүй. Хэлмэгдэл үүсгэж болохгүй шүү. Энэ шинжээч нар та нар Сонсгол даргалагчийн хувьд бол бүгдийг нь мэдэх албагүй. Та нар нас барсан хүн дуудчихсан байгаа шүү дээ. Тийм байж болохгүй шүү дээ.

Дараагийн асуудал юу гэхлээр зэрэг, би дуудагдсан. Сонсгол даргалагч залруулсан. Надыг Гаалийн ерөнхий газрын даргаас чөлөөлөгдөөд явснаас хойш 5 жилийн дараад энэ ажил нь эхэлсэн байдаг. Би бас дуудагдсан.

Дараагийн асуудал юу гэхлээр зэрэг надтай холбогдуулаад миний хүүг “Шинэст-Өргөө” гэдэг компанитай холбоотой. Би танай сонсголынхонд 2 удаа бичиг бичсэн. Хариу байхгүй. Улсын бүртгэлээс хариу авлаа. Тийм холбогдол алга. Авилгатай тэмцэх газарт хандаад Даидаваа даргад хандаад бас өргөдөл гаргалаа. Танд холбогдол алга. Таныг гүтгэсэн байж болзошгүй байна.

Өргөдөл гомдлын хуулийн дагуу үүнийгээ судалж шийдвэрлүүл гээд ийм хариу өгчихсөн байгаа юм. Тэгээд ер нь хүний нэр төр гэдэг бол хамгийн ариун нандин зүйл. Тийм учраас дараа дараагийн юман дээрээ үүнийгээ.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр энэ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Нүүрсний сонсголыг Улсын Их Хурлын түр хороо зохион байгуулсан. Энэ түр хороо ер нь байгуулагдаад 2 жилийн нүүр үзэж байж өнөөдөр бид энэ Улсын Их Хурал дээр энэ асуудлыг авч хэлэлцэж, тодорхой шийдэл гаргахын төлөө анхаарч ажилласан гэж ойлгож байгаа.

Тэгэхлээр энэ Нүүрсний Түр хорооны анхны нотлох баримтын хэмжээнд цуглуулсан нотлох баримт энд хэлэлцэгдээгүй, зорилгоосоо хазайсан гэж үзэж байгаа. Төр, хувийн хэвшлийн нүүрсний асуудал, худалдааны борлуулалтын асуудал, тээвэр ложистикийн асуудал, улсын хилээр нэвтрүүлсэн асуудлыг энэ түрүүчийн Түр хороо бий болгосон байсан. Өнөөдөр Монгол Улс 23 онд 68 сая тонн нүүрс гаргасан. Үүний 28 сая тонн нь төрийн өмч, орон нутгийн өмчийн Тавантолгойн нүүрснүүд, 40 сая тонн нүүрс өнөөдөр Монгол Улсын хилээр гарсан байгаа. Энд хамгийн том булхай луйвар байсан. Түүний дотор Ховд аймаг дахь “Хөшөөт”-ийн нүүрсний уурхай. Энэ Түр хорооны шинжээчдэд би маш их эргэлзэж байгаа. Өнөөдөр яах вэ ингээд энэ парламентын үед энэ асуудал чинь ингээд дуусаж байгаа гэж битгий ойлгоорой. Цаг хугацаа гэдэг юм байгаа. Дараагийн парламентын үед энэ асуудал чинь ноцтой сөхөгдөнө шүү гэдгийг бүүр энд зориуд хий тэмдэглэж хэлье.

Өнөөдөр энэ Түр хорооны би шинжээчээс нэг юм асууя. Анхны Түр хороон дээр 2 нас барсан хүнийг дуудсан

та нар. Дараагийнх дээр 1 хүнийг дуудсан. Үүнийг хэн дуудсан юм? Ямар баримтаар яах гэж дуудсан юм? Үүнийг та нар хэлмээр байна. Үүнийг бүүр зориуд би асууж байна.

Хоёрдугаарт нь тэр 5 сая 200 мянган тонн нүүрс гарсан гээд байгаа. Та нар сүүлд энэ чинь одоо энэ гарсан гээд байгаа хүмүүс чинь Их Хурлын бүх гишүүд үүнийг ярьсан шүү дээ. Тэгээд үүнийг хэлэлцсэн юун дээр тэр 2 сая болох юм биш үү, ямар болох юм гэдэг юмыг яригдсан асуудал чинь өнөөдөр нууц биш шүү дээ. Танай Түр хорооны энэ тайлан хэлэлцсэн хурал дээр чинь яригдсан байна лээ шүү дээ. Үүний хариуцлагыг хэн хүлээх юм? Та бүхэн өнөөдөр Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шинжээчийн үүрэг хариуцлага гэж юм байгаа шүү дээ. Үүний тухай яригдах юм уу, аль эс үгүй бол энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын түр хорооны шинжээчид өөр эрх, үүрэгтэй, өөр байдлаар үүнийг шалгасан юм уу? Өнөөдөр ард түмэн энэ мэдэх эрхийнхээ хүрээнд энэ асуудлыг л мэдэхийг л хүсэж байсан. Энд олон асуудал хөндөгдөж ярьсан, олон түрүүчийн Түр хорооны үед яригдаж байсан олон асуудал энд дарагдсан байгаа. Энэ мэдээлэл одоо бид нарт байж байна. Энэ яагаад ийм асуудал гаргасан бэ гэдгийг бас энэ шинжээчид та бүхэн цаг хугацааны хувьд яригдана шүү. Үүнийг бид зориуд энэ протоколд тэмдэглэж үлдээе.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Түр хороон дарга хариулна.

**Б.Энхбаяр:** Ер нь бол сая хэлсэнчлэн хяналт шалгалтын цар хүрээ маань их том. Адьшаа гишүүний асуултад хариулаад хариулаад явчихъя.

Нэг, Ховдын “Хөшөөт”-ийн уурхайг яагаад шалгаагүй вэ гэж? Улсын Их Хурлын энэ Түр хороо бол “Тавантолгой”, “Эрдэнэс Тавантолгой” гэдэг 2 нүүрсний компанийн худалдан

авалт, борлуулалт, тээвэрлэлттэй холбоотой асуудлыг шалгана гэдэг тогтоолоор байгуулагдсан Түр хороо. Монгол Улсын бүх нүүрсний уурхайг шалгах түр хороо биш. Бидний Улсын Их Хурлаас өгсөн даалгавар чиг үүрэгт бусад нүүрсний уурхайг шалгах чиг үүрэг байгаагүй. Бусад асуудал руу орох чиг үүрэг байгаагүй.

Тийм ч учраас өөр асуудал руу ороогүй. Тухайлбал, таны төмөр замын асуудал руу ороогүй жишээлбэл. Зөвхөн энэ 2 компанитай холбоотой асуудлаа л шалгасан. Яг энэ 2 компанитай холбоотой нотлох баримтууд л яригдсан.

Хоёрдугаарт, яах вэ хянан шалгагч шинжээч нар маань арван хоёр, гурван жилийн хугацаан дахь цаасан нотлох баримтуудын хүрээнд хяналт шалгалтаа хийж байгаа юм. Тэгэхээр тэр 10 хэдэн жилийн өмнө гарын үсэг зурсан, шийдвэр гаргасан, оролцсон хүн одоо бас энэ нас барчихсан эсэх асуудлыг энэ хүмүүс маань мэдэхгүй хэдэн мянган хүний л юм шалгаж байдаг. Тэнд нэг Бат юм уу, Дорж гээд нэг хүн гардаг. Тэгээд энэ хүн нь шийдвэр гаргасан байна дуудъя гээд л нэрс орж ирж байгаа. Тэгээд тэр дээр бас ийм алдаа, эндэгдэл гарсан, 2, 3 тохиолдол гарсан.

Тийм учраас би бол 2 дахь Сонсголын үеийн гэрч нарыг дуудахдаа бас хэлсэн. Ийм талийгаач болсон хүний нэр усыг бас дуудсандаа бас талийгаачийн ар гэрийнхнээс хүлцэл өчиж байна гэдгийгээ би бол илэрхийлсэн. Үүнийгээ ч гэсэн бас энэ чуулганы нэгдсэн хуралдаанд албан ёсоор ар гэрийнхнээс нь уучлалт хүсэж байна. Ийм алдаа бас гарсан. Үүнийгээ бол бас залруулж авсан.

Ер нь бол гэрч нарын нэрсийг жишээлбэл 12 цагт Түр хороо хуралдаж гэрч нарын нэрсээ зарлана гэж байхад манай энэ хянан шалгагч, шинжээч нар урьд шөнө нь нойргүй л хонож байсан. 11 хагаст Түр хороонд, даргад нэрсээ бүгдээ

эмхлээд л өгч байсан. Тийм учраас хэн нэгнийг нь онцлоод л, дуудаад л бариад л ингээд байсан гэдэг, эсвэл Түр хороо нь, дарга нь нөлөөлөөд л тэрийг дууд, энийг дууд гээд байсан ийм асуудал бол байхгүй. Таны яригдаж байгаа 5.2 сая тонн нүүрс гаалийн бүрдүүлэлтгүй гарсан гэх, болзошгүй гэх асуудал бол 25 хувийн шалгалтын хүрээнд гарсан асуудал. Түр хороо намрын чуулганы хугацаанд тайлангаа тавих чиг үүрэгтэйгээр байгуулагдсан. Бидэнд 2-хон сарын хугацаа байсан. Би Хөгжлийн банк дээр хагас жил, 6 сар ажилласан. 6 сарын хугацаатай ажиллах ийм бололцоотой хугацаатай байсан сан бол өшөө олон асуудал тодорхой болно. Мөн сая хэлсэнчлэн тэнд яригдаж байгаа асуудлууд нь буцаад хууль, хяналтын байгууллагуудаар өөр шугамаар нотлогдох өөр үйл баримтууд бол бидэнд байсан. Тэгэхдээ энэ нь хянан шалгагчдын хүрээнд шалгах ийм асуудал бололцоогүй асуудлууд байсан. Тийм мэдээллүүд байсан.

**Г.Занданшатар:** Ням-Осорын Учрал. Ширнэнбандийн Адьшаа гишүүн тодруулж асууя.

**Ш.Адьяшаа:** Тэгэхлээр энэ төр хувийн хэвшлийнхний тухай Монгол Улсын хилээр ч хууль бус үйл ажиллагаа явуулаад, гаалийн бүрдүүлэлтгүй бусад ашиг сонирхлын үүднээс Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн асуудал энд хамаагүй юм байна л гэж ойлголоо. Тэгээд энэ Энхбаяр ер нь бол хатуухан хэлэхэд энэ сонсгол өөрсдийнхөө өрсөлдөгчдийг, сөрөг хүчнээ намнах том гэмт хэргийг дарах ийм л үйл ажиллагаа болсон шүү гэдгийг би хариуцлагатай хэлье. Цаг хугацаа үүнийг харуулна. Цаг хугацаа харуулна.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Түр хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн хариулна.

**Б.Энхбаяр:** Цаг хугацаагаар бол олон юм тодорхой болж байгаа, болсон.

Тухайлбал, Алтанхуягийн хамааруулж Дэнзэнгийн гэх 17 тэрбумын НАБТ-ын талбайн асуудал бол анх бол Адьяшаа гишүүнтэй холбоотой байсан юм билээ. Адьяшаа гишүүн тэрийгээ авч чадахгүй алдаад, тэгээд алдсандаа хорсоод холбогдох мэдээллийг тухайн үеийн сөрөг хүчин МАН-ынханд мэдээлэл дамжуулж, тэд нараар Дэнзэнг хусуулж, Батсуурийг хонгилоор чирүүлж явсан түүхтэй хүн байна лээ. Ер нь бол.

Сая энэ Түр хороог анх байгуулагдсан учир шалтгаан нь нүүрстэй холбоотой асуудал дээр нэлээн монопол болъё гэдэг байдлаар шантааж хэлбэрээр анх энэ Түр хороог санаачилж байгуулж байгаад мэхт мэхэндээ болчихсон ийм хүн юм байна лээ.

**Г.Занданшатар:** Ням-Осорын Учрал гишүүн. Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Өнөөдрийн Их Хурал, Засгийн газрын ажлуудаас энэ мэдэх эрхийг хангуулж байгаа олон санаачилга манлайллууд бас чухал ажилд тооцогдоно. Тэгэхээр үүнийг бас энэ Энхбаяр сайдын ахалсан Хянан шалгах түр хорооны бас сонсгол харууллаа. Тэгэхээр иргэдийн бас мэдэх эрхийг хангуулахад маш олон эх сурвалжуудын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож өгсөн. Би нэг зүйл дээр энэ сонсголын үеэр их эргэлзэж байсан. Үнэхээр энэ архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал үнэхээр сүйрчихсэн юм байна. Тэр жижиг “Тавантолгой” компани дээр байна. Зүгээр хэдхэн жилийн өмнө томилсон ТУЗ-ийнхөө даргыг томилсон шийдвэрээ олохгүй байна гээд л нэг ийм юм яриад байдаг. Тэгээд 3, 4 жилийн бүх бичиг баримт нь алга болчихсон, устгачихсан гэдэг нэг ийм л тайлбартай. Тэгэхээр Түр хорооны даргаас ер нь энэ сонсголын үеэр хэдий хэмжээний архив устчихаад байгаа юм бэ? Ийм дүгнэлт гарсан уу гэдэг зүйлийг бас асуумаар байна. Та энэ хянан шалгах сонсголын үеэр энэ шинжээч нар ч гэсэн



мэдээлэлд анализ хийгээд, дүгнэлт хийгээд гаргахдаа энэ бүртгэлийн багц хуулийн хүрээнд бий болсон энэ дээр түшиглэх шиг боллоо. Дээрээс нь энэ Засгийн газрын “5 Ш” ажиллагаа энэ shilen.gov.mn дээр байгаа мөр өгөгдлүүдээс бас ашиглах шиг боллоо. Тэгэхээр эдгээр ил тод болсон мэдээлэл дээр дүн шинжилгээ хийгээд, анализ хийгээд олон нийтэд ил болгож байгаа нь дэвшил үү гэвэл дэвшил.

Тэгэхээр өнөөдрийн яг Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулиар цахимаар үүссэн бичиг баримт нь цахимаар архивлагдаж болно гэдэг энэ концепц нь одоо хүртэл батлагдаагүй байсан учраас өнөөдрийн архивын энэ хуулийг хэн ч хөнддөггүй байсан юм байна лээ. Хэрвээ цахимаар үүссэн архив, цаасаар үүссэн архив хоорондоо зөрөх юм цаасыг нь барина гэдэг ийм хуультай. Тэгээд цахимаар явсан бичиг баримтуудыг хэвлээд, хадгалаад сейфт хийгээд байдаг. Тэгээд устчихсан гээд үүнийгээ нотлох баримт гэж дараа нь үздэггүй.

Тийм ч учраас сая энэ парламентаар тэр 109 хуулийг батлуулсан. Тэгээд энэ 109 хуулийн Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль дээр хэрвээ тухайн бичиг баримт цахимаар үүссэн бол цахимаараа л архивлагдана гэдгийг зөвшөөрч өгсөн анх удаа. Дижитал архив гэдэг ойлголтыг бий болгож байна шүү дээ.

Тэгэхээр цаасаар үүссэн баримт бичиг архив устаад алга болчихдог юм байж. Цахимаар үүссэн архив ул мөр нь үлддэг. Нэг ёсондоо хаанаас бичиг яваад хаана очоод хэн устах вэ гэдэг тод тэр ул мөр нь түүхтэйгээ үлдэж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ төрийн өмчийн компаниудыг чинь, энэ нээлттэй компаниудыг чинь засаглалыг нь сайжруулахын тулд энэ бичиг баримтууд нь энэ архив, албан хэрэг хөтлөлт нь бүхэлдээ цахим дээр суурилад одоо орчин үед бол тэр блокчэйн дээр

бүртгэлтэй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр хэн нэгэн улс төрч нөхөр орж ирээд тэр архивыг нь устгана гэж байхгүй.

Яагаад гэвэл устгалаа гэвэл хаашаа шилжсэн нь тодорхой. Жишээ нь Энхбаяр сайдын тэр дэд ажлын хэсгийн ахалсан тэр Улсын бүртгэлийн хууль дээр open data өнөөдөр тэр төрийн бус байгууллага хэний нэр дээр байгаад хэн рүү шилжсэн нь тэр цахим дээр гараад ирж байгаа биз дээ? Хэрвээ тэр open data байхгүй бол өнөөдрийн энэ шилэн систем нээгдээгүй цаашидаа магадгүй тэр төрийн бус хэнээс хаашаа шилжсэн нь байхгүй, өнөөдрийн эзэмшигч нь энэ байна гээд хэдэн цаас үзүүлэх л байхгүй юу. Тэгэхээр энэ өнөөдрийн энэ тогтоол дээрээ энэ дижитал архивыг бий болгооч гэдгийг бүүр тодорхой тусгаж өгмөөр байгаа юм. Тэгж байж цаашаа энэ цахим дээр нь ул мөр нь үлддэг тогтолцоо руу шилжихгүй бол бид дахиад л хэдэн жилийн дараа энэ чинь 21-р зуунд бичиг баримт устчихлаа гээд хээвнэг яриад сууж байдаг. Хэн ч устгасан нь тодорхойгүй ийм байдалтай байх юм бол цаашидаа энэ засаглал ярина гэдэг бол төвөгтэй.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Түр хороон дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Үнэхээр арван гурав, дөрвөн жилийн хугацааны үйл баримтуудыг шалгаж байгаа. Тэр дотроо маш их олон бичиг баримтууд бол ер нь устсан юм уу, зарим нь аман тайлбараар үер аваад явчихсан гэсэн шүү дээ. Бүүр говьд байгаа “Тавантолгой” компанийн хүн. Үерээр ингээд алга болчихсон гээд. Тэгээдтэр “Си” зөвшөөрөлтэй холбоотой 17 он хүртэлх баримтууд байхгүй, “Тавантолгой” компанийн худалдан авалтын баримтууд байхгүй, шийдвэрүүд байхгүй, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 2011 оны баримт байхгүй, 1213 оны худалдан

авах төлөвлөгөө байхгүй, 14-15 оны материал байхгүй. Сая хэлж байгаа тэр 5.2 сая тонн гаалийн хяналтын зөрүү. Тэр чинь одоо бол энэ НАБТ-ын талбайгаас гарч байгаа машин нүүний мэдээллүүд гэдэг маань яг байгаа хүрээндээ Хянан шалгах түр хороонд ирсэн нотлох баримтын хүрээнд шалгаад гарч байгаа тэр тоо баримт байгаа.

Тийм ч учраас хяналт шалгалтын явцад ер нь одоо энэ хяналт шалгалтаар энэ тайлан, мэдээллүүд гарвал энэ НАБТ-ын талбайнууд дээр байгаа тэр нүүний эх баримтуудыг бол ер нь устгах эрсдэлтэй юм байна лээ. Тийм учраас гаалийн байгууллагыг эрүүгийн цагдаагийн хяналт доор одоо байгаа нүүний тэр яг эх мэдээллүүдийг татаж авчирч битүүмжлэх ийм ажлуудыг хүртэл хийсэн. Энэ чинь айх юм байна шүү дээ ний нуугүй хэлэхэд. Одоо ингээд нотлох баримтаар ийм юмнууд ил боллоо гэнгүүт энэ чинь мэдчихсэн байна гээд л устгачих юм байна лээ. Тэр байтугай устгагдсан дата мэдээллүүдийг сэргээсэн. Тухайлбал, тэр бичлэгүүдийг сэргээх ажил бас хийлээ шүү дээ энэ чинь. Давхар энэ хяналт шалгалтын хүрээнд. Одоо энэ бол мэдээж хууль, хяналтын байгууллагуудын түрүүн бас гишүүд хэлээд байгаа энэ бол нэлээн удаан хугацааны том ер нь ажлууд болох юм байна лээ.

Хоёрдугаарт, ер нь, сүүлдээ бараг манай энэ хэдэн хянан шалгагч, шинжээч нар маань бараг нүүрс хулгайлчихсан юм шиг болгох гэж байна лээ шүү зарим нөхдүүд. Бараг хянан шалгасан, энэ шударга ажилласан хүмүүс сүүлдээ буруутах ч юм шиг, буруутай ч юм шиг ийм ажлыг бол зохион байгуулах юмнууд сонсогдоод байгаа юм. Би бол сонсголын өмнө ч гэсэн хэлж байсан энэ тусгай алба дээр ажиллаж байсан удирдах албан тушаалтны хүмүүс хүртэл нөлөөллөө татаарай гэж. Ийм юм гарсан учраас би хэлж байсан юм. Янз янзын байдлаар энэ нөлөөлөх гэж үзсэн. Тийм учраас энэ цаашиа таны хэлсэнчлэн

архивыг, хөтлөлтийн ер нь төрийн бүх байгууллагуудаар, энэ төрийн өмчийн компаниуд дээр энэ нүүрс тэй холбоотой юман дээр маш сайн цэгцлэх ийм шаардлагатай. Таны хэлсэн энэ цахимжуулалттай холбоотой асуудлыг бас тэмдэглэлээр, энэ тогтоотой хамт ер нь нүүрс тээврийн компаниуд, НАБТ-ын талбайнуудад үүрэг болгох учиртай юм байна лээ. Тэгэхгүй бол энэ цахимаар байдаггүй. Таны хэлж байгаа үнэн. Үүнтэй холбоотой шалгах гэхээр эх баримтыг үзнэ гэнгүүтээ нэг их том склад зааж байгаа байхгүй юу. Ингээд шалгачих гээд. Хэдэн сая тонн ингээд ямар ч эмх цэгцгүйгээр тэндээ овоолчихсон. Зориуд тийм байдлаар овоолчихсон. Тэгээд нүүрс борлуулалтын гэрээ юу болж байна гэхээр ингээд эндээс үз

**Г.Занданшатар:** Ням-Осорын Учрал гишүүн, сайд тодруулъя.

**Н.Учрал:** Энэ тогтоол дээр тэр Бүртгэлийн хуулийг та бид нар тэр тухайн үед хэлэлцэж байхад хараат бус, кодлогдсон технологид суурилсан хэлбэрээр бүртгэнэ гэдэг үг. Энэ Эстонийн Архивын хуульд тэгж байдаг юм байна лээ. Төрийн албан хэрэг хөтлөлт, дээрээс нь энэ төрийн өмчийн компаниудын бичиг хэрэг хөтлөлт, архив бол кодлогдсон, хараат бус технологид бүртгэгдэнэ гэж. Тэгээд хэн ч түүнийг оролдоггүй, ул мөр устдаггүй. Тийм учраас ул мөрөө устгах ямар ч бололцоог цаашидаа энэ ирээдүйд үүсэх эрсдэлээс сэргийлж энэ хуульд хийж өгөөч ээ. Энэ “Эрдэнэс Тавантолгой компани ч бай, жижиг “Тавантолгой” компани ч бай энэ чинь ашиг орлоготой компаниуд шүү дээ. Энд хэдэн төгрөг зараад, дижитал архиваа үүсгэж байж цаашиа ирээдүйд итгэх итгэл үнэмшлийг нийгэмд төрүүлэх болов уу. Тийм учраас энэ тогтоол дээрээ оруулж өгөөч л гэж би хүсэх гээд байна.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Түр хороон дарга хариулъя.

**Б.Энхбаяр:** Тийм. Энэ ер нь цахим архивтай болох нээлттэй болох асуудал их чухал. Одоо бидний open data бол хуулийн этгээдийн одоо үүсгэн байгуулагч, эцсийн өмчлөгчтэй холбоотой мэдээлэл бол ил байгаа. Энэ хуулийн этгээдийг анх хэн үүсгэн байгуулсан, явц дунд нь яаж нүүдэл суудал хийж сольж, хольсон гэдэг нь бол нээлттэй мэдээлэл дээр цахимаар байдаггүй. Тийм учраас бид цаасан суурьтай улсын бүртгэлийн лавлагаагаар 10 жилийн өмнө, 5 жилийн өмнө, жилийн өмнө бүртгэлээ яаж солив гэдэг мэдээллүүдийг авч, түүнийгээ нотлох баримтаар илчилж, ашиглаж байсан. Ер нь нэг зүйл их тодорхой харагдсан нь яг жилийн өмнөх ард иргэдийн нүүрсний хулгайг эсэргүүцсэн жагсаалын дараа маш олон нүүрсний компани улс төрийн нөлөө бүхий этгээдүүд бүртгэлийн мэдээллээ өөрчилж, зүсээ хувиргах ажил хийсэн байсан.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Хяналт шалгалтын түр хороо тайлангаа танилцуулж байна. Энэ ер нь нүүрсний хулгай Монголын түүхэнд ер нь хамгийн их хор хохиролтой ийм хулгайгаар тэмдэглэгдэх байх. Үүнээс илүү их хохиролтой хэрэг ер нь цаашид гарах ч боломжгүй гэж үзэж байна. Тэгэхээр энэ Хяналт шалгалтын хууль бас үр дүнгээ өгч байна. Улсын Их Хурал 2023 оныг авлигатай тэмцэх жилд анхаарлаа хандуулж ажилласан. Ганболд даргаар ахлуулсан Хянан шалгах түр хороо, дараа нь Энхбаяр даргаар ахлуулсан, мөн манай Нямбаатар өмнөх сайд, одоогийн Энхбаяр сайд гээд ингээд үе үеийн Хянан шалгах хорооны дарга болоод Хууль зүйн сайд нар, энд сууж байгаа олон арван шинжээч нар маш олон цаг өдөр, шөнөгүй, нойр хоолгүй олон мянган

хавтаст хэрэг дээр ингээж ажиллаж өнгөрсөн энэ 10 гаруй жилийн хугацааны энэ хулгай луйврыг илрүүлж, ард түмнийг энэ мэдэх эрхийг хангаж ажилласан нь энэ Хяналт шалгалтын түр хорооны бас үүрэг, зорилгоо биелүүлсэн байна гэж ингээж хэлж байна.

Нөгөө талаар энэ дотоод аудиттай л байх ёстой. Хөндлөнгийн төрийн аудит байгаа. Энэ хяналт шалгалтын байгууллагууд ер нь энэ хугацаанд хэрхэн яаж ажилласан юм бэ? Хяналт шалгалтыг хэрхэн яаж хийж байсан юм бэ? Энэ тайлан дүнгээ хаана танилцуулж байсан юм бэ? Хяналт шалгалтынх нь үр дүнгээр ямар арга хэмжээ авч байсан юм бэ? Үүнийг бас Хяналт шалгалтын түр хороо ер нь эргэж харж үзсэн үү, үгүй юү?

Хоёрт, 44 их наядын хохирол учирсан гэж ярьсан яриа юу болсон бэ? Энэ худлаа болж таарсан уу? Хэр бодитой, үндэслэлтэй тооцоо вэ? Энэ асуудлыг гаргаж ирсэн энэ улс төрч нар нь энэ яриагаа нотолж чадсан уу? Тэгэхээр хэдүүлээ одоо нэг тоотой болмоор байна. Хяналт шалгалтын түр хороо тайлангаа тавьж байгаатай холбогдуулж өнгөрсөн энэ хугацаанд яг хэдэн сая тонн нүүрсийг энэ 2 компани дээрээс алдсан гэж гарч ирж байгаа вэ? Үүний үр дүнд хэчнээн тэрбум, их наяд төгрөгийн хохирол улсад учирсан гэж үзэж байгаа вэ? Үүнийг нэг тоо гарсан уу, үгүй юү? Нэг хэлж өгөөч. Тоотой болмоор байх юм. Янз бүрийн л юм ярих юм.

Гуравд, өнөөдөр энэ Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг янз бүрээр л тайлбарлаад л, эсэргүүцээд л, шүүмжлээд л ингээд явж байна. Дэмжээд л. Яг энэ нүүрсний хулгайны ард дээр энэ хөрөнгө оруулалтын хууль орж ирж байгаа учраас нүүрсний хулгайны энэ сонсголоор энэ Өмнөговь гэдэг энэ аймагт чинь үндсэндээ бараг Монголын газар нутаг гээд байх юм бараг үндсэндээ байхгүй болсон нь

тогтоогдсон учраас газраар яаж дургиж байсан бэ, наргиж байсан бэ, яаж хууль зөрчиж байсан бэ гэдэг нь ил тод болсон учраас ард түмэн энэ Хөрөнгө оруулалтын хууль дээр газрын асуудал их эмзэг байгаа юм шиг надад санагдсан.

Тийм учраас энэ тайлантай холбогдуулаад Улсын Их Хурлаас тогтоол гарах юм байна. Тогтоол гарах юм байна. Хяналт шалгалтын тайлангаа тавьчихлаа. Энэ бол нэг л хэсэг нь. Асуудал дуусаагүй байн. Маши олон хариуцлагын арга хэмжээг ард түмэн нэхэж байна. Хариуцлагын арга хэмжээ. Энэ олон хор хохирол учруулсан, хулгай луйвар хийсэн, завхсан, үгссэн, сүлжээ бий болгосон энэ нөхдүүдэд одоо энэ асуудлууд хууль, хяналтын байгууллага руу шилжинэ. Хэрхэн яаж хууль хяналтын байгууллагууд энэ асуудал дээр хандаж, ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуудал ард түмэн хүлээлт.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Түр хорооны дарга, Хянан шалгах түр хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр хариулна.

**Б.Энхбаяр:** Тийм ээ, Сандаг-Очир гишүүнээ. Улсын Их Хурал буюу ард түмний төлөөллийн байгууллага үүргээ гүйцэтгэсэн. Ард түмний мэдэх эрхийг хангасан. Хууль, хяналтын ч байгууллагын урьд өмнө шалгаж тогтоогдоогүй маш олон асуудлуудыг нотлох баримтаар нотолж, ил болгосон. Одоо ард түмэнтэй хамт та ч тэр, би ч тэр хуулийн байгууллага руу нүдээ чилээж байна. 3 сая ард түмний 6 сая нүд, 6 сая чих сонссон. Юу болов гэдгийг. Одоо 6 сая нүд, чих хууль, хяналтын байгууллагууд руу харж байгаа. Өнөөдөр энэ тайланг сонсож үзсэн хууль хяналтын байгууллагын шударга албан хаагчид бүгд дор бүрнээ бас дүгнэлт хийж байгаа байх. Олон хэргүүд өмнө нь улс төрийн дээд түвшний оролцоо, хууль,

хяналтын байгууллагын дээд түвшний нөлөөлөлтэйгөөр хэрэгсэхгүй болгож, шалгагдахгүй өнгөрч байсан байна лээ. Одоо Улсын Их Хурлын хяналт шалгалтаар нэгэнт бүх ард түмэнтэйгээ цуг зурагтаар ил болчихсон асуудал дээр тэд тэгэх боломжгүй болгосон. Энэ бол сонсголын үр дүн.

Үр дүн чинь хаана байна вэ гэж асуугаад байгаа юм? Үр дүн чинь энэ байхгүй юу. Тэгэхгүйгээр Улсын Их Хурал өөрөө энэ хүнд ял өгдөг газар биш. Тэгвэл Үндсэн хууль зөрчигдөнө, эрх мэдэл хуваарилах зарчим алдагдана. Ард түмэн мэдэх эрхээ Улсын Их Хурал хангах тэр үүргээ гүйцэтгэсэн. Хууль, хяналтын байгууллага ажиллах ёстой. Харна. Би Хууль зүйн сайдын хувьд ч харна. Тэрнээс биш би нөлөөлөхгүй, тэрийг нь шалга, энийг нь барь, энийг нь битгий шалга гэж би нөлөөлөхгүй. Мөрдөн шалгах ажиллагаанд хэнбугай ч хөндлөнгөөс оролцдог, нөлөөлдөг. Энэ байдлын эсрэг харин миний бие сайдаар томилогдсоноос хойш анхнаасаа хатуу байр суурьтай байгаа. Тэр байтугай мөрдөн байцаалтын нууцыг задруулж ил болгодог энэ асуудал дээр ч хатуу байр суурьтай сая ялын шийтгэлийнх нь бодлогыг нь Улсын Их Хурал дэмжиж, чангалсан байгаа. Чангасан байгаа.

Яагаад? Нүүрсний сонсохлоор олон асуудлууд ил болсон. Өөрийнх нь хулгай нь илрэнгүүт гөлөг төөрүүлдэг, захиалгаар мөнгө өгдөг ийм асуудлууд ч илчлэгдсэн. Ард түмний нүд сэрсэн. Үүний цаана маш их мөнгө эргэлдэж байгаа нь тодорхой болсон. Тэгэхдээ үнэн үгүйсгэгддэггүй байхгүй юу. Би маш олон хууль, хяналтын байгууллагад ажиллаж байгаа хууль сахиулагчдаа хандаж уриалмаар байгаа юм. Та бүхэн маань Монголын ард түмний энэ итгэлийг бөхөөх ажлыг битгий хийгээрэй. Хууль бус үүрэг даалгавар өгч байгаа, үүнийг хаацайлах гэж байгаа дарга нарынхаа асуудлыг харин эсэргүүцээрэй. Түр хорооны ажиллуулсан

*sonsgol.mn хаяг цаашид ажиллана. Ийм дарга нарын мэдээллийг бас ирүүлээрэй.*

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулна.

**Ц.Сандаг-Очир:** Хоёр дахь асуултад бас хариулж өгөөрэй.

Нөгөө талаар та бид нар сая Эрүүгийн хуульд албан тушаалыг ийм төрд оногдуулах ялын бодлогыг чангалсан. Гэхдээ хууль эргэж үйлчилдэггүй. Тийм учраас энэ өнөөдөр хариуцлага алдсан, эрүүгийн үйлдэл хийсэн энэ улсууд чинь өнөөдөр нөгөө өмнөх хөнгөн ял олгогддог энэ тухайн үеийн хүчин төгөлдөр байсан хуулиараа шийтгэгдэх байх. Тэгэхээр өршөөлд хамрагдана, тэгэхээр хялбаршуулсан журмаар шийдэгдэнэ, тэгэхээр хөнгөн ял авна гэдэг ийм байдлыг бас ард түмэнд бас зөвөөр нь ойлгуул. Тэгэхгүй бол нөгөө л хууль чангалсан гээд байсан та нар хаа байна гэдэг асуудлыг бас ярих байх. Үүн дээр нэг бас хариулж өгөөч.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Хянан шалгалт түр хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд.

**Б.Энхбаяр:** Яг хэдэн төгрөгийн хулгай болчихоо вэ тоо хэлээч гээд байгаа юм. Би тоо хэлж чадашгүй юм. Яагаад гэхээр тоог бас нотлох гээд 40 гэж ярьсан Доржханд гишүүн 40-өө нотолж чадаагүй. 400 гэж уянгын халил хийсэн Ганбаатар гишүүн маань шараа болсон. Энэ сошиалд явж байсан юм гэж авсан юм. Сүүлдээ сураг ажгаар би ярьж байхаар нь ярьчихсан юм. Тэгэхээр энэ сонсголтой хамт сураг ажгаар ярьдаг улс төрч нар ч илчлэгдсэн бас. Сураг ажгаар ярьж энэ ард түмнийг үймүүлж, тоо томшгүй тоо ярьж, худлаа үнэн тэрийгээ нотолж чадахгүй улс төрждөг асуудал ч илчлэгдсэн бас. Тэгээд саяын хэлсэнчлэн 25 хувийг нь шалгахад 5.2 сая тонн гэж гарч ирж байгаа байхгүй юу. Маш олон.../минут дуусав./

**Г.Занданшатар:** Гүйцээж хариулъя. Баттөмөрийн Энхбаяр Түр хороон дарга гүйцээж хариулъя.

**Б.Энхбаяр:** Энэ чинь нөгөө маш олон баримтуудаа устгачихсан, ирүүлээгүй ийм асуудлууд байгаа. Тэгээд нөгөө талаар би 2 сувагтай хэлээд байна шүү дээ. Нөгөө талаар дахиад өөр байдлаар шалгаж, нотлох ийм асуудлууд бас байгаад байгаа гэж. Ингэж байж энэ таны хэлж байгаа буюу хууль, хяналтын байгууллагуудын цаашид хийх ажил байгаад байгаа байхгүй юу. Үүнийг нотлох. Тухайлбал, одоо тэр энд сонсгол дээр дурдагдсан компаниуд үгүйсгээд байгаа, манай шинжээчдийг буруутгаад байгаа, худлаа ярьчихсан юм, худлаа тоо байна гээд яриад байгаа асуудал нь манай шинжээчдийн цаасаар биш өөр байгууллагын ажлаар шалгаж, нотлогдох тийм асуудлууд байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас би энэ хууль, хяналтын байгууллагуудын ажил байна гэж яриад байгаа нь энэ юм. Тэрийг нь болохоор би дэлгэрэнгүй хийж чадахгүй байгаад байна л даа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Дамдины Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ гэсэн. Энэ хооронд ирцээ бүрдүүлээд, санал хураалтад бэлдье. Цогтбаатар гишүүнийг байхгүй гээд хасчихсан юм.

Энэ асуулт, хариулт, үг хэлсний дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд явуулъя.

**Д.Цогтбаатар:** Энэ дээр, ер нь энэ үнэхээр энэ хяналтын сонсгол хийх ач холбогдол үүн дээр гарсан. Энхбаяр гишүүн хүнд ачаа үүрсэн. Энэ ажлыг хийсэн хүн үүний ард магтаалтай гарна гэж байхгүй. Энэ үнэхээр хэцүү. Тэгэхдээ энэ сонсгол явагдахад бас анхаарах юмнууд яг жишээлбэл Хууль зүйн байнгын хорооны зүгээс анхаарах юмнууд харагдаж байна. Үүнийг бид нар цаашаа боловсронгуй болгохгүй бол Хууль зүйн

сайдын үед Энхбаяр даргаа бас бодууштай юм байна.

Юу гэвэл эрх мэдэлтнүүд аливаа хэргийг эхлүүлэхгүй бариад, хаагаад байгаа тохиолдолд энэ Улсын Их Хурал дээр энэ хяналт шалгалтын процессыг эхлүүлээд, тэгээд яалт ч үгүй энэ хуулийн процессыг зогсоогоод байгаа хүмүүсийн тэр чагтыг авч байгаад процессыг эхлүүлэх нь аягүй чухал. Тэгэхийн тулд ийм сонсгол бол хийж болж байгаа юм. Харин хуулийн процесс эхэлчихсэн байхад хууль, хяналтын байгууллагын процесс эхэлчхээд байхад үүнийгээ ингээд давхар хийх бол нөгөө шүүх байгууллага, хууль, хяналтын байгууллагуудын хараат бус байдалд энэ улсад байгаа улс төрийн хамгийн том нөлөө бүхий байгууллага үүнийг авч хэлэлцсэний дараа нөлөөлөөгүй гэж хэлэхэд хэцүү болчих юм байна лээ.

Тэгэхлээр үүн дээрээ бид нар илүү нарийвчилж, энэ системээ боловсронгуй, энэ бол өөрөө давшил. Угаасаа энэ чинь амьдрал дээр нотлогдож байж юмаа сайжруулж байх ёстой. Үүнийгээ бол бид нар бас харж хийгүүштэй юм байна лээ. Яг тийм учраас Энхбаяр сайдад сая гараад байгаа хүндрэлүүд амьдрал дээр гарсан байхгүй юу. Эргээд зөндөө улсууд үгүй энэ чинь энд яригдаж байгаа зүйл энд яригдах уу, үгүй юү гээд л өчнөөн хэрүүл маргаан гараад байгаа чинь үүнтэй бас холбоотой.

Нөгөө талаас би Энхбаяр сайдад нэг зүйл дээр талархал илэрхийлмээр байна. Хууль зүйн байнгын хороон дарга байхад нь би утааны сонсгол хийе, одоо утаа байхгүй байхад утаа гарахгүй юм шигээр бид нар ингээд мартчихаад яваад байна гээд утааны сонсголын хүсэлтийг тавьсан. Сая яг энэ сонсголынхоо хүрээнд харин утааны сонсголыг оруулж ирээд сонсчихлоо доо. Тэн дээр бас дутахааргүй их нүгэл, дутагдал байгаа нь харагдсан шүү. Энэ сонсголын давуу тал ингээд ерөөсөө заримдаа хүмүүсийн нүдэнд ажиглагдахгүй. Жишээлбэл, энэ

Тавантолгой бол маш том төсөл байхгүй юу. Тэгтэл тэрний хажууд хамаагүй жижиг төсөл дээр ямар том зөрчлүүд байж байгаа нь эндээс харагдаж байгаа юм. Тэгээд Энхбаяр сайдаас би сүүлд нь ганц асуулт асууя. Та одоо энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нэгийг ч нэмж байгуулахгүй хориг тавих санал дээр өөрөө гарын үсэг зурсан хүн. Бид нарын энэ хийсэн санаачилга зөв гэдгийг та сая энэ сонсголоороо өөрөө бодит байдал дээр мэдэрч авсан байх. Энэ хулгай, энэ зөрчил төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд ийм том байхад хэзээ ч зогсохгүй. Үүнийг ядаад хязгаарлаж энэ мараторын тавьж тоог нь хязгаарлахгүй бол энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээр дамжуулж юм хийнэ, нийгмийн асуудлыг шийднэ гэдэг бол шууд сэтгэлгээг засахгүйгээр энэ асуудлыг шийдэхгүй шүү. Би энийг л хэлээд байгаа. Хэчнээн олон хүнийг шоронд хийгээд энэ бүтэхгүй систем байж байхад дараа нь олон аавын хүүхдийг дахиад шоронд хийх хэрэг л гарна.

Тэгэхлээр энэ дээр миний асуулт та үүн дээр бүрэн итгэлээ олж авав уу тэр тогтоолын төслийг санаачилсан хүний хувьд? Тэрийг асуух гэсэн юм.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Түр хороон дарга. Дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхимд.

**Б.Энхбаяр:** Тийм ээ, Цогтбаатар гишүүн маань санаачлаад энэ ер нь төрд өмч байгаа цагт хулгай тасрахгүй юм байна. Ялангуяа энэ төрийн өмчийн компани байгуулагдаад л байвал хулгай гэхээсээ гадна ерөөсөө энэ зах зээлийн хувийн хэвшилээ чөлөөт эдийн засгаа нухчин дарсан ийм асуудал руу явах нь гээд төрийн өмчийн компани шинээр нэгийг ч байгуулахгүй байх тогтоолын төслийг хамтарч санаачлах уу гээд. Тэгээд би бас дэмжиж Цогтбаатар гишүүнтэй хамт энэ санаачилга дээр хамт явж байгаа. Энэ итгэл үнэмшил

маань улам батжиж байгаа. Батжихаас гадна ер нь сүүлийн хэдэн жил хулгай л ярилаа. Яриад л байх юм. Цаашидаа яах юм бэ гэдэг дээр улс төрийн хамгийн дээд шийдвэр гаргагч Улсын Их Хурал хариугаа өгөх ёстой.

Тийм ч учраас зөвхөн энэ сонсгол юмнууд энэ ил болгосон төдийгөөр 2020 оны Улсын Их Хурал дараагийн Улсын Их Хуралд халаагаа өгөх учиргүй гэж үзэж байгаа. Тийм ч учраас миний бие Улсын Их Хурал дээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн ажлын хэсгийг ахалж ажиллаж байсан. Сая Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдоод энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн баригдсан хувилбарыг нь дахин сайжруулах, боловсронгуй болгох, санал, дүгнэлт хэлэх ажлын хэсгийг би энэ нүүрсний хулгайг шалгаж байх явцдаа давхар ажиллуулж байсан. Энэ ажлын хэсэг санал, дүгнэлтээ мөн гаргасан.

Өөрөөр хэлбэл, бид хулгай байгааг мэдсэн бол, асуудал хаана байгааг оношилсон юм бол цаашид үүнийг төрийн өмч дээр хязгаарлах, Улсын Их Хурал, Засгийн гаазр. ТҮЗ, гүйцэтгэх удирдлагууд цаашид ямар хүрээ рамын дотор шийдвэрүүд гаргадаг байх, тэр хэрээр хариуцлагаа үүрдэг байх хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах саналын томъёоллыг бэлтгэж дууссан байгааг эрхэм гишүүддээ танилцуулъя.

Одоо чуулган хаагдангуут Улсын Их Хурлынхаа ажлын хэсэгт танилцуулаад, энэхүү саналын томъёоллоо Улсын Их Хурлын дарга, даргын зөвлөлийн гишүүд зөвшөөрвөл Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах хүсэл, эрмэлзэлтэй байгаа гэдгийгээ бас та бүхэндээ хэлье. Энэ хуулийн төсөл дээр сая олон удаагийн

сүүлийн 2, 3 жилийн турш ярьсан энэ өмч газар, хувьцаа, ТҮЗ, гүйцэтгэх удирдлага, Улсын Их Хурал, Засгийн газар, сайд, бүх түвшиний шийдвэр гаргалттай холбоотой хууль, хяналт зохицуулалтыг сайжруулах чиглэлд саналын томъёоллыг бэлтгэсэн байгаа. Би бас гишүүддээ, ажлын хэсэгтээ, Эдийн засгийн байнгын хорооныхоо гишүүдэд чуулганы завсарлагааны хугацаанд энэ асуудлыг нэг бүрчлэн танилцуулж, бас хичээж ажиллана. Та бүхэн бас дэмжиж ажиллахыг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Батиугар гишүүн, Учрал гишүүн, Ганхуяг гишүүн санал хураалтдаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” хувьцаат компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулна. Санал хураалт.

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 56.8-д Түр хороо тайлан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулснаар уг хороог татан буугдсанд тооцно гэж заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг

мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо татан буугдсанд тооцлоо.

Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 38.1-д заасны дагуу заасан хугацаанд Түр хороо ажиллаж, тайлангаа Улсын Их Хуралд танилцуулснаар, холбогдох шийдвэрийг гаргаснаар татан буугдсанд тооцно гэж заасны дагуу Хяналт шалгалтын түр хороогоо ард түмний мэдэх эрхийг хангаж, парламентын хяналт шалгалтын бүрэн эрхийг хэрэгжүүлж, ард түмний мэдэх эрхийг хангасан энэ нотлох баримтуудаа хууль, хяналтын байгууллагуудад шилжүүлсэн байна.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын түр хороо нээлттэй сонсгол бол шүүх хурал биш, яллах, цагаатгах талыг баримтлах биш, нотлох баримтыг шинжлэн судлаад хууль, хяналтын байгууллагуудад шилжүүлсэн. Ингээд хууль, хяналтын байгууллагууд энэ асуудлыг нягтлан судалж, яллах, цагаатгах талаа баримталж, хариуг Улсын Их Хуралд эргэж мэдүүлэх үүрэгтэй. Ингээд Хянан шалгалтын түр хороо татан буугдсанд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

21.17 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ